2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 05 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн ирц хүрсэн байна.

Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

55,6 хувьтай, 57,1 хувьтай ирц хүрсэн тул чуулганы хуралдааныг эхлүүлэе.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 08 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар дараах 8 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт, Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Нийт 14 төсөл байгаа.

2 дугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 4 дэх хэлэлцүүлгийг хийнэ.

3 дугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ.

4 дүгээрт, ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

5 дугаарт, “Монгол Улсын Их 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг

хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

6 дугаарт, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

7 дугаарт, Баталсан хууль, тогтоолын төслийн эцсийн найруулгыг сонсоно.

8 дугаарт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы хаалт хийгдэнэ.

Ингээд 8 асуудал хэлэлцэхээр байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

**Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална.**

#### Нийт 14 төсөл байгаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д 7 хоногийн Баасан гарагийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулна. Хуралдааны ирц хуулийн төсөлд эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно

гэж заасны дагуу Байнгын хороо хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж эхэлнэ.

Ирц 83 гишүүн ирцэд бүртгэгдсэн байна.

Ирц, төстийн санал хураалтыг явуулъя гэж бодож байна.

Түүнээс өмнө бас Парисын 2024 оны зуны 17 дугаар пара олимпын наадам өчигдөр эхэлсэн байгаа. 168 орны 4400 гаруй тамирчин спортын 22 төрөлд өрсөлдөж байгаа юм. Тус наадамд манай улсаас спортын 6 төрөлд 12 тамирчин оролцож байгаа. Өнөөдөр өглөө таеквондогийн эмэгтэйчүүдийн -52 кг-ын жинд хүч сорьсон Завхан аймгийн Тосонцэнгэл сумын харьяат, ОУХМ, 2023 оны ДАШТ-ий хүрэл медальт, Ази тивийн аварга Уламбаярын Сүрэнжав аваргаар шалгарсан байна.

Парис 2024 Пара олимпын анхны алтан медалийг эх орондоо авчирсан Уламбаярын Сүрэнжавтаа Улсын Их Хурлын нийт гишүүд, Монгол Улсын нийт ард иргэдийнхээ өмнөөс баяр хүргэе. Спортынх нь ажилд амжилт хүсье.

Өнөөдөр чуулганы хуралдааны санал хураалтын ажлаа эхлүүлье.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа.

Тийм учраас нийт гишүүдийн олонх буюу 64 гишүүн дэмжсэнээр хууль, тогтоолууд эцэслэн батлагдана.

Ингээд санал хураалтыг эхлүүлье.

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

68 гишүүн буюу 77,3 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

66 гишүүн буюу 74,2 хувиар санал дэмжигдлээ.

3. Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

75,8 хувь 69 гишүүн дэмжлээ.

**Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:**

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

73 гишүүн дэмжиж, 80,2 хувиар санал дэмжигдлээ. Эцэслэн батлагдлаа.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл

хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

72 гишүүн дэмжсэн. 79,1 хувиар санал дэмжигдлээ.

3. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

72 гишүүн буюу 79,1 хувиар санал дэмжигдлээ.

4. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

76 гишүүн буюу 81,7 хувиар санал дэмжигдлээ.

5. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

72 гишүүн буюу 77,4 хувиар санал дэмжигдлээ.

6. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

77 гишүүн буюу 82,8 хувиар санал дэмжигдлээ.

7. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

72 гишүүн буюу 76,6 хувиар санал дэмжигдлээ.

8. Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

78 гишүүн буюу 82,1 хувиар санал дэмжигдлээ.

9. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

79 гишүүн буюу 83,2 хувиар санал дэмжигдлээ.

10. “Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

61 гишүүн санал дэмжиж өгснөөр уналаа, тийм ээ. Эцэслэн батлагдсангүй.

Төхөөрөмж ажиллахгүй байна гэдэг шалтгаан хүлээж авахаар бас Улсын Их Хурлын гишүүд шүүмжлээд байгаа. Тэгээд бодитой горимын саналаа л гаргасан нь зөв.

Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац ...

Ердийн олонхоор асуудал шийдэгдэх юм байна, тогтоол учраас.

Тэгээд Баатархүү сайд ер нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайд төхөөрөмжтэйгөө жоохон харилцаж чадахгүй л байх шиг байна. Олон санал дээр эсрэг гараад байгаа шүү, анхаарна биз.

10 дахь санал Төрийн өмчөөс нийслэлийн өмчид шилжүүлэх тухай тогтоолын төсөл 61 гишүүн дэмжсэнээр 64,2 хувиар дэмжигдлээ.

11. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

70 гишүүн буюу 73,7 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд хууль, тогтоолын төслүүд эцэслэн батлагдала.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийнхэнд талархал дэвшүүлъя.

10.22 цаг

Хэлэлцэх асуудал 2.

**Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 4 дэх хэлэлцүүлэг эхлүүлъя.**

Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Бэлтрэгийн Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Чойжилсүрэнгийн Таванжил Сангийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга.

Байнгын хороо төсвийн төслүүдийг 4 дэх хэлэлцүүлэгт бэлтгэн гишүүдэд тараасан байгаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл заалт бүрийг уншиж, сонсгож, зүйл тус бүрээр нь санал хураалт явуулна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтыг явуулна.

60 гишүүн буюу 62,5 уу.

Уучлаарай. Энэ хэлэлцэх асуудлын дараалал дээр бас алдаа гарсан байна.

Энэ 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж, сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулна гэж түрүүн алга тогшсон байгаа.

Сая эцэслэн батлах санал хураалтыг болоогүй байхад нь хураалгаад ингээд 60 гишүүн санал өгснөөрөө.

Тэгэхээр энэ санал хураалтыг хүчингүй болгоод зүйл тус бүрээр нь уншиж танилцуулах шаардлагатай болж байна.

Ингээд **Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:**

“1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн

дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх

үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

**2/3 дугаар зүйл:**

“3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлого төвлөрүүлнэ:

<b>Д/д</b>	<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>	<b>Дүн /сая төгрөгөөр/</b>
1	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>185.0</b> 185.0
2	<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>100.0</b> 100.0
3	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b> Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>105,629.2</b> 101,200.0 4,429.2
4	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>510.0</b> 510.0
5	<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>2,737.7</b> 2,737.7
6	<b>Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>2,472.9</b> 2,472.9
7	<b>Монгол Улсын Шадар сайд</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>16,099.0</b> 16,099.0
8	<b>Монгол Улсын Шадар сайд</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>25.0</b> 25.0
9	<b>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>175.0</b> 175.0
10	<b>Гадаад харилцааны сайд</b> Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>6,000.0</b> 5,100.0 900.0
11	<b>Сангийн сайд</b> Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>18,784,694.9</b> 11,143,087.7 478,553.6 6,792,915.6 281,474.0 558,000.0 9,217.6
12	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b> Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар	<b>81,276.1</b> 45,000.0 2,700.0

	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	1,552.9
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	32,023.2
13	<b>Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд</b>	<b>360,261.8</b>
	Ашигт малтмал, газрын тосны газар	355,971.6
	Үндэсний геологийн алба	130.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,160.2
14	<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>38,185.4</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	38,185.4
15	<b>Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд</b>	<b>1,485.5</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,485.5
16	<b>Боловсролын сайд</b>	<b>5,857.9</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,857.9
17	<b>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>39,034.4</b>
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	850.0
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	2,535.1
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	35,649.3
18	<b>Зам, тээврийн сайд</b>	<b>105,656.0</b>
	Иргэний нисэхийн ерөнхий газар	80,000.0
	Зам, тээврийн яам	300.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	25,356.0
19	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>54,588.5</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	54,588.5
20	<b>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд</b>	<b>8,665.5</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,665.5
21	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>5,555.4</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,555.4

**3/5 дугаар зүйл:**

“5 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Сангийн сайд</b>	<b>487,311.2</b>
	Үүнээс: “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дүрмийн санд	83,673.5
2	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>20,600.7</b>
3	<b>Боловсролын сайд</b>	<b>30,000.0</b>
4	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>10,286.9</b>
5	<b>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>22,758.8</b>

**4/6 дугаар зүйл:**

“6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

6.1. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

<b>Д/д</b>	<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>	<b>Дүн /сая төгрөгөөр/</b>
1	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</b> Урсгал зардал	<b>30,283.9</b> 30,283.9
2	<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>142,182.7</b> 120,093.1 22,089.6
3	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>384,831.7</b> 311,552.3 73,279.5
4	<b>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга</b> Урсгал зардал	<b>4,510.2</b> 4,510.2
5	<b>Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>29,070.1</b> 17,541.3 11,528.8
6	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>171,153.6</b> 151,178.6 19,975.0
7	<b>Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга</b> Урсгал зардал	<b>5,571.7</b> 5,571.7
8	<b>Улсын ерөнхий прокурор</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>110,621.1</b> 99,272.8 11,348.3
9	<b>Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга</b> Урсгал зардал	<b>18,849.9</b> 18,849.9
10	<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>44,294.5</b> 43,413.4 881.1
11	<b>Авлигатай тэмцэх газрын дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>48,006.0</b> 45,347.9 2,658.2
12	<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>14,727.6</b> 13,835.1 892.5
13	<b>Төрийн албаны зөвлөлийн дарга</b> Урсгал зардал	<b>7,554.9</b> 7,554.9
14	<b>Үндэсний статистикийн хорооны дарга</b> Урсгал зардал	<b>21,784.5</b> 21,784.5
15	<b>Сонгуулийн ерөнхий хорооны дарга</b> Урсгал зардал	<b>73,210.6</b> 73,210.6
16	<b>Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга</b>	<b>8,314.6</b>



	<i>Урсгал зардал</i>	8,314.6
17	<b>Шүүхийн сахилгын хорооны дарга</b> <i>Урсгал зардал</i>	4,862.1 4,862.1
18	<b>Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	183,147.5 90,681.7 92,465.9
19	<b>Монгол Улсын Шадар сайд</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	363,931.8 255,364.4 108,567.4
20	<b>Монгол Улсын Шадар сайд</b> <i>Урсгал зардал</i>	5,143.1 5,143.1
21	<b>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	238,099.9 82,748.4 155,351.5
22	<b>Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга</b> <i>Урсгал зардал</i>	14,506.6 14,506.6
23	<b>Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	11,176.3 5,713.2 5,463.1
24	<b>Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга</b> <i>Хөрөнгийн зардал</i>	116,229.2 116,229.2
25	<b>Гадаад харилцааны сайд</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	207,047.1 193,347.1 13,700.0
26	<b>Сангийн сайд</b> <i>Урсгал зардал</i> үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт <i>Хөрөнгийн зардал</i> <i>Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</i>	5,594,295.3 2,533,689.1 1,173,620.2 293,606.2 2,767,000.0
27	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	1,406,724.4 1,279,536.7 127,187.7
28	<b>Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	61,794.3 21,794.3 40,000.0
29	<b>Батлан хамгаалахын сайд</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	613,066.5 557,285.9 55,780.7
30	<b>Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	240,267.2 219,729.5 20,537.7
31	<b>Боловсролын сайд</b> <i>Урсгал зардал</i> <i>Хөрөнгийн зардал</i>	4,150,472.6 3,427,417.7 723,054.9
32	<b>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	3,966,463.5

	Урсгал зардал	3,917,705.4
	Хөрөнгийн зардал	48,758.1
33	<b>Зам, тээврийн сайд</b>	<b>817,916.9</b>
	Урсгал зардал	24,320.3
	Хөрөнгийн зардал	793,596.6
34	<b>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд</b>	<b>575,318.0</b>
	Урсгал зардал	330,626.7
	Хөрөнгийн зардал	244,691.4
35	<b>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд</b>	<b>458,888.7</b>
	Урсгал зардал	45,105.8
	Хөрөнгийн зардал	413,783.0
36	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>676,018.0</b>
	Урсгал зардал	555,484.2
	Хөрөнгийн зардал	120,533.8
37	<b>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд</b>	<b>87,490.3</b>
	Урсгал зардал	71,067.3
	Хөрөнгийн зардал	16,423.0
38	<b>Эрчим хүчний сайд</b>	<b>468,184.1</b>
	Урсгал зардал	242,170.1
	Хөрөнгийн зардал	226,014.0
39	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>1,658,681.7</b>
	Урсгал зардал	1,376,042.7
	Хөрөнгийн зардал	282,639.0

6.2. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилт олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	127,778.2
2	Боловсролын сайд	31,036.3
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	50,285.5
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	5,000.0

5/16-18 дугаар зүйл:

“16 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	33,831.9
2	Баян-Өлгий	22,080.6
3	Баянхонгор	34,182.5
4	Булган	10,232.3
5	Говь-Алтай	26,065.0
6	Дундговь	18,195.6
7	Завхан	37,581.9
8	Өвөрхангай	27,680.8

9	Сүхбаатар	13,917.6
10	Төв	16,840.6
11	Увс	30,877.0
12	Ховд	12,982.1
13	Хөвсгөл	37,957.8
14	Хэнтий	38,777.6
15	Говьсүмбэр	6,836.4
<b>Нийт дүн</b>		<b>368,039.7</b>

17 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг, хот	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	11,773.8
2	Дорнод	2,619.1
3	Өмнөговь	1,419,975.6
4	Сэлэнгэ	2,308.0
5	Дархан-Уул	1,355.1
6	Улаанбаатар	19,590.5
7	Орхон	137,661.3
<b>Нийт дүн</b>		<b>1,595,283.5</b>

18 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг, хот	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	12,690.8
2	Баян-Өлгий	11,949.5
3	Баянхонгор	21,577.0
4	Булган	14,228.4
5	Говь-Алтай	17,357.4
6	Дорноговь	42,708.1
7	Дорнод	25,422.0
8	Дундговь	15,880.4
9	Завхан	14,700.7
10	Өвөрхангай	14,480.8
11	Өмнөговь	47,716.0
12	Сүхбаатар	18,215.7
13	Сэлэнгэ	27,768.4
14	Төв	28,366.8
15	Увс	13,069.0
16	Ховд	29,385.2
17	Хөвсгөл	16,739.1
18	Хэнтий	18,587.1

19	Дархан-Уул	20,763.4
20	Улаанбаатар	50,167.0
21	Орхон	34,710.3
22	Говьсүмбэр	7,000.3
<b>Нийт дүн</b>		<b>503,483.6</b>

Тодруулж 2 зүйл хэлэх шаардлагатай юм байна. Зам, тээврийн сайдын төвлөрүүлэх орлогын хэмжээ 105,656.0 сая. Үүн дотроо Иргэний нисэхийн ерөнхий газар 80 тэрбум. Зам, тээврийн яам 300 сая. Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 25 тэрбум 356 сая.

Мөн 37 дээр байгаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 87,490.3 сая. Урсгал зардал 71, 067.3 сая. Хөрөнгийн зардал 16,423.0 сая гэсэн зүйлийг тодруулж хэлье.

Говьсүмбэр аймгийн орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлэг 7 тэрбум 3 сая.

Ингээд санал хураалт явуулна. Санал хураалт.

77 гишүүн буюу 74 хувиар дэмжигдлээ.

2 дугаар зүйл. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2024 оны хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийг энэ хуулийн 1 дүгээр хавсралтаар өөрчлөн найруулсугай. Санал хураалт.

77 гишүүн буюу 74 хувиар санал дэмжигдлээ.

3 дугаар зүйл. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг энэ

хуулийн 2 дугаар хавсралтаар өөрчлөн найруулсугай. Санал хураалт.

75 гишүүн буюу 72,1 хувиар санал дэмжигдлээ.

4. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг энэ хуулийн 3 дугаар хавсралтаар өөрчлөн найруулсугай. Санал хураалт.

72 гишүүн буюу 69,2 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар зүйл. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “18,359,777.4” гэснийг “20,173,724.9” гэж, 7 дугаар зүйлийн “20,753,857.3” гэснийг “22,677,835.3” гэж, 8 дугаар зүйлийн “3,359,350.2” гэснийг “3,828,603.7” гэж, 10 дугаар зүйлийн “513,710.9” гэснийг “478,553.6” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “3,414,050.7” гэснийг “3,951,799.6” гэж, 12.2 дахь хэсгийн “1,225,000.0” гэснийг “2,209,000.0” гэж, 13 дугаар зүйлийн “3,286,546.7” гэснийг “1,940,399.6” гэж тус тус өөрчилсүгэй. Санал хураалт.

81 гишүүн буюу 77,9 хувиар санал дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай. Санал хураалт.

79 гишүүн буюу 76 хувиар санал дэмжигдлээ.

7 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт.

82 гишүүн буюу 78,8 хувиар дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтыг явуулж байна. Санал хураалт.

85 гишүүн буюу 81,7 хувиар эцэслэн батлагдлаа. Бүхэлдээ.

**Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн зүйл заалт тус бүрээр санал хураалт явуулна.**

1 дүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл.

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт.

11.1.Энэ хуулийн зорилт нь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, хуримтлал үүсгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санал хураалт.

84 гишүүн буюу 80,8 хувиар санал дэмжигдлээ.

2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж.

2.1.Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санал хураалт.

80 гишүүн буюу 76,9 хувиар санал дэмжигдлээ.

**2 дугаар бүлэг. Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн орлого.**

3 дугаар зүйл. Үндэсний баялгийн санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>499,529.2</b>
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	499,529.2
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2-т заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг	499,529.2
	Үүнээс: Хуримтлалын санд	499,529.2
2	<b>Сангийн сайд</b>	<b>788,968.7</b>
	Татварын ерөнхий газар	788,968.7
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 20 хувь	788,968.7
	Үүнээс: Ирээдүйн өв санд	788,968.7
	<b>Нийт орлого</b>	<b>1,288,497.9</b>

Санал хураалт.

77 гишүүн буюу 74 хувиар санал дэмжигдлээ.

4 дүгээр. 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2,788,332.7 сая төгрөг байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу Ирээдүйн өв санд 2024 оны төсвийн жилд 788,968.7 сая төгрөг хуримтлуулна.

5 дугаар зүйл.

Санал хураалт. Уучлаарай 4 дүгээр зүйл дээрээ санал хураалт.

83 гишүүн буюу 79,8 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээ 499,529.2 сая төгрөг. Санал хураалт.

78 гишүүн буюу 75 хувиар санал дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт.

82 гишүүн буюу 78,8 хувиар санал дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтыг явуулна.

82 гишүүн буюу 78,8 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүд батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Хэлэлцэх асуудал 3.

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Далайн Батбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын дэд хорооны дарга Далайн Батбаярыг индэрт урьж байна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаярыг индэрт урьж байна. Төсвийн зарлагын дэд хорооны дарга Далайн Батбаяр индэрт гарч танилцуулгаа унших хэрэгтэй.

Ажлын хэсгийг танилцуулж байя.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Эрдэнэбилигийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл ХЗДХ-ийн сайд, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд,

Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Чинбатын Номин Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Жадамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр ХХААХҮ-ийн сайд, Цэндийн Баатархүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Нямдэлэгийн Мандуул Нийслэлийн Засаг даргын I дүгээр орлогч, Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Лхагвын Цэдэвсүрэн ТАЗ-ийн дарга, Цэвээнсүрэнгийн Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга, Барсүрэнгийн Баасандорж Улсын Их Хурлын Тамгын газрын дарга нарийн бичгийн дарга, Максимын Чинбат Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, Бямбажавын Ганбат ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Түдэвийн Цэрэнбадрал СЗХ-ны дэд дарга, Даньхүүгийн Баянбилэг Монгол Улсын ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Цээхээгийн Адьяахишиг ХЭҮК-ын Тамгын газрын дарга, Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ СЕХ-ны Тамгын газрын дарга, Батцэнгэлийн Эрдэнэтулга ШЕЗ-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Заграагийн Баасанням АТГ-ын Тамгын дарга, Бямбасүрэнгийн Лхагва ҮСХ-ны Тамгын газрын дарга, Хөхөөгийн Отгонжаргал ҮАБЗ-ийн Санхүүгийн хэлтсийн дарга, Луттөмөрийн Очирсүрэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын Ажлын албаны дарга, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн

аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Лханаажавын Мөнхтүшиг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагийн Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Амарсайханы Хишигбаяр Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөр-Уянгын Жамбалцэрэн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Пуушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Идэшийн Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нансалын Тавинбэх ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Бэлтрэгийн Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Чойжилсүрэнгийн Таванжил Сангийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Рэгжийбуугийн Отгонжаргал ГЕГ-ын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны

Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Ванчингийн Рэнцэнханд Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга, Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Болдбаатарын Энхжин НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Хүүгийн Мөнхжаргал Эрдэнэс тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Галбадрахын Гантулга Эрдэнэс тавантолгой ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Зарлагын дэд хорооны дарга Далайн Батбаяр гишүүн ирсэн үү? Энэ сая энэ танилцуулга дээр даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч гэсэн их олон албан тушаал дурдагдаж байна. 9 сарын 1-нээс эхлээд ТАЗ-өөс Төрийн албаны хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор яам, агентлагт шалгалт орж эхэлнэ.

Тийм учраас Төрийн албаны хуулийн зөрчлийг дор бүрдээ арилгана. Шалгалтаар илэрсэн зөрчлийг нэн даруй арилгах шаардлагыг Улсын Их Хурлаас тавьж ажиллана гэдгийг үүгээр бас мэдэгдье.

Далайн Батбаяр гишүүнийг индэрт урьж байна.

**Д.Батбаяр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, 2 дахь хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороонд шилжүүлсэн болно.

Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж, төсвийн гүйцэтгэл болон Байнгын хороодын ирүүлсэн санал, дүгнэлтийг хэлэлцэн нэгтгэн гаргасан дүгнэлтээ та бүхэндээ танилцуулж байна.

Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, Улсын Их Хуралд ирүүлсэн дүгнэлтээрээ төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого болон тусламжийн дүнг 23 их наяд 294,9 тэрбум төгрөг, нийт зарлагыг 22 их наяд 509 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785,9 тэрбум төгрөгийн ашигтай буюу эерэг үзүүлэлттэй байгааг баталгаажуулсан.

Түүнчлэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд тусгасан эдийн засгийн үзүүлэлтүүдэд тухайн жилийн төсвийг батлахдаа өөрчлөлт оруулж байгаад анхаарал хандуулахыг толилуулсан байна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганзориг татвар төлөгчөөс татварыг үл барах журмаар хураан авч бүрдүүлсэн төсвийн орлогыг нөгөө талдаа улсын төсвөөс үр ашигтай захиран зарцуулж байгаа эсэх, төсвийн зардал нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа эсэх, үр ашиггүй урсгал зардлыг үе шаттай бууруулах арга хэмжээний талаар, зогсонги байгаа төсөл, хөтөлбөрийг дуусгах арга хэмжээний талаар, Монголбанкны болон Төрийн сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг тодорхой тусгах, хэрхэн оновчтой удирдах талаар, Улсын Их Хурлын гишүүн



Батжаргал Байнгын хороодын санал, дүгнэлтэд тусгасан саналыг нэгтгэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох, Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн эсэх талаар, гадаад зээл тусламжийн санхүүжилт 80 хувьтай байтал явц нь 40 хувьтай байгаа шалтгааны талаар, төсвийн байгууллагын болон Төрийн өмчит компаниудын өр, авлага нэмэгдсэнд шалтгааны талаар, ЭМД-ын сан алдагдалтай байхад өглөг нэмэгдсэн шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Заяабал уул уурхайн биржийн үйл ажиллагаа олон улсын жишигт нийцэж байгаа эсэх талаар, төсвийн байгууллагуудын одоогийн чиг үүрэг оновчтой байгаа эсэх, төсвийн нийт зардлын өсөлтөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэх, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөвлөлт зөв эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Баясгалан ЭМД-ын сангийн зарцуулалтад илэрсэн зөрчлийн талаар, төрийн албан хаагчийн цалингийн тогтолцоог олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх талаар, ажлын байрыг нэмэгдүүлэх татварын бодлогыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Төрийн өмчит компаниудын засаглал, менежментийг сайжруулах талаар баримталсан бодлогын талаар, хязгаарлалттай дүгнэлт авсан төсөв зарцуулагчдад авсан хариуцлагын талаар, эрүүл мэнд болон нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг Чингис хаан, Капитал банканд байршуулсан асуудлын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Баярмаа Аудитын байгууллагын гаргасан дүгнэлтээр төсвийн сахилга бат алдагдсан эсэх, татварын төлөгчдийн мөнгийг үр ашиггүй захиран зарцуулсан асуудлын талаар, гадаадын зээл, тусламжийг ашигласан төсвийн ерөнхийлөн захирагчид үр дүнгээ тайлагнадаггүй талаар, концессын эргэн төлөлт, хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Батбаяр Улсын Их Хурлын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 2023 оны 07 дугаар сарын 07-ны

өдрийн Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан албан бичгээр Монгол Улсын 2022 оны гүйцэтгэлтэй холбогдуулан сөрөг буюу хязгаарлалттай төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохих арга хэмжээ авсан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Дэд хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа төсвийн захирагч нар дахин алдаа дутагдал гаргахгүй байхыг анхаарах, эрүүл мэнд болон нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг арилжааны банканд байршуулсан асуудлыг түргэн шийдвэрлэх, активын удирдлагын болон дотоод аудитын чиглэлийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, улсын болон орон нутгийн төсвөөр баригдаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Заяабал Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төсөл, хөтөлбөрийг Улсын төсөвтэй уялдуулан хэрэгжилтийг бүрэн хангах, Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн хүрэх үр дүн бодитой хэрэгжсэн эсэхэд анхаарч, хөгжлийн төлөө хамтран ажиллах шаардлагатай байгаа талаар тус тус үг хэлсэн болно.

“Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Тэгэхээр Төсвийн зарлагын дэд хорооны дүгнэлт Улсын Их Хурлын гишүүдэд тараагдаж амжаагүй байгаа юм байна. Тэгэхээр дэд хорооны даргаас бас тодруулахад албажсан эцсийн дүгнэлт мөн, тийм ээ, саяын уншиж танилцуулсан. Энэ дээрээ бас нэг тодруулга өгөх нь зүйтэй гэж.

Далайн Батбаяр гишүүний микрофоныг өгье.

**Д.Батбаяр:** Энэ албажсан эцсийн дүгнэлт мөн, өмнө нь унхсан учраас.

**Д.Амарбаясгалан:** Ингээд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Байна уу? Уянга, Энхтүвшин гишүүнээр. Энэ нэмэгдэж байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. 10 гишүүн үг хэлнэ, асуулт асууна.

Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд асуулт асууя. Асуулт асуухгүй юм уу, тестэлж үзсэн юм уу, төхөөрөмж гайгүй ажиллаж байгаа шүү.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

**Л.Соронзонболд:** Энэ Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан дээрээс нэг асуулт асууя гэж бодсон юм. Энэ дээр мөнгөн хөрөнгө дээр ерөнхийдөө 23 оны сүүлээр 12 их наяд төгрөг байгаа.

**Д.Амарбаясгалан:** Байж байгаарай Соронзонболд гишүүн. Энэ Засгийн газрын гишүүд, Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд холбогдох албан тушаалтнуудыг орж ирэхийг хүсэж байна.

Соронзонболд гишүүн.

**Л.Соронзонболд:** Энэ мөнгөн хөрөнгөн дээр 23 оны сүүлээр 12 их наяд төгрөг байршиж байгаа юм байна. Энэ мөнгөний хэдэн хувь нь Монголбанк дээр,

хэдэн хувь нь арилжааны банканд байршидаг вэ гэдэг асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Далай Батбаяр гишүүн. Дэд хорооны дарга хариулт өгье.

**Д.Батбаяр:** Энэ өнөөдрийн хуралдаан дээр манай ажлын хэсэг бас ирчихсэн оролцож байгаа. Тийм учраас яг нарийн тоотой асуудлуудыг манай ажлын хэсэг хариулаад явчихна.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсэг хэн байна. Тавинжил. Индрийн 2 дугаар микрофон. 2 дугаар индрийн микрофоныг.

Сангийн яамны ТЗУГ-ын дарга Тавинжил байна. Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангаар илэрхийлэгдсэн 12 их наяд төгрөгийн 5 орчим их наяд төгрөг нь 4,5 их наяд төгрөг нь Монголбанканд байршиж байгаа. Энэ нь улсын төсвийн орлого болон төсөвт байгууллагуудын үлдэгдлээс бүрддэг нэгдсэн дансны Монголбанк дахь Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэл байгаа. Тэгэхээр 4,5 тэрбум төгрөг гэдэг бол ойролцоогоор нэг 35 хувь нь Монголбанканд нэгдсэн дансанд байршиж байгаа.

Үлдсэн 7,5 тэрбум төгрөг нь ТӨК-ууд, тэгээд харьяа улсын үйлдвэрийн газруудын арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл байгаа. Унд нь ялангуяа манай Эрдэнэс тавантолгой, Эрдэнэт үйлдвэр гээд ийм томоохон компаниудын мөнгөн хөрөнгө бол нэлээн далайцтай хэсгийг нь эзэлж байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Соронзонболд гишүүн тодруулга авъя.

**Л.Соронзонболд:** Энэ асууж байгаа шалтгаан нь болохоор ингээд байгаа юм. Яах вэ, Монголбанк дээр байршихаар тэр төсвийн 4,5 их наяд төгрөгийг хэрвээ арилжааны банкад байршуулсан бол арилжааны банк тэр мөнгийг бас цааш нь тодорхой хувийг нь

зээлэх байхгүй юу. Тэгээд тухайн тэр зээлээр авсан арилжааны банк нь бас орлого олно.

Нөгөө талдаа зээлийг ашигласан ААН нь бас орлого олно. Ингэхээр уул нь нөгөө нэг татварт төсөвт төвлөрүүлэх татварын орлого нэмэгдэх ийм боломжтой байгаа юм. Тэгэхээр би заавал бас Монголбанк дээр байршуулаад нөгөө Монголын бизнес эрхлэгчдийг дэмжихэд ашиглагдах боломжтой эх үүсвэрийг Монголбанк дээр байршуулаад байгаа нь жоохон буруу юм биш үү л гэсэн ийм л санал байгаад байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Тодруулга хариулт өгье.

**Ч.Тавинжил:** Гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Монгол Улсын Засгийн газраас Засгийн газрын энэ төрийн сангийн тогтолцоог 2002 онд нэвтрүүлсэн байгаа. Үүгээрээ бид нар бүх төсөвт байгууллагууд улсын төсвийн дансыг Монголбанк дээр нэгдсэн дансанд ингэж байршуулж, төлбөр тооцоог нь хийж байгаа. Энэ Засгийн газрын төрийн сангийн тогтолцоог дагаад энэ Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем гээд ийм системийг нэвтрүүлсэн. Энэ нь бүх төсвийн байгууллагууд энэ улсын төсвийн зарлага, санхүүжилт, гүйлгээг хийдэг ийм тогтолцоо байгаа.

Энэ нь Монгол Улсын 330 сум, 9 дүүрэг, 21 аймаг, тэгээд энэ бусад яамнууд дээр ингэж цахимаар гүйлгээ хийдэг ийм улсын төсвийн санхүүжилт, зарлагын гүйлгээг хийдэг ийм тогтолцоо байгаа. Тэгээд үүний гол төв данс нь Монголбанк дахь энэ улсын төсвийн данс. Улсын төсвийн ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Миний асуулт боловсролын салбартай холбоотой. 23 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дээр 137 төрийн өмчит хуулийн этгээдээс тэр дундаа 109 байгууллага

дээр санхүүгийн санал, дүгнэлт гарсан байна. Тэр дотроос 38 нь “хязгаарлалттай” дүгнэлттэй гарсан байгаа юм. Тэгэхээр нэг ёсондоо 3-ны 1 нь “хязгаарлалттай” буюу асуудалтай.

Тэгээд тэр 38 дотор яг боловсролын салбар дээр Монголын хамгийн том төрийн өмчит сургуулиуд ер нь бүгдээрээ орчихсон байна л даа. МУИС, Шинжлэх ухаан технологийн сургууль, Технологийн Их сургууль, МУБИС, ХААИС, Соёл урлаг. Тэгэхээр энд 5 сургуульд суралцаж байгаа нийт оюутан нь 50 мянган оюутан байдаг юм байна.

Тэгэхээр Монгол Улсын нийт их, дээд сургуульд суралцаж байгаа нийт оюутны 40 хувь нь нь суралцаж байгаа яг энэ 5 сургууль дээр “хязгаарлалттай” дүгнэлтүүд ингээд гараад байгаа нь ер нь асуудалтай гэж бодоод байна л даа.

Ер нь санхүүгийн тайлан дээр “хязгаарлалттай” дүгнэлт гарч байгаа бол энэ нь менежментийн асуудал шууд яригдана гэсэн үг. 50 мянган оюутны ард дахиад бараг 100 мянга гаруй аав, ээж нар тэр хүүхдийнхээ төлөө сургалтынх нь төлбөрийг нь төлөх гээд насаараа хуримтлуулсан мөнгөө зарж байгаа аав, ээж нар байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ “хязгаарлалттай” дүгнэлтүүдийг ингээд гаргаад л ингээд л нэг яриа болгоод орхих юм уу. Эсвэл энэ төрийн өмчит сургуулиуд дээрээ менежментийн том реформ хийх юм уу, 1 дүгээрт.

2 дугаарт, Засгийн газрын тусгай сангууд байна. 22 тусгай сангаас 20 тусгай сан дээр аудит хийгдсэн байна. Тэр дундаа нөгөө л алдарт Боловсролын зээлийн сан. Ер нь сүүлийн 10 жил аудитын дүгнэлт дээр дандаа “хязгаарлалттай”, хамгийн их асуудалтай гарч байсан нь өөрөө Боловсролын зээлийн сан. Энэ удаагийн аудитын дүгнэлт дээр чинь бараг 120 тэрбум төгрөгийн асуудал зөрчил гэж гарчихсан байна.

Тэгээд бүр сонирхолтой нь тэр 120 тэрбум төгрөгийн зээл хөөн хэлэлцэх хугацаа дууссан, найдваргүй болох эрсдэлтэй гэсэн байгаа юм. Тэгэхээр татвар төлөгчдийн мөнгөөр зээл авчхаад, тэр нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдгийг хэзээ ч ойлгохгүй юм байна. Юу гэсэн үг вэ. Хаан банкнаас чинь бид нар зээл авчхаад, хөөн хэлэлцэх хугацаа дуусна гэж байдаггүй шүү дээ.

Тэгэхээр яагаад татвар төлөгчдийн мөнгөөр олгосон зээл хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэсэн аудитын дүгнэлт дээр гардаг юм бол. Найдваргүй болох эрсдэлтэй гэж ер нь сүүлийн олон жилийн аудитын дүгнэлт дээр байдаг. Нөгөө хамгийн гол нь аудитын дүгнэлт дээр бүх зүйл нь асуудалтайгаа, жишээтэйгээ байдаг боловч авсан арга хэмжээ л ховор байгаад байгаа юм л даа. Тэгэхээр үүнийг нэг цэгцлэх ёстой гэж бодож байгаа юм.

Тэгээд бас Ерөнхий аудитор Загджав даргын дүгнэлтийн үг дээр бас нэг ноцтой асуудал хөндөгдсөн. Боловсролын зээлийн сангийн гадаад зээлийн авсан тэр асуудалтай эргэн төлөгдөөгүй зээл Монголбанкны саарал жагсаалтад хэзээ ч орохгүйгээр явж ирсэн.

Гэтэл Боловсролын зээлийн сангийн 70 хувийн санхүүжилт нь явагддаг дотоодын оюутнууд нэг ёсондоо ардын хүүхдүүд нь алдсан байж авсан нэг 4 сая төгрөгийн зээл нь эргэн төлөгдөхгүй бол Монголбанкны хар жагсаалтад ордог, дипломоо хураалгадаг. Гэхдээ гадаад зээлээр авсан хүүхдүүдийн зээл нь хэзээ ч эргэн төлөгдөж байгаагүй, түүний араас хэн ч хөөцөлдөж байгаагүй.

Энэ аудитын дүгнэлт дээр бас 147 хүүхэдтэй бүр холбогдож чадаагүй гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ байдлыг, үүнийг яах вэ? Энэ яагаад Монголбанканд уг нь тэр нэрс нь өгөгдөхгүй байгаа юм бол? Уул нь шийдвэр нь гарсан гэж ойлгосон.

**Д.Амарбаясгалан:** Асуулт асуучхав уу, үг хэлчхэв үү. Хэн хариулах вэ? Далайн Батбаяр гишүүн хариулъя. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга.

**Д.Батбаяр:** Батнайрамдал гишүүний эхний асуултад хариулъя. Яалт ч байхгүй яг энэ төсвийн сахилга баттай холбоотой, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулаад байгаа, аудитын дүгнэлт гардаг, аудитын дүгнэлтийг цааш нь арга хэмжээ болгодоггүй ийм асуудал уяжигрчихсан юм байна лээ.

Тэр байтугай өнгөрсөн парламентын үед арга хэмжээ тооцуулахаар сөрөг болон “хязгаарлалттай” дүгнэлт хүргэсэн, хүлээн авсан албан тушаалтнуудад арга хэмжээ авхуулахаар Зарлагын хяналтын дэд хорооноос албан бичиг Ерөнхий сайдад хүртэл хаяглаж явуулж байсан. Харамсалтай нь энэ албан бичгийн хариуг заасан хугацаанд нь хүргүүлээгүй. Энэ албан бичгийн дагуу арга хэмжээ авсан эсэх нь тодорхойгүй байгаад байдаг. Үеийн үед яг энэ ингээд хариуцлагагүй байдалд нь хариуцлага тооцдог энэ механизм нь ажиллахгүй явсан юм билээ.

Тэгэхээр таны хэлж байгаа маш үнэн, зүйтэй үг. Залуу гишүүний хувьд үнэхээр чухал асуудлыг хөндөж байна. Тэгэхээр үүнийг ч бас цааш цаашид нь анхаарах ёстой.

Зарлагын хяналтын дэд хорооноос мөн холбогдох хүмүүст нь бас албан бичгийг хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын тогтоол гаргуулахаар Төсвийн байнгын хороо болон Улсын Их Хурлын даргад хандах болно.

Боловсролын сангийн зээл болон Монголбанкны холбоотой асуудалд манай ажлын хэсгээс хариулчих байх.

**Д.Амарбаясгалан:** Хэн байна. Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Маш зүйтэй асуудлуудыг хөндөж байна, Батнайрамдал гишүүн ээ. Тэгэхээр энэ тэр ер нь их, дээд сургуулиудын удирдлага болоод Дээд боловсролын тухай хуулиараа Удирдах зөвлөл нь ингээд ишидээд явдаг байсан. Гэхдээ бид энэ чанарын тогтолцоог нь сайжруулах, хариуцлага тооцуулахаар бас хандах болно. Хязгаарлагдмал ийм юм гаргаад 2 жил дараалчихсан сургууль ч байна шүү дээ. Жишээлбэл МУИС. 2 жил дараалаад хязгаарлагдмал гэсэн ийм дүгнэлт авчихсан. Энэ дээр холбогдох этгээдүүд нь хариуцлага хүлээх ёстой гэж бодож байна.

Ер нь ил тод ийм чанарын сайн удирдлагын тогтолцоотой газарт ийм юм гарахгүй шүү дээ. Юуны хувьд тэр боловсролын зээлийн тэр авлагын тайлбарын тухайд нэг хэдэн эрх зүйн баримт бичгийг ингээд харахаар 2011 оны 7 дугаар сарын 10-нд батлагдсан Дээд боловсролын санхүүжилт, нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8 дахь заалтад сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, эргэн төлөх тухай Улсын Их Хурлаас тогтооно гэж заасан. Энэ зохицуулалт нь 23 оны 7 сарын 7-ны ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя. Наранбаяр сайдын микрофоныг өгье.

**П.Наранбаяр:** Энэ заалт нь 7 сарын 7-ны өдрөөр хууль хүчингүй болох хүртэл үйлчилсэн байгаа, 23 оны 7 сарын 7-ны өдөр хүртэл. Энэ батлагдсанаас хойш Боловсролын зээлийн сангаас олгодог санхүүжилтийн нэг төрөл болох гадаадад суралцуулах зээлийг зохицуулсан 12 оны 19 дүгээр тогтоол, 13 оны 271 дүгээр тогтоол, 20 оны 70 дугаар тогтоолын хавсралт журмууд болон суралцагчтай байгуулах гэрээнд зээл эргэн төлөгдөх тухай зохицуулалт нь нарийвчлан тусгагдаагүй байсантай холбоотойгоор тус сан зээлийн эргэн төлөлтийг шаардах эрх бүрдээгүй ингээд байгаад байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурал дээр Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдана. Энэ ажлын хэсэгт миний бие ч гэсэн идэвхтэй оролцоод яг энэ би эргүүлэн төлөх энэ бодлогыг л нарийн тусгачихъя гэсэн ийм зүйлийг ярьж байгаа.

Тэгээд ер нь ингээд 10 жилээс дээш хугацаанд төлөөгүй явж байгаа энэ авлагыг нь ингээд харахаар нэлээн их дүнтэй олон хүн ингээд байж байгаа. Би өчигдөр Байнгын хороонд үүнийг мэдээлсэн. Тэгээд энэ 10 жилээс дээш байгаа энэ төлөөгүй байгаа хүмүүстээ өнөөгийн үйлчилж байгаа энэ журам дүрмийнх нь дагуу ингээд шинэчлэх шаардлагатай ийм зүйлүүдийг нь бид нар ингээд нөхөн төлүүлэхээр, эргүүлэн төлүүлэхээр ажиллана.

Ер нь 10-аас дээш жил төлөөгүй байгаа хүн нийтдээ 502 байна. Гадаадын зээлийн авлагын тухайд. Энэ мөнгөн дүн нь болохоороо зэрэг нийтдээ нийт авлага болон хүүтэйгээ нийлээд ингээд нэг 48 ийм тэрбум төгрөг болчихсон ийм нөхцөл байдалтай байгаа. Тэгэхээр зэрэг энэ авлагыг төлүүлэх, авсан бол эргүүлж төлөх энэ нөхцөл энэ юу гэдгийг бид нар эргэж харж нарийвчлах энэ ажлаа үргэлжлүүлнэ.

Түүнээс гадна тухайн үед үйлчилж байсан хууль журмынхаа дагуу яг ингээд төлөөд дуусчихсан хүнтэй нь бүх орлого юу нь хаах ийм шаардлагатай байгаа.

Цаашидаа ч гэсэн энэ Боловсролын зээлийн сан дээр бид бас дэлхийд нэртэй сайн сургуульд хүүхдүүдийг явуулахаас гадна бас өчигдөр Найдлаа гишүүн ч гэсэн хэлж байсан. Ер нь энэ боловсон хүчнээ Монголдоо сайн бэлдэх дээр анхааръя эд нар гэсэн ийм ярьж байна лээ. Тэгэхээр энэ асуудлыг би ч гэсэн дэмжинэ. Тухайлбал энэ боловсролын зээлийн сан чинь дотроо ингээд нэг 5 ангилалтай байгаад байгаа.

Гадаадын зээл. Гадаадын зээл нь дотроо 2. Магистр, бакалавр, доктор

гээд ингээд магистр, доктор, бакалавр гээд байна.

Оюутан хөгжлийн зээл гээд байгаа. Энэ оюутан хөгжлийн зээл ер нь дотоодын их, дээд сургуульд сурч байгаа хүмүүст зориулсан байгаа. Энэ дээр ч гэсэн их олон асуудлууд урган гарч байгаа. Энэ зүйлүүдийг тухайн үед би Байнгын хороондоо бас мэдээлээд, энэ дээр хийх шинэчлэлүүдээ хамтран ярилцаад явъя гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Отгоншарын Батнайрамдал гишүүн тодруулна. 1 минут. Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Тэгэхээр Боловсролын зээлийн сангийн асуудал бараг мэдэхгүй хүн байхгүй болсон байх. Тэгэхээр энэ дээр Наранбаяр сайд та нэлээн том реформ хийх байх гэж хүлээж байгаа. Энэ дээр маш олон нийтийн маш том хүлээлт ч гэсэн байгаа. Тэгээд энэ дээр тантай зөв реформын төлөө хамтарч ажиллах болно. Хамтдаа нэг заавал шийдэл гаргах ёстой.

2 дугаарт, бас энэ төрийн өмчит томоохон их, дээд сургуулиудын асуудал. Ингээд “хязгаарлалттай” дүгнэлтүүд гараад байна гэдэг нь менежментийн асуудал цогцоороо байгаад байна гэсэн үг л дээ. Тэгэхээр үүнийг нэг ганц захирлын нэг ганц 2 хүний томилолтын асуудал гэж битгий бодоосой, томилгооны асуудал гэж битгий бодоосой. Яагаад гэх юм бол энэ 5 сургуулийн ард 50 мянган хүүхдийн ирээдүй, түүний ард дахиад 100, 150 мянган аав ээж нарын асуудал яригдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энд ингээд менежментийн том шинэчлэл хийх болчихсон байна л гэдэг аудитын дүгнэлт гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр та энэ томоохон төрийн өмчит их, дээд сургуулийн ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

**Н.Наранбаатар:** Баярлалаа. Гишүүд энэ өдрийн мэнд хүргэе.

Сая улсын төсвийн тодотгол батлагдлаа. Тэгээд энэ тодотголоор 7 аймаг улсын төсөвт орлого төвлөрүүлнэ гэж. Дорноговь 11 тэрбум, Дорнод 2 тэрбум, Өмнөговь 1,4 их наяд гээд хамгийн өндөр. Сэлэнгэ 2 тэрбум, Дархан 1, Улаанбаатар 19 тэрбум, Орхон 137 тэрбум гээд. Өмнөговь аймгаас 1,4 их наяд төгрөгийн орлогыг энэ жил улсын төсөвт төвлөрүүлэхээр дөнгөж сая та хэд баталчихлаа.

Урьд жилүүдэд төсвийн гүйцэтгэл харахад Өмнөговь аймаг улсын төсөвт 21 онд 78 тэрбум, 22 онд 264, 23 онд 456, ингээд 24 онд 1,4 их наяд гээд улсын төсөвт үлэмж их хэмжээний орлого төвлөрүүлээд байгаа юм.

Би юу гэж асуух гээд байна вэ гэхээр зэрэг төсвийн хөрөнгө оруулалтыг эргээд энэ бүс нутаг, ялангуяа энэ аймгуудад нь юу үндэслэж хуваарилаад байгаа юм бэ? Өнгөрсөн 4 жилийн хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт говийн бүс нутагт нэлээд олон ажлуудыг хийхээр төлөвлөсөн байсан. Харамсалтай нь төсвийн хууль орж ирээд өчүүхэн бага хэмжээний төсөв тавьчихдаг. Хамгийн их төвлөрүүлж байгаа мөртөө хамгийн бага хөрөнгө оруулалт тавьдаг. Тухайлах юм бол Өмнөговь аймаг энэ онд 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нэг арван зургаахан тэрбум төгрөгийн л одоо, бусад аймгууд нь 100 хэд, 200 хэдэн тэрбум төгрөг гараад явчихсан. Тэгээд хамгийн сүүлээсээ 1 дүгээр байранд хөрөнгө оруулалтаараа тавьдаг. Өгөх болохоороо зэрэг хамгийн өндөр дүнтэй тавьчихдаг. Энэ 24 онд уг нь 700 тэрбум төгрөг л улсын төсөвт төвлөрүүлнэ гэж баталсан байсан, ноднин. Тэгээд сая тодотголоор нэмээд 2 дахин нэмээд 1,4 их наяд болгоод тавьсан.

Тэгээд ирэх жил хэд болгож нэмэх юм мэдэхгүй. Тэгээд одоо 9 сарын 1-ний дотор улсын төсөв хөрөнгө оруулалт, бүх

зүйлээ Сангийн яам Засгийн газарт Улсын Их Хуралд өргөн барих гэж байна. Цаг хугацаа бас богино болсон байна. Тэгээд хөрөнгө оруулалтын хуваарилалтуудаа аймгууд, бүс нутгууд хийх гэж байгаа хөрөнгө оруулалтаа яаж хуваарилж, яаж яваад байгаа юм бэ? Хамгийн их өгсөн нь хамгийн бага өгөх зарчмаар яваад байгаа юм уу. Энэ дээрээ нэг анхаараач. Хийх ажил маш их байна.

Говийн бүс нутаг тэр чигтээ цөлжилтөд. Нийт газар нутгийн 80 гаруй хувь нь цөлжилтөд хамрагдчихсан. Мал маллах боломжгүй болчихсон. Аймгийн төвүүд нь ДЦС байхгүйгээс болоод дулаан хангамж нь муудчихсан. Шинэ цахилгаан станц барих гэхээр төсөв хөрөнгө байхгүй. Хил боомтуудаа бид хөгжүүлнэ гээд хил боомтоо авто замаар холбох томоохон зорилт тавиад, аймаг орон нутгийн төсвөөрөө явуулаад байдаг. Хүрэлцдэггүй. Улсын төсвөөс нэмэрлэнэ гэсэн мөртөө нэмэрлэж чаддаггүй, нэг дөрөв, тавхан километр замын төсөв хөрөнгө тавьчихдаг. Зарим сумууд нь хуучныхаа тог цахилгаангүй байдаг тэр үетэй л хэвээрээ. Тог цахилгаан байхгүй. Гаднаас тог цахилгаан импортлодог. Нэгдсэн төвийнхөө системд холбогдож чадаагүй ийм сумууд хүртэл манай хамгийн баян гэж нэрлэгдээд байгаа аймгууд байж байна.

Тийм учраас та бүхэн энд хөрөнгө оруулалтаа хэрхэн хийж байгаа юм. Энэ жилийн хөрөнгө оруулалт төсвийн бодлогодоо ямар бодлого барьж байгаа юм бэ гэдэг талаар Сангийн яамнаас тодруулж асууя.

Дараа нь тодруулъя.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгөх үү? Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 23 оны гүйцэтгэл яригдаж байгаа. Тийм, энэ удаа 3 төсөв давхцаж бид ажиллаж байна.

Тодотгол, 25 оны төсөв, энэ төсвийн гүйцэтгэл гээд.

Та 25 онд 25 оны төсөв дээр яригдах хөрөнгө оруулалтын бодлогыг асуулаа гэж ойлгож байна. Зөв үү тийм ээ. Тийм. Тэгэхээр өнөөдөр хуулийн хугацаандаа багтаж Засгийн газар 2025 оныхоо, ирэх оныхоо төсвийг Улсын Их Хуралд өргөн барина. Тэгээд тэнд нэлээн асуудлууд тодорхой болох байх.

Ер нь яах вэ, нэгжийн тухай хуульд өөрчлөлт ороод орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээс орж байгаа татварын орлогын 40 хувийг нь буцаагаад орон нутаг руу нь хуваарилдаг ийм болсон байгаа. Яах вэ, бидний Монгол Улсын хувьд нэгдмэл улсын татварын бодлогоор явдаг гэдгийг та сайн мэднэ. Гэхдээ үнэхээр яг таны хэлж байгаагаар говийн бүсийн энэ томоохон уул уурхайнууд сүүлийн жилүүдэд татвар төвлөрүүлэлтийн орлого дээр нэлээн томоохон жин дарж ирж байгаа. Тийм. Энэ яах аргагүй үнэн зүйл.

Мөн говийн бүсийн ард түмэн энэ уул уурхай, томоохон энэ мега төслүүд дээр маш ухаалгаар хүлээцтэй хандаж энэ одоо төслүүдийг амжилттай явуулахад маш сайн дэмжлэг үзүүлж ингэж яваа. Тийм.

Тийм ч учраас яг таны хэлж байгааг члан ер нь тэнд хөрөнгө оруулалт болон бүс нутгийн хөгжлийн асуудлууд мэдээж түлхүү, тэнд асуудал тавигдана. Тэгээд 2025 оны төсөв өргөн барихаар өшөө их дэлгэрэнгүй ярья.

**Д.Амарбаясгалан:** Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууя.

**Г.Дамдинням:** Засгийн газрын үйл ажиллагааны тайлан чухлыг бүгдээрээ мэдэж байгаа. Үүний өмнөх хэлэлцүүлэг дээр Засгийн газрын сайд нарыг нэхээд байсан, гол сайд нар хүрээд ирлээ. Ашигүй. Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл, Барилга, хот байгуулалтын сайд Батсуурь нар ашигүй хүрээд ирсэн

байна. Миний асуултад хариулах байлгүй гэж бодож байна.

Сайд нарыг томилогдож байхад би энэ авлига хороололтой холбоотой асуудлыг ярьж байсан юм. Монгол Улсад хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдүүлэх үүрэг Засгийн газар, тэр дундаа Хууль зүй, дотоод хэргийн сайдад байдаг. Тэгээд энэ Улаанбаатар хотын захирагч болон бусад хүмүүсээс авч байгаа мэдээллээр захиргааны эрх зүйн актууд тавиад байдаг, тавиад байдаг, хэрэгжүүлж болохгүй байна гэдэг ийм хариултыг өгөөд байгаа байхгүй юу.

Тэр цагдаа чинь хаачихсан юм. Хуулийг хэрэгжүүлдэг, мөрдүүлдэг хүмүүс нь яагаад ажиллахгүй байгаа юм. Энэ авлига хороолол гэдэг газар дээр. Улсаараа, засгаараа, хотоороо зүтгээд дийлэхгүй байна шүү дээ. Хуулиа мөрдүүлмээр байгаа байхгүй юу. Би таныг сайд болж байхад Алтангэрэл сайд энэ дээр нэг тодорхой анхаарал хандуулаадхаарай, асууна шүү гэж байсан. Би байнга асууна. Тэгээд энэ дээр нэг хариулт өгөөдхөөч.

2 дугаарт, Батсуурь сайд аа. Энэ авлига хорооллын өндөр барилгын хяналтыг Барилга, хот байгуулалтын яам хийдэг хууль журамтай юм байна лээ. Тэгээд энэ нураая, зогсооё, болиулъя гээд энэ хууль бус техникийн нөхцөлүүдтэй холбоотой асуудлуудыг нь ингээд танай яамныхан яриад л шийдвэр гаргаад л байдаг. Тэгээд энэ барилгыг ер нь зогсооход юу нь болохгүй байгаад байгаа юм.

Та нар ингээд шүүхийн шийдвэртэй гэж хүлээлгэсээр байгаад айлуудыг нь оруулаад, тэгээд л болгочихно гэж бодоод байгаа юм уу. Энэ газрын наймаа, хууль бус байдал нэг газар очоод зогсох ёстой байхгүй юу. Би хувь гишүүнийхээ хувьд энэ газрын наймаа яг энэ цэг дээрээс зогсоод эргэх ёстой байхгүй юу. Энэ барилга баригдаад дууслаа л бол, ашиглалтад орлоо л бол дээшээ өгсүүлээд л, энэ нарны гүүрнээс

дээшээ өгсүүлээд л, шинэ гүүрнээс дээшээ өгсүүлээд л, газруудыг нь бүгдийг нь олгочихсон юм байна лээ. Төмөр замын дэргэдэх тусгай хамгаалалттай газар, голын ай сав дотор олгочихсон газар байхгүй юу, хоёрын хоёр хууль зөрччихсөн.

Та 2 сайд энэ авлига хорооллын газар болон техникийн нөхцөлүүдтэй холбоотой бүх мэдээллийг нэг нийтэд ил болгоод өгч болох уу? Хугацаа авч байгаад, намрын чуулган эхлэхээс өмнө. Энэ асуултад 2 сайд хариулмаар байна.

3 дугаар асуулт ийм асуулт байна. Энэ Монголын энэ төрийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгө л гэсэн үг л дээ. Арилжааны 10 банканд 1131 данс дээр 2,3 их наяд төгрөгийн данс байна, агуулагдаж байна. Энэ данснууд дээр хүү тооцож бодуулж авч, төрийн мөнгийг, төсвийн мөнгийг нэмэгдүүлэх эрх нь Засгийн газарт байгаа. Энэ маягаараа аваачаад байрлуулсан энэ мөнгө нь 3-аас дээш хувийн хүү авч болохгүй гэсэн таазыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам нар хамтраад гаргачихсан журам байгаад байгаа байхгүй юу.

Гэтэл Монголбанкны бодлогын хүү 11 хувь байна, 11 хувь байна. 7 хувийн зөрөөтэй байхгүй юу. Хадгаламжийн хүү жигнэсэн дунджаараа 11,3 хувийн хүүтэй байгаа юм. 7,3 хувийн зөрөө байгаад байгаа юм. Яагаад энд ийм 3 хувийн тааз тавиад байгаа юм? Ядаж бодлогын хүүгээрээ байж болдоггүй юм уу? 7 хувийн өсөлт хийнэ гэсэн үг шүү дээ. Энэ төрийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгө. Үүнийг асууя.

**Д.Амарбаясгалан:** Энэ Дамдинням гишүүн 2 жил л үндсэндээ энэ авлига хорооллын асуудлыг хөндөж ярьж байгаа. Засгийн газар, хот, хотын удирдлагууд очихоороо олон нийтэд зориулаад хэвлэл мэдээллээр попорсон мэдээ өгөөд яваад байдаг, нураана л гээд байдаг.

Тэгсэн мөртөө энэ Дамдинням гишүүний хөндөж байгааг та бүхэн минь



логикийнхоо хувьд бодоод үзээрэй. 2 жилийн өмнө Ерөнхий сайд очиж ажиллаад голын голдирол өөрчилсөн байна. Олон нийтийн эрсдэлтэй байх нөхцөлийг, үерийн усны эрсдэлтэй байх нөхцөлийг үүсгэсэн байна. Нураана гээд мэдэгдчихсэн. Түүнээс хойш зөвшөөрөл өгсөн байдлыг шалга гэдгийг энэ Дамдинням гишүүн шаардаад байгаа.

Тэгэхээр энэ дээр Засгийн газрын гишүүд, холбогдох энэ хотын удирдлагууд бодитой ажил хийснийгээ 7 хоногийн дотор Улсын Их Хуралд мэдээлэл ирүүлэх хэрэгтэй. Шаардлагатай гэж үзвэл Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулаад, яг энэ үйл явцыг шалгах ёстой. Энэ өөрөө нийгэмд шударга ёс гэж байдаг юм уу, олон нийтийн эрх ашиг гэж байдаг юм уу гэдгийг нотлох зүйл учраас энэ дээр бид онцгой анхаарч ажиллана.

Түүнээс ямар нэгэн байдлаар Улсын Их Хурлын гишүүн асуугаад, тухайн цагт нь янз бүрийн аргаар тайлбар тавиад, хариулт өгөөд явдаг энэ байдлыг бид яг энэ арга хэмжээнээс эхлээд таслан зогсоох учиртай.

Тэгэхээр Дамдинням гишүүн энэ дээр анхаарал тавь. Салбарын сайд, хотын удирдлагууд энэ дээр бодитой алхмаа хий.

Ялангуяа Ерөнхий сайд очоод ажилласан тэр өдрөөс хойш олгогдсон зөвшөөрлийг хэн өгсөн, ямар эрх ашгаар өгсөн, ямар шийдвэрийг хэн гаргасан гэдгийг тодорхой болгож, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэх ёстой. Төрийн хууль 3 хоног хэрэгждэг гэдэг нэг үг байдаг. Албан тушаалтнууд түүнийгээ бодохгүйгээр ажиллах ёстой. Хууль бол хууль, журам бол журам. Одоо энэ журмын зохицуулалтыг ч гэсэн бид хязгаарлахаар Улсын Их Хурал үйл ажиллагаандаа орж байгаа юм. Журмаар зохицуулалт хийж байгаа байдал өөрөө албан тушаалтан эрхээ хэрэгжүүлэх үү, хэрэгжүүлэхгүй юу гэдгийг шийдээд байгаа учраас олон

нийтийн эрх энэ дээр зөрчигдөж байгаа юм.

Тийм учраас журмын энэ зохицуулалтыг цөөлнө. Тэгэхээр Их Хурал энэ дээр анхаарлаа тавьж ажиллана. Дамдинням гишүүний зөв. Энэ асуудлыг заавал ярьж байх ёстой. Олон нийт үүнийг яаж шийдэхийг харж байгаа. Энэ дээр Хууль зүйн сайд хариулт өгөхийг хүсье. Алтангэрэл сайд.

**О.Алтангэрэл:** Энэ анх авлига хороолол буюу энэ Акуа гардин хорооллын зөвшөөрөл яаж олгосон. Сая Улсын Их Хурлын даргын ярианд дурдаж байгаа тэр Ерөнхий сайдыг очсоноос хойш дахиж нэмж зөвшөөрөл өгсөн үү, үгүй юу гэдэг цэвэр албан тушаалын асуудал болж хувирна.

Тэгэхээр Амарбаясгалан дарга аа, энэ дээр бас Авлигатай тэмцэх газар бас оролцох ёстой. Тэгээд яг таны хэлсэн саналыг бүрэн дэмжиж байна.

Өнөөдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар яамны харьяанд үйл ажиллагаа явуулж байна. Тэгээд нэгэнтээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бол шүүхээс гарсан шийдвэрийг биелүүлэх ёстой. Тэгэнгүүт захиргааны хэргийн шүүх дээр энэ барилгатай холбоотой ийм захирамж гараад асуудал гээд гацчихсан байж байдаг. Хэрэг шийдвэрлэж байгаа гэдэг. Захиргааныхаа процессын хуулийг үзэхээр энэ хэрэг аль хэзээний шийдвэрлэгдээд дуусчихсан байх ёстой. Харамсалтай нь одоо болтол огт шийдвэрлэгдээгүй явж байна. Шүүхийн шийдвэр гарах хүртэл энэ шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх захирамж гарчихсан. Захирамжийг бид нар яаж ч чадахгүй бодитой үнэн.

Тэгэхдээ бид нар одоо энэ дээр дахиад асуудал бодох ёстой. Захиргааны хэргийн шүүхийн хяналтад Засгийн газрын шийдвэр байх ёстой, холбогдох албан тушаалтны шийдвэр байх ёстой

гэж би өөрөө хуульчийнхаа хувьд үздэг хүн.

Тэгэхдээ өнгөрсөн жилүүдэд Дамдинням гишүүний тавьж байгаа энэ асуудал шиг, авлига хороолол шиг дахиад улс орны эдийн засаг, цаашидын бүтээн байгуулалтад чухал үүрэгтэй том төслүүд олноороо Захиргааны хэргийн шүүх дээр гацаж байгаа. Захиргааны процессынхоо хуулийн хугацаанд шийдвэрлэгдэхгүй байгаа. Энэ дунд яг Монголын ард түмэн шүүхийн шийдвэр биелэхгүй байна, Монгол Улсад хууль ёс хаана байна. Жирийн иргэнд үйлчилж байгаа хууль ёс энэ мөнгөтэй хөрөнгөтэй хүмүүст үйлчлэхгүй байна гэдэг. Яг энэ гомдол үүсэж байгаа учраас захиргааны хэргийн шүүх дээр энэ дуулиан шуугиантай хэргүүд олны анхааралд өртсөн хэргүүд яагаад удааширч байгаа, яагаад биелэгдэхгүй байгаа гэдэг тал дээр зохих судалгаа хийж ажиллаж байна.

Тэгэхээр сая Улсын Их Хурлын даргын хэлсний дагуу холбогдох хууль хяналтын байгууллагууд нь Авлигатай тэмцэх газартай хамтраад, Улсын Их Хурлаас энэ хяналт шалгалтын ажлын хэсэг гарах юм бол дэмжлэг үзүүлээд, энэ асуудал дээр хэдүүлээ хамтраад ажиллая. Одоо асуудлыг нэг талдаа гаргаад шийдэх цаг нь болсон гэдэгтэй 100 хувь санал нийлж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Тэгье. Тэгээд 14 хоногийн дотор мэдээлэл цуглуулах ажил дээр Засгийн газрын зүгээс холбогдох байгууллагууд энэ дээр анхаарч ажилла. Энэ ажил хангалтгүй гэж үзсэн тохиолдолд намрын чуулганы нээлт дээр Хяналт шалгалтын түр хороо байгуулах шийдвэрийг Улсын Их Хурал гаргана гэдгийг бас албан ёсоор хэлчихье.

Дараачийн асуудал. Бодлогын хүү. Монголбанк. Засгийн газрын гишүүд санал нэг байна гэж ингэж хэлж байна.

Монголбанктэй холбоотой бодлогын хүүтэй холбоотой асуултад хэн хариулах вэ? Эдийн засаг, хөгжлийн сайд

байна уу? Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван. Ажлын хэсгийн микрофон өгье.

**Г.Энхтайван:** Дамдинням гишүүний асуултад хариулъя. Гишүүн энэ арилжааны банк дээр байршиж байгаа хүүгийн зохицуулалттай холбоотой асуулт асуулаа.

Арилжааны банк дээр хадгаламжийн хүү болон харилцах дансны хүүтэй холбоотой бас бага зэрэг ойлголтын зөрөө яваад байх шиг байна. Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хамтарсан тушаалаар харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн дээд хэмжээг 3 хувь хүртэл байхаар тогтоосон байгаад байгаа.

Хадгаламжийн хүү болон төрийн болон төрийн өмчийн компаниуд болон Засгийн газрын тусгай сангууд арилжааны банкнуудаар хадгаламж байршуулж байгаа. Энэ дээр хүүгийн дээд хязгаар дээр холбогдох зохицуулалтыг нь байгууллагуудаас ямар нэгэн хязгаарлалт тавиагүй. Харилцах данс дээр 3 хувь байгаа.

Өмнө нь мөрдөгдөж байсан Ковидын тухай хуулиар харилцах дансанд хүү тооцохыг зогсоосон байсан шүү дээ. Тэгээд энэ Ковидын хууль дуусгавар болсны дараа харилцах дансанд 3 хувийн хүү тооцож байгаа. Хадгаламжийн дансанд ямар нэгэн хязгаарлалт байхгүй байгаа.

**Д.Амарбаясгалан:** Дамдинням гишүүн тодруулга 1 минут.

**Г.Дамдинням:** Ингээд л нэг тийм гөлөг төөрүүлсэн юм Монголбанкныхан, та нар бид нарыг тэнэг гэж битгий бодоод бай л даа. Хүмүүс хараад сууж байгаа шүү дээ. 1131 харилцах дансны үлдэгдлийг би хэлээд байна шүү дээ. Харилцах хадгаламж юм уу. Энэ дээр 2,3 их наяд төгрөгийн эх үүсвэр байгаа

байхгүй юу. Төрийн. Арилжааны 10 банканд байгаа 1131 данс, харилцах данс нь хуртэл орж байгаа гээд байна шүү дээ. Яагаад 3 хувийн хүүд нөгөө тааз тавиад байгаа юм бэ л гэж асуугаад байна шүү дээ. Энэ чинь бодлогын хүү 11 хувь байхад, зөрөө нь байх ёстой шүү дээ. Энд чинь. Яагаад тааз тавьдаг юм?

**Д.Амарбаясгалан:** Монголбанк энэ дээр ер нь нэг жоохон тодорхой хариул. Энэ гишүүд яг үнэнийг хэлэхэд амаа чилтэл асуулт асуух юм. Тэгээд тодорхой хариулт авч чадахгүй. Энэ бодлогын хүү ер нь ямар учиртай яваад байгаа юм? Энэ Монголбанк өөрөө энэ бизнес, зах зээлээ дэмжсэн бүтэцтэй байж чадаж байгаа юм уу? Энэ арилжааны банкнууд чинь ер нь энэ хөрөнгө оруулалтын урт хугацаатай зээлийг өгөх нөхцөл боломжоо хэрхэн бүрдүүлж байгаа юм? Зөвхөн хэрэглээний зээлд эргэлдсэн арилжааны банкнууд үйл ажиллагаа явуулаад байгаа юм уу гээд энэ зарчмын асуудлууд дээр Монголбанк их тодорхой хариулт өгөх хэрэгтэй.

Ирэх 7 хоногт Улсын Их Хурлын дарга Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн хамтаар бас Монголбанк дээр очиж ажиллана. Тэгээд энэ асуудлуудыг маш тодорхой болгох ёстой шүү.

Тодруулж хариулъя.

**Г.Энхтайван:** Дамдинням гишүүний асуултад тодруулъя. Би бас түрүүн хэлсэн. Харилцах дансны хүү. Харилцах данс гэдэг маань тухайн аж ахуйн нэгж, байгууллага, Засгийн газрын тусгай сан маань ямар нэгэн хугацаанд баригдалгүйгээр өдөр тутам гүйлгээ хийх зориулалттай. Энэ харилцах данс маань урсгал зардал болон урсгал гүйлгээнүүдийг санхүүжүүлэх зориулалттай.

Тэгэхээр арилжааны банк болон бусад холбогдох хадгаламж авч байгаа этгээдүүд энэ дээр тухайн мөнгөн хөрөнгийг эргэлдүүлээд, тухайн мөнгөн хөрөнгөд хадгаламжийн хүүтэй тэнцүү хэмжээний хүү тооцох ямар ч

боломжгүй. Ковидын хуулийн үеэр бүр бид бүхэн энэ хүүг бүр тэглэчихсэн байсан.

Харилцах дансны хүү 3 хувь гэдэг маань дэлхийн бусад орны жишигтэй тооцохоор маш өндөр үзүүлэлт. Хэрвээ бодлогын хүүгээр харилцах дансанд үлдэгдэл тооцоод явах юм бол ингэж ажиллах, харилцах данс нээх арилжааны банк байхгүй болно.

**Д.Амарбаясгалан:** Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Би энэ уул уурхайн бус салбарын өсөлттэй холбоотой асуулт асууя.

Өнгөрсөн 2023 онд эдийн засаг маань 7 хувиар өссөн байна. Тэгээд энд уул уурхай гол өсөлтийг авчирсан 2,6 хувь нь. Тэгээд дараачийн салбар нь тээвэр агуулах гэж байна л даа.

Тэгэхээр миний асуулт энэтэй холбоотой. Энэ танилцуулга дээр ч гэсэн бас энэ тээвэр агуулахын салбар 1,8 хувиар ингэж өссөн нь болохоор уул уурхайтай холбоотой гэсэн өсөлт байна гэж тайлбарласан байна. Тэгэхээр энэ уул уурхайн өсөлт гэдэг дотор зарим нь жишээлбэл энко тээрмээсээ болоод ам нөхцөлөөр жишээлбэл борлуулалтаа тооцчихсон, зарим нь болохоор биржээр зарж байгаа бол хил нөхцөлтэй учраас тээвэр нь орчихсон гэх мэтчилний зөрөөнүүд байх шиг байна.

Тэгэхээр энэ тээврийн салбарын өсөлт, хойно тайлбарлахдаа бараг 40 орчим хувиар өссөн гэсэн ийм үзүүлэлт байна. Тэгэхээр эндээс энэ өсөлтөөс уул уурхайтай холбоотой тээврийн салбараас салбарын 1,8 хувийн өсөлтийн хэдэн хувь нь уул уурхайн салбартай холбоотой өсөлт вэ гэсэн асуулт байна. Тэгээд нэмж дараа нь асууя.

**Д.Энхтүвшин:** Эдийн засаг, хөгжлийн сайд байхгүй байна. Төрийн нарийн бичгийн дарга хариулах уу?

Батхүү Төрийн нарийн бичгийн дарга хариулт өгье.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

2023 оны эдийн засгийн өсөлттэй холбоотой бүтцийн талаасаа харах юм бол тээвэр логистикийн салбар өөрөө ДНБ-д эзлэх хувийн жин нь 5,6 хувь нь байгаа. Яг тоон үзүүлэлтээрээ нийт ачаа тээвэр 62,1 сая тонн ачаа тээвэр хийгдсэн байгаа. Үүнээсээ авто зам нь 21,2 сая тонн, төмөр зам 32,4 сая тонн, агаарын тээвэр 8,6 сая тонн гэсэн байгаа. Энэ салбарын уул уурхайгаас салбар яаж байгаа шалтгаан нь манай уул уурхайн голлох бүтээгдэхүүн нүүрс байдаг. Экспортод нүүрс гаргадаг. Нүүрсний тээврийг төмөр зам, авто зам гэсэн 2 арга замаар гаргаж байгаа. Яг энэ статистикийн аргачлалын тоон задаргаа нь ҮСХ дээр гаргадаг нь нэгтгэгддэг.

Эдийн засаг, хөгжлийн яам бол албан ёсны эх сурвалжаас тоонуудаа авч үзээд дүгнэлтээ гаргадаг байгаа. Шаардлагатай дэлгэрэнгүй мэдээллийг танд бас албан бичгээр хүргүүлье.

**Д.Амарбаясгалан:** Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулга 1 минут.

**Д.Энхтүвшин:** Үүнийг асуугаад байгаа шалтгаан нь гэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар хязгаарлагч үзүүлэлтүүд байгаа. Төсвийн зардлын өсөлт нь дотоод юу уул уурхайн бус салбарын өсөлтөөс хэтрэхгүй байхаар ийм заалт байгаа.

Тэгэхээр энэ дээр уул уурхайн салбарын бус өсөлт нь 23,3 буюу яг уул уурхайн салбараа дангаар нь аваад зарим уул уурхайтай холбоотой тээврийн салбар нь тээвэр гэдэг өөр хэсэгт орчхоод. Тэгэхээр энэ үзүүлэлтийг яг уул уурхайгаас хамааралтай салбараа нэмчихвэл Төсвийн тогтвортой байдлын тухай энэ хуулийг зөрчихөөр 2023 оны төсвийн гүйцэтгэл харагдаад байгаа юм л

даа. Энэ талаар энэ залруулгыг тээвэр дотор орсон залруулгыг хийвэл уул уурхайн бус салбарын өсөлт нь хэдэн хувь гарахаар байгаа вэ?

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя. Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

**И.Батхүү:** Энхтүвшин гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Түрүүн дурдсан байгаа манай Эдийн засаг, хөгжлийн яам бол энэ үндсэн макро эдийн засгийн тоогоо яг албан ёсны эх сурвалжуудаас авдаг. Тухайлбал ҮСХ, Монголбанк, тэгээд ГЕГ гэх мэтчилэн. Яг таны дурдсан задаргааг бид нар нэмэлт тооцоо хийж байж гаргаж авах шаардлагатай байгаа учраас танд жич албаны шугамаар хүргүүлье.

**Д.Амарбаясгалан:** Дахин тодруулах юм уу? Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Би үүнийг бас өмнө нь Байнгын хороод дээр асуугаад асуулт хариулт авч чадаагүй юм. Бас л яг тодруулъя гээд орхичихсон. Би тэгээд бас хэд хоногийн хугацаа байсан учраас тодруулсан болов уу гэж бодоод дахиж асуусан. Яах вэ, үүнийг гол нь дараа нь тодруулж болно л доо. Бид хэд одоо, жишээлбэл 2023 оны төсвийн гүйцэтгэл батална гэхээр хэрвээ саяын логикоор бодвол уул уурхайн бус салбарын өсөлт маань энэ тооцоолсноос өөр дүн гарах гээд байгаа байхгүй юу. 23,3-аас доошоо орох гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр хэрвээ энэ хэмжээндээ батлагд, бид нар батална гэвэл хууль зөрчсөн төслийг жишээлбэл батлах ийм эрсдэл байгаа учраас энэ талаар л тодруулаад байгаа юм. Тэгэхээр 23,3 хувийн өсөлтдөө тааруулаад төсвийн зарлага 23,2 хувиар өсчихсөн байна лээ. Тэгэхээр маш нарийн юу зөрөө байгаа, бага зөрөө байгаа учраас уул уурхайн тэр тээвэртэй холбоотой салбарын зөрүү ороод ирвэл статистик ингээд зөрвөл хууль зөрчсөн төсвийн гүйцэтгэл батлах

ийм асуудал байгаа учраас асуугаад байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос хариулах уу? Энхтүвшин гишүүн бас ноцтой зүйл хөндөж байна шүү дээ. Одоо тэгээд батлахад зөрчилтэй юм батлах гээд байна гэдэг асуудал яригдчихлаа шүү дээ.

Тэгэхээр энэ зарлагын дэд хороо хуралдсан, дүгнэлт гаргасан. Энэ асуудал дээр ямар байр суурь байна? Ажлын хэсэг Эдийн засаг, хөгжлийн яамнаас өөр оролцоо байна уу? Ажлын хэсгийн нэмж хариулах хүн байна уу. Батхүү дарга хариулах уу? Тэгье. Батхүү дарга. 2 дугаар индрийн микрофон өгье.

**И.Батхүү:** Нэмэлтээр тодруулга өгье. Таны асууж байгаа уул уурхайн бус салбарын өсөлтийн тоо мэдээж маш чухал тоо байгаа. Яг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар энэ зарлагын өсөлтийг хязгаарлахад гол авч үздэг томъёоны үндсэн тоо байгаа. Тэгэхээрээ бас яг энэ чухал асуудлыг бас тантай санал нэг байна. Цаашидаа судалж бас юу тодорхой аргачлалыг нь сайжруулах тал дээр бас ажиллаж боломжтой гэж үзэж байна.

**Д.Амарбаясгалан:** Чинбатын Ундрам гишүүн асуулт асууя.

**Ч.Ундрам:** Эхний асуултаа Байгаль орчны сайдаас асуумаар байна. Энэ Хог хаягдлын тухай хууль гэж байдаг. Үүнээс гадна Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль гэж байдаг. Тэгээд Монгол Улс чинь хөрсний бохирдол, орчны бохирдол гээд маш хүнд нөхцөл байдалд байгаа. Үүнийг дагаад манайх чинь ХАА-н орон. Хөрс бохирдох юм бол хүнс бохирдоно, ингээд хүмүүс өвдөнө. Тэгээд ийм асуудлууд байгаа.

Энэ хог хаягдлын асуудалтай холбоотой ер нь хэдэн төгрөг 2023 оны төсөвт тусгагдаад, тэр нь ямар төсөл, хөтөлбөр болж хэрэгжээд, ямар үр дүнд

хүрээд явж байгаа юм бэ. Энэ дээрээ бид нар дүгнэлт хийгээд, цаашид бас яаж ажиллах вэ гэдгээ харах ёстой л доо. Энэ хог хаягдалтай холбоотой энэ химийн хорт болон аюултай бодис сэтгэл эмзэглүүлж байгаа зүйл юу вэ гэхээр өнгөрсөн 7 хоног манай Боловсролын байнгын хороо ШУА дээр очиж ажилласан. Тэнд маш өндөр түвшний химийн бодистой судалгаанууд явагдаж байдаг.

Тэгээд химийн урвалжууд нь хог хаягдал болдог. Түүнийгээ хаяж чаддаггүй. Мөн энд тэндхийн байгууллагууд хаяж чадахгүй болохгүй байгаа хорттой, аюултай бодисуудаа академи дээр авчраад өгчихдөг. Ингээд 12 тонн химийн хорттой бодис тэнд янз бүрийн шилэн сав савлагаанд хийгдээд хадгалагдаж байна. Тэр дэлбэрэх юм бол энэ Улаанбаатар хот байхгүй болно.

Үүнээс гадна МУИС бас 42 онд байгуулагдаад, ингээд 80 гаруй жил болоод явж байна. Тэнд бас өчнөөн олон химийн хорттой бодисууд хадгалагдаад, ингээд л хэзээ, яаж устгалд орох юм бол хүлээгдээд байж байгаа. Ямар ч стандарт шаардлага хангах сав баглаа боодол байхгүйгээр. Цацраг идэвхт бодис бүхий хаягдлууд ч гэсэн Цөмийн технологийн хүрээлэн дээр байж байна.

Мөн ахуйн хэрэглээний батарейгаас авхуулаад л зөндөө хог хаягдал байна. Энэтэй холбоотой ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Энэ Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль чинь хэрэгжиж байгаа юм уу, үгүй юу гэдэг ийм асуулт байна.

2 дахь асуултыг Боловсролын сайдаас асуумаар байна. Боловсролын салбарыг орчин цагийн боловсролын салбар үүсэж хөгжсөөд 103, 104 жил болж байна. Нүхэн жорлонгоос нь салгая гээд 2021 оны төсөвт бид 100 тэрбум төгрөгийг Эрдэнэт үйлдвэрээс босгоод, Улсын Их Хурлын тогтоолоор баталгаажуулаад, ингээд хэрэгжүүлэхээр болсон. Өнөөдөр болтол

энэ 100 тэрбум төгрөгөө бүрэн зарцуулж чадаагүй. 60 тэрбум орчмыг зарцуулчихсан байгаа.

Тэгээд Монгол Улсын энэ 850 орчим ЕБС, дотуур байр, цэцэрлэгийн нүхэн жорлонгийн 50 хүрэхгүй хувийг нь л бид нар шинэчилсэн байгаа. Эхнээсээ ганц 2 хийсэн нүхэн жорлон нь хөлдөөд, бүр ажиллахгүй болчихсон. Ингээд айлын 2, 3 настай хүүхэд цэцэрлэгт явдаг, сумд. Өвлийн хүйтэнд гадаа бие засах болдог. Малчны хүүхэд 6 настай хүүхэд дотуур байранд амьдардаг. Шөнө орой нүхэн жорлонд бие засах болдог. Тэгээд өчнөөн үүнийг дагасан асуудлууд гардаг.

Тэгэхээр энэ мөнгийг шийдүүлснээс хойш 4 дэх жил рүүгээ орж байна. 23 онд яг юу хийгдсэн байна? Цаашид бид нар ямар арга хэмжээ авах ёстой юм бэ? Яаж бид нар энэ үр хүүхдүүдээ нэг ийм аюулгүй орчинд сургах юм бэ? Наранбаяр сайд аа. Ийм 2 асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяа сайд өнөөдөр үдээс өмнө чөлөө авсан байгаа. Ар гэрийн гачигдлаар. Тэгэхээр Төрийн нарийн бичгийн дарга Баттулга хариулъя. 1 дүгээр индэр.

**Э.Баттулга:** Ундрам гишүүний асуултад хариулъя. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны төсөвт 2023 онд 24 тэрбум төгрөг тавигдсан. Энэ төсвийн дийлэнхийг Агаар орчны бохирдлыг бууруулахад зарцуулж байгаа. Хог хаягдлын тухай хуулийн дагуу хөрс бохирдуулагч эх үүсвэрийн дийлэнх хэсгийг эзэлж байгаа ахуйн хог хаягдалтай холбоотой төлбөр, түүний зарцуулалт орон нутгийн засаг захиргаанд хамаардаг.

Сая гишүүний хөндсөн аюултай хог хаягдал болон химийн бодистой холбоотой асуудлууд манай яамны эрхлэх асуудлын хүрээнд байгаа. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор өнгөрсөн хугацаанд аймаг болгонд аюултай хог

хаягдлын төвлөрсөн болон түр хадгалах цэгүүдийг барьж байгаа. Энэ он болон ирэх жилд нийтдээ 6 цэгийг барьснаар аюултай хог хаягдлын түр хадгалах болон устгах цэгүүдийг бүрэн байгуулж, бүх аймагт, нийслэл хотод барьж дуусаж байгаа.

Дахин ашиглах болон устгах асуудлаар өнөөдрийн байдлаар 34 үйлдвэр ашиглалтад ороод байна. Эндээс 24 нь хуванцар хог хаягдал дахин боловсруулдаг. Үлдсэн 10 нь химийн болон эмнэлгийн таны түрүүн дурдсан зай хураагуур, батарей, хүхрийн хүчил болон бусад химийн хортой аюултай бодисуудыг задлах, устгах ийм боломжтой хувийн хэвшлийн ААН-үүд үйл ажиллагаагаа явуулаад эхэлсэн байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сумдын сургуулийн ариун цэврийн өрөө, нолийн асуудлаар Наранбаяр сайд хариулт өгөх үү. 100 тэрбум төгрөг Улсын Их Хурал бөөн сүр болж батлаад, ариун цэврийн байгууламжуудыг шинэчилнэ гээд 4 жил болж байдаг. Хэрэгждэггүй. Аймаг суман дээрээ очоод гацдаг юм шиг байгаа юм. Тэгээд бас сураг сонсоход мэдээлэл авахад бас жоохон асуудлууд бас байгаад байх шиг байгаа юм. 2 жил үү.

**Наранбаяр сайд.** Орон нутаг дээр энэ асуудал бас их байх шиг байгаа юм.

**П.Наранбаяр:** Энэ ариун цэврийн байгууламжийн асуудлыг ингэж нэг дор, нэг мөсөн ингээд шийдэх гэж оролдсон нь сайн хэрэг. Энэ 4 үе шаттай явж байгаа ийм төсөл. Эрдэнэт үйлдвэрээс энэ санхүүжилтийг нь гаргаад өнөөгийн байдлаар нэг 67 орчим тэрбум төгрөг нь гарчихсан ингээд явж байгаа. Гэвч жишээлбэл 24 оны 3 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 15 аймгийн 78 сумд нийт 252 ариун цэврийн байгууламжийг ашиглалтад оруулсан байна. Урьд нь 3 яамны Төрийн нарийн бичгийн даргын хэмжээнд ингэсэн ажлын хэсэг явж байгаад, дараа нь Боловсролын ерөнхий газар дээр очиж энэ ажил нэлээн шуударсан гэх юм уу явсан. Урьд нь нэг

зураг төсөвгүй ингээд явчихсан учраас тэнд угаасаа ариун цэврийн байгууламж барих, ус суваг гэж тийм юм байхгүй газруудад хийсэн эд нар дээрээ нэлээн алдаа гарсан. 300 метр газар ухаад ч ус гарч ирээгүй ийм тохиолдол гарсан.

*Ийм учраас хамгийн түрүүнд тэр ажлын хэсгээс хийсэн боловсролын ... /минут дуусав/*

**Д.Амарбаясгалан:** Наранбаяр сайд нэмж хариулъя.

**П.Наранбаяр:** Тэгээд Боловсролын ерөнхий газар дээр ирээд хийгдсэн гол ажил нь зураг төсөвтэй болгоод, ингээд ААН-ийг яг гүйцэтгэлээр нь ингээд санхүүжүүлээд явсан юм байна лээ. Энэ дээр ингээд танд зарим тоог хэлэхэд сургууль 109. Энэ нийт зорилгынхоо 43,3 хувь нь дээр, дотуур байр 83, цэцэрлэг 60 нийтдээ 23,8, дотуур байр 33 хувьтай ингээд явж байгаа.

Ашиглалтад орсон энэ араас нь ингээд шалгаад ингээд үзэхэд ашиглалт жишигэлбэл зарим аймаг дээр их муу байгаад байгаа юм. Энэ ашиглалтын хувь нь жишигэлбэл Баян-Өлгий аймаг 64 хувьтай, Увс аймаг 70 хувьтай, Завхан бүр 55 хувьтай энэ хөлдчихсөн. Үнэн. Тэгээд хөлдчихсөн юу нь хөлдөлт үүссэн нь 36,1 хувь, доголдол гарсан нь 15,5 хувь, суултуур, угаалтуур, душ эвдрэлд орсон нь 12,4 хувь нь байгаа юм. Энэ болгоныг нь засаад явуулж байгаа.

Тэгээд хамгийн гол нь нэг слесарь хэрэгтэй, ийм тогтолцоо нь хэрэгтэй юм байна лээ. Ингэж засаад явахгүй бол энэ ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

**Дав.Цогтбаатар:** Баярлалаа. Өдрийн мэнд. Өчигдөр энэ Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр бас санаа зовоод ярьж чадсангүй. Одоо энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарт бас

анхааруулж хэлэх гэсэн нэг санаа байгаа юм.

Жишээлэхэд, системийн нөлөө бүхий 5 банкны нэг нь Төрийн банк. Дээрээс нь төрийн маш их дэмжлэгтэй. Өчигдөр захирлаас нь асуусан ямар амбицтай тэнд очсон бэ, ямар дараагийн амбиц чинь юу байна гээд. Тайлангаа уншиж өгчхөөд гараад явчих юм. Би ийм ашигт ажиллагаанд хүргэсэн гээд. Системийн нөлөө бүхий 5 банкны хамгийн муу ашигт үзүүлэлттэй явж байгаа банк нь Төрийн банк.

Тэгээд бид нар энэ нөгөө нэг дургүй ламыг дарж, сахил хүртээсэн аятай ийм нэг хүмүүсийг хугацаагүй, ямар ч хариуцлагагүйгээр томилоод ажиллуулаад байгаа юм. Тэгээд жишээ нь би энэ банк дээрээ дахиад ярихад энэ яг ижилхэн гараанаас магадгүй 2013 оноос Төрийн банк байгуулагдсан цагаас нь эхлээд ярихад ижилхэн баланстай байсан 2 банк нэг нь өнөөдөр цахимжаад, ашигийн хэмжээ нь жишээлэхэд 290 тэрбум, чанаргүй зээлийнх нь хэмжээ 4,5. Манай Төрийн банкных 42,8 буюу энэ бараг 5, 6 дахин бага. Чанаргүй зээлийнх нь хэмжээ 6,2 өндөр гэсэн үг.

Тэгээд энэ дээр нь энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар гэдэг юм уу. Энэ 6726 хуулийн этгээдийг энэ дарга томилж байгаа хүмүүс анхаарахгүй бол ДНБ-ий 77,9 хувь нь нь аудитынхаа дүгнэлтээр “хязгаарлалттай” дүгнэлттэй орж ирээд байгаа юм. Тэгээд тайлбарыг нь сонсохоор юм уу, асуултыг нь асуухаар бид нар энэ журмынхаа хүрээнд ажиллаж байна гэдэг байдлаар аягүй их хариулт яваад байна лээ. Энэ жишээлэхэд Монголбанк дээр. Өчигдөр бол. Журмаа сайжруулах тал дээр бас анхаарч хичээж ажиллахгүй бол 6726 компанид зориулж Улсын Их Хурал ашигтай ажилласан ажил гэдэг хууль баталж өгөх боломжгүй биз дээ? Улсын Их Хурал.

Тэгэхээр энэ дээрээ бид нар анхаарч ажиллах юм бол энэ 6726

компанийг жишээлэхэд юу гэдэг юм, хувьчлахыг нь хувьчлаад, нэгтгэхийг нь нэгтгээд 1 талд нь гаргахгүй бол төр өөрөө хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд маш том ингээд үйл ажиллагаа явуулаад байдаг. Энэ нь ямар ч үр дүнгүй, урсгал зардал, хөрөнгө оруулалт гараад яваад байгаа юм. Энэ дээр би энэ үнэхээр чамлалттай санагдаад энэ байгууллагуудад жоохон анхааруулж, хариуцлагатай ажилла гэдэг дээр нь хэлмээр байгаа юм.

Уг нь хангайн бүсийн гишүүдтэй Ерөнхий сайд, энэ хамтарч байгаа 3 намын дарга, Засгийн газрын бусад гишүүд санал сонсож байхад нь хэлсэн. Мэргэжлийн байгаад өгөөч, мэргэжлийн хүмүүсийг томилооч гээд.

Дээрээс нь мэргэжлийн байхаасаа гадна үр ашигтай, хугацаатай гэрээ байгуулахгүй бол ямар ч хугацаагүйгээр дургүй ламыг дарж, сахил хүртээгээд тэнд нь мөнхлөөд байгаа байхгүй юу. Төрийн банкиг би үнэхээр маш чамлалттай гэж хараад байгаа юм.

Тэгэхээр яг энэ жишгийг бусад бүх салбарууд дээр хариуцлагажуулаад, үүрэгжүүлээд хугацаатай гэрээ, контракт байгуулаад яваарай гэж хэлэх гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Цогтбаатар гишүүн үг хэллээ.

Ер нь энэ төрийн өмчит үйлдвэрийн газрын тоо эрс буурах зайлиггүй шаардлагатай болчихсон. Улсын Их Хурлын даргын захирамжаар бас энэ ажлын хэсэг байгуулагдаж, төр аж ахуй үйлчилгээний бизнес хийхгүй байх чиглэл дээр тогтоолын төсөл санаачлахаар ажлын хэсэг байгуулагдаж байгаа.

Төрийн худалдан авалтын үйл ажиллагаа 2023 оны дүнгээр аваад үзэхэд 12 их наяд төгрөгийн худалдан авалт хийж байгаа юм. Түүнийхээ 7 их наяд төгрөгийг төр өөрөө өөрөөсөө худалдаж

авч байгаа юм. Тэгэхээр энэ бизнесийн салбарт орон зайг нь бодитой гаргаж өгөх үүднээс, төрийн байгууллагууд дэргэдээ аж ахуй үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаггүй байх энэ тогтоолыг Улсын Их Хурлаас намрын чуулганаараа багтаж гаргана гэж ингэж зорьж байгаа.

Засгийн газар дэргэдээ байсан хэвлэх үйлдвэр, ресторан, зоогийн газрын үйлчилгээ явуулж байсан төрийн өмчит үйлдвэрийн газруудыг татан буулгасан. Улсын Их Хурал бас дэргэдээ байгаа энэ аж ахуйн үйлчилгээний үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг татан буулгана. Нэгхэн жишээ хэлэхэд Засгийн газрын дэргэд хэвлэх үйлдвэр ажиллаад төсвөөс жилдээ 300 сая төгрөгийн төсөв авдаг байсан. Тэр хэвлэх үйлдвэрийн гүйцэтгэсэн ажил нь Засгийн газрын 20 сая төгрөгийн өртөгтэй бланкийг хэвлэхэд л зориулагдаж байгаа юм. Тэгэхээр 20 сая төгрөгийн өртөг бүхий бланк хэвлүүлэхийн тулд 300 сая төгрөгийн зардал гаргаж байгаа юм.

Бас энэ 4 давхарт байсан ресторан. Жил болгон төсөвт үйлдвэрийн газар 1,4 тэрбум төгрөгийн төсөв улсын төсвөөс авдаг байсан. Үүнийг татан буулгангуут энэ рестораныг хувийн хэвшил түрээсэлж ажиллаад, төсөвт бараг 200 сая төгрөгийн орлого төвлөрүүлдэг болчихож байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө энэ хувцас оёдог, үйлчилгээ үзүүлдэг, амралт сувилал, зоогийн газар ажиллуулдаг энэ байдлаас төр бүрэн татгалзах ёстой. Харин төр нийгмийн хариуцлагын хүрээнд хувийн хэвшлийн сонирхохгүй, хийхгүй байгаа ашиг багатай, тэр үйл ажиллагаануудыг авч явж байх хэрэгтэй. Тэр бол нийгмийн хариуцлага.

Тэгэхээр энэ дээр Цогтбаатар гишүүний саналтай санал нэг байна. Энэ дээр бид тогтоолын төсөл санаачлах ажлын хэсгийг Их Хурлын даргын захирамжаар байгуулна гэдгийг бас нэмээд хэлчихье.



Гончигдоржийн Уянгахишиг  
гишүүн асуулт асууна.

**Г.Уянгахишиг:** Нэг 2 асуулт асууя.  
1 дүгээр асуулт болохоор энэ нийгмийн даатгалын сантай холбоотой. Нийгмийн даатгалын ерөнхий хууль дээр 13 дугаар зүйл дээр нь нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага гэсэн хэсэг байгаа. Энэ дээр нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтална гэж заасан. Мөн энэ дээр 13.7 дээр буюу олон нийтийн хяналтын зөвлөлийн тухай дурдаж өгсөн байгаа.

Тэгэхээр 1 дүгээр асуулт. Олон нийтийн хяналтын зөвлөл ер нь байгуулагдсан юм уу? Тэндээс тайлан юм гардаг юм уу. Тэр мэдээллийг бид нар хаанаас авч болох юм бэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт, өнөөдөр Байнгын хорооны хурал дээр П.Ганзориг гишүүн асуусан, тэр үлдэгдэл чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд ямар өгөөжтэйгөөр байршуулдаг юм бэ гэж. Түүн дээр хүүгүй байршуулдаг гэдэг хариулт өгсөн байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг бас лавлаж асуумаар байна. Яагаад хүүгүй байршуулдаг юм бэ? Энэ дээр энэ хууль дээр маш тодорхой заачихсан. Хүүгийн хэмжээ нь өөрөө тогтоогдох ёстой, бодлогын хүү, арилжааны хадгаламжийн хүү, эдгээрийн дундажласан хүү гээд ингээд маш тодорхой заачихсан байгаа.

Тэгэхээр энэ дээр хариулт өгнө үү.

Мөн 23 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хууль дээр болохоороо 300 саяыг Засгийн газрын, үгүй ээ, 300 тэрбумыг Засгийн газрын үнэт цаас болон Монголбанкны үнэт цаасанд байршуулна гэчихсэн байгаа юм. Тэгэхээр түүн дээр ингээд бид нар харахаар сая аудитын дүгнэлт дээр байна л даа. 163 тэрбум тийм ээ, Капитал банк болон Чингис хаан банк дээр очоод гацчихсан. Гэтэл дөнгөж бид нар 300

тэрбумыг байршуулж, хөрөнгө оруулалт оруулах тухай юм яригдаж байтал энэ 163 тэрбум өнөөдөр ямар ч ашиглах боломжгүйгээр байж байна.

Тэгэхээр нийгмийн даатгалын сан чинь өөрөө буцаагаад нийгмийн даатгал тэтгэврээ тавих ёстой. Нөгөө тэтгэврийн мөнгөнд нь дутагдал үүсдэг. Тэгэнгүүт ингээд нийгмийн даатгалынхаа шимтгэлийн хэмжээг нэмээд, нийгмийн даатгалынхаа шимтгэл авах ёстой төрлүүд, орлогын төрлүүдээ нэмээд, ингээд үүнийхээ орлогыг нэмэгдүүлээд байдаг. Татвартай адилхан болгочоод байдаг.

Гэтэл үүнийх нь хариуд нөгөө ажил олгогч нар дээр болон ажилтнууд дээр очиж байгаа цалингийн хэмжээ нэмэгдэхгүй. Ажил олгогч нар дээр очиж байгаа ачаалал нэмэгдээд байдаг. Гэтэл өөрөө энэ нийгмийн даатгалын сан чинь ийм хариуцлагагүй хөрөнгө оруулалтын бодлоготой явж байхад цаашидаа үүнийг ер нь нөгөө тэтгэврийн сангийн шинэчлэл гэдэг юм руугаа бид нар яаралтай орохгүй бол ийм нөхцөл байдлууд байнга байгаад байна.

Дараагийн нэг том асуудал бол бид нар өнөөдөр төсвийн гүйцэтгэл ярьж байгаа. Тэгэхээр дэгийн тухай хуулиараа 74.3-д заасны дагуу төсвийн гүйцэтгэл ярьж байхад Ерөнхий сайд байлцах ёстой. Мөн түүнчлэн Засгийн газрын гишүүд байлцах ёстой. Гэтэл өнөөдөр бид нар яаралтай горимоор, ээлжит бус хурлаар хаврын чуулганаар хэлэлцэх ёстой байсан асуудлыг татаж авчраад хэлэлцүүлж байгаа мөртөө, нөгөө Засгийн газрын гишүүд нь бүрэлдэхүүнээрээ байдаггүй. Ерөнхий сайд байдаггүй. Байнгын хороон дээр очоод асуулт асуухаар хариулах хүн байдаггүй.

Дээрээс нь сайд нар маань шинээр томилогдчихсон мэдээлэл байхгүй. Тэгэхээр энэ төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байгаа энэ хэлэлцүүлэг үндсэндээ үр дүн багатай л гэж харагдаад байна.

Нөгөө талаасаа дэгийн тухай хуулийн 74.7 дээр байгаа Төсвийн зарлагын хяналтын хороо улсын төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын төсөл боловсруулж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно гэдэг заалт байгаа. Үүнийг ашиглаасай гэж бодож байна. Яагаад гэхээр энэ гүйцэтгэл хэлэлцэх явцад маш олон асуултууд гарч ирсэн.

Мөн үндэсний аудитаас нэлээн олон том зөрчлүүдийг гаргаж бичсэн байгаа юм. Тэгэхээр хэн хариуцлага хүлээх юм, энэ зөрчлүүдийг яаж арилгах юм гэдэг ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан сайд хариулъя. Нийгмийн даатгалын тогтолцоотой холбоотой асуудал.

**Л.Энх-Амгалан:** Уянгахийг гишүүн ээ, ийм байгаа. Нийгмийн даатгалын багц хууль шинээр батлагдаж гарсан. Тэгээд 1 сарын 1-нээс ингэж хэрэгжиж байгаа. Тэгээд сая энэ хаврын чуулган өнгөрсөн парламент бас тарахаас өмнө ерөнхийдөө нөгөө шинэ хууль гараад олон журмууд шинэчлэгдэж байгаа. Тэр юуны журмуудын хүрээнд энэ нөгөө Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд байна шүү дээ. Тийм Үндэсний зөвлөлийн ажиллах журам нь өөрөө энэ манай Байнгын хороогоор батлагдах ёстой юм. Би бас энэ байнгын хорооны даргатайгаа бас ярьсан байгаа.

Тэгээд энэ журам батлагдаж байж, нөгөө ажлын алба, тэгээд нөгөө таны асуусан нөгөө олон нийтийн хөндлөнгийн хяналтууд бий болох зохицуулалтууд нь энэ журмаар бий болох юм. Тэгээд энэ нөгөө хаврын сая нөгөө шинэ чуулган эхлээд ингээд нэг цөөхөн хоног бид нар чуулж байгаа. Тэгээд манай Байнгын хороо хамгийн түрүүнд батлах ёстой энэ журам бол энэ журам батлагдахаар тэр олон нийтийн хяналт

дор энэ тогтолцоонууд нь бий болно гэж ойлгож болно. 1 дүгээрт.

2 дугаар асуудал бол яг одоогийн байдлаар бид нар арилжааны банканд ингээд нэг их байршуулчихсан, хүү багатай байршуулчихсан, хүүгүй байршуулчихсан юм байхгүй. Яагаад гэвэл өөрөө энэ нийгмийн даатгалын сан чинь өөрөө алдагдалтай байгаа шүү дээ. Ерөөсөө 1 нөгөө 1 сарын тэтгэвэр дараагийн сарынхаа тэтгэврийг тавих хугацаанд л тухайн нөгөө банкнууд дээр байгаад нөгөө дансны чөлөөт үлдэгдлүүд л байгаад байгаа юм. Түүнээс биш нөгөө хүүлээгүй байхгүй юу. Хүүлэх угаасаа бололцоогүй гэсэн үг. Урьдынх шиг нөгөө нэг 6 сараар, бүтэн жилээр, 2 жилээр арилжааны банкнуудад тавьж хүүлдэг ийм тогтолцоонд бид нар одоогийн сүүлийн үед бид нар ийм тогтолцоонд ийм юу гүйлгээнүүд хийгдээгүй байгаа гэж би хариуцлагатайгаар хэлье. Хариуцлагатайгаар.

Өмнө нь гарсан гашиун сургамж байна. Та бас хэллээ. Өнөөдөр энэ Чингис Хаан банк, Капитал банканд бараг үндсэндээ том эрсдэлд орчихсон 163 тэрбум төгрөгийн эрсдэл байгаа гэлээ. Гэхдээ өнөөдөр Чингис хаан банк чинь дампуурлаа зарлаагүй байгаа шүү дээ. Монголбанк тэр дампуурлаа зарлагдаагүй энэ Чингис хаан Банк. Чингис хаан банк бол шинээр хөрөнгө оруулагч нар орж ирж байгаа юм байна лээ. Миний ойлгосноор, би буруу ойлгоогүй бол. Шинээр хөрөнгө оруулагч нар орж ирэхэд бид нар хамгийн түрүүнд энэ Чингис хаан дээр Чингис хаан банк дээр үүссэн одоо эрсдэлд орчих гээд байгаа 98 орчим тэрбум төгрөгийн асуудал дээр бид нар хэлэлцээрт орё л гэсэн ийм зүйл, саналуудыг бид нар Монголбанканд хүргүүлсэн. Иймэрхүү л байдалтай байгаа юм.

Тийм учраас одоо тийм урьдын тийм гашиун туршлагауд дахиж давтагдахгүй болов уу гэж бас бодож байна. Тэгээд яах вэ, одоо шинэ нийгмийн даатгалын шинэ тогтолцооны шинэчлэл

эхэлж байгаа. Сая Засгийн газрын өчигдөр бид нар батлуулж авсан мөрийн хөтөлбөр дээр энэ нийгмийн даатгалынхаа тогтолцоог бид нар тогтолцооны шинэчлэл хийнэ. Нийгмийн даатгалынхаа тэтгэврийн сангийнхаа алдагдлыг бууруулах энэ тогтолцооны бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж гэж бодож байгаа.

Тэгээд энэ чиглэл рүү бид нар ирэх 2, 3 жилд нэлээн тийм дорвитой арга хэмжээнүүд хийнэ л гэж төлөвлөж байна.

**Д.Амарбаясгалан:**

Гончигдоржийн Уянгахишиг гишүүн тодруулж асууя.

**Г.Уянгахишиг:** Тэр 2 банк дээр байгаа эрсдэлд орчихсон байгаа гэж байгаа хөрөнгө байгаа шүү дээ. Тэгэхээр түүн дээр ер нь яг тэр хадгалуулсан мөнгөнийхөө хэмжээгээр яваад байна уу? Түүн дээр бас хүү бодож байгаа юу? Өгөөж тооцож байгаа юу? Алдагдсан боломж тооцож байгаа болов уу?

**Д.Амарбаясгалан:** Тодруулж хариулъя Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Ямар ч байсан Капитал банк дээр анх тохирсон, байршуулсан үнэ юу, хадгаламж бол 120 орчим тэрбум төгрөг хувааж байршуулсан юм байна лээ. Тэндээс үндсэндээ хүү тооцсон хүүгийн юу нь 30-аад тэрбум төгрөгийн хүү авсан юм байна лээ. Тэгэхээр үндсэндээ 150 болж байгаа биз. Ингээд 150-аасаа 60-аад тэрбум төгрөг нь юуны 150-аасаа одоо 100-г нь барагдуулаад, одоо бол тэр нөгөө юун дээр Капитал банк дээр 60-аад тэрбум төгрөгийн үлдэгдэл үлдсэн байна. Тэр юунаас бид нар хүү тооцож байгаа. Авлага талдаа бүртгэж авч байна гэсэн үг шүү дээ, бид нар тийм ээ. Одоо Чингис хааны Чингис хаан банк дээр байршуулж байгаа 98 тэрбум төгрөг дээр ч гэсэн бид нар тэр хүүг тооцож, бид нар нөгөө талдаа авлага талдаа бүртгэлжүүлээд ингээд явж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Энэ чинь Энх-Амгалан сайд шүүхийн шийдвэрийн асуудал байгаа тийм ээ, тийм. Тэгээд 1 шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл дээр энэ Алтангэрэл сайд аа, нэг шүүхийн шийдвэр ялгавартай гүйцэтгээд байгаа энэ нэг байдлыг таслан зогсоохгүй бол энэ нийгмийн даатгалын сангийн хөрөнгө шамшигдуулсан асуудал хүртэл шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл дээр л асуудал нь өнөөдрийг хүртэл гацаж байна шүү дээ, 4 жил. Тийм ээ. Одоо Жавхлан сайдтай бас саяхан ярьж байсан. Төр өөрөө шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд хойрго хандаад байна.

Ирэх оны төсөв дээр энэ нэг иргэдийг, ААН-үүдийг хохироочихсон төрийн буруутай шийдвэрээс, төрийн албан хаагчдын буруутай үйлдлээс болоод хохирчихсон тэр асуудлыг нэг мөр шийдэх байдал дээр анхаарахгүй бол ялгавартай, ялгамжтай шийдвэр гаргаад байна. 80 гаруй тэрбум төгрөгийн өглөтэй мөртөө жил болгон нэг бага хэмжээний төлбөр тавьчихдаг. Тэр төлбөрийг хэний шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхийг Хууль зүйн сайд шийдэж байгаа байдал чинь л өөрөө зохимжгүй шүү дээ.

Яагаад 10 жил болчихсон өр төлбөрийг нь шийдэхгүй, өнөөдөр үүссэн өр төлбөрийг нь шийдэж байна гэдэг чинь бусдад давуу байдал бий болгож шийдвэр гүйцэтгэл хандаад байгаагийн л хэлбэр. Яг нийгмийн даатгалын энэ төлбөртэй холбоотой асуудал мөн адил.

Энх-Амгалан сайд тодруулж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Үгүй ээ, харин нэг 1 зүйл ерөөсөө би ойлгоогүй. Ямар зүйлийг ойлгоогүй вэ гэхээр ингээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан дээр ингээд энэ юунууд чинь очиж байна шүү дээ, энэ шийдвэр гүйцэтгүүлэх ёстой. Тэгсэн чинь надад хэлсэн тайлбараар би энэ ямар журмаар үүнийг бүр Алтангэрэл сайд энэ дээр нэг анхаарал хандуулах ёстой гэж бодоод байгаа юм. Нөгөө төрийн алдагдалд орсон байгууллагууд, жишээ нь

НДЕГ алдагдалд орчихлоо шүү дээ. Тийм ээ. Нийгмийн тэтгэврийн сан нийгмийн даатгал. Гэтэл нөгөө хувийнх нь юунуудыг хохирлуудыг түрүүнд барагдуулаад, төрийн байгууллагуудад учирсан хохирлыг сүүлд эрэмбээр нь ингээд сүүлд эрэмбэлдэг нэг ийм зохицуулалттай юм гэсэн нэг ийм тэнэг юм яриад суугаад байгаа байхгүй юу. Би тэгээд үгүй яахаараа хувийн компаниудын хохирлыг түрүүлж барагдуулчхаад, төрийн байгууллагуудын хохирлуудыг сүүлд нь барагдуулдаг юм бэ гэдэг энэ ямар хуулийн, ямар журмын, ямар зохицуулалттай юм гэдгийг ерөөсөө ойлгохгүй. Үүнийг Алтангэрэл сайд үүнийг та нэг бас нэг анхааралдаа авч ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Төрийн байгууллагууд ингээд өөрсдөдөө зориулсан журам гаргаад, тэрийгээ хэрэгжүүлэх үү, хэрэгжүүлэхгүй юу гэдэг нь өөрсдийн сонголтын асуудал болоод байгаагийн жишээ байхгүй юу энэ чинь.

Тэгэхээр энэ журам зайлигүй цөөрөх ёстой. Энэ хууль байх ёстой. Албан тушаалтан үзэмжээр асуудалд ханддаг байдлыг ингэж таслан зогсоохгүйгээр энэ асуудал нэг мөр цэгцлэгдэхгүй гэж.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Далайн Батбаяр гишүүн нэмж хариулъя.

**Д.Батбаяр:** Уянгахишиг гишүүний санал болгож байгаа энэ санал маш зүйтэй санал байна. Зарлагын хяналтын дэд хороо илүү өргөн хүрээнд хуулийнхаа хүрээнд ажиллах ёстой гэдэгтэй 100 хувь нь санал нийлж байгаа. Цаг хугацаа маш давчуу байлаа. 2 хоногийн дотор орж ирээд хэлэлцээд хавчигдаад гарч байна. Үйл ажиллагааны хувьд ч гэсэн маш давчуу байлаа.

Ер нь энэ 2023 оны төслийн гүйцэтгэлийг 6 сардаа буюу өмнөх парламентын үед багтаагаад хэлэлцчих ёстой байсан. Түүнийг хэлэлцэж чадаагүй

учраас одоо хэлэлцэж байна. Засгийн газрын бүтэц нь өөр болчихсон. Сайд дарга нар нь солигдсон учраас асуултад тэр болгон хариулж чадахгүй, хуралд тэр болгон оролцож чадахгүй байх шиг байна. Цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байгаа учраас Байнгын хороод дээр ирж оролцож байгаа ажлын хэсгүүд бас оролцоо бас бага байгаа юм шиг ажиглагдсан. Харин хамгийн сүүлийн хурал болох манай дэд хороо буюу Зарлагын хяналтын дэд хороо дээр яг энэ төсөл ерөнхийлөн захирагч ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Далайн Батбаяр гишүүний үгэн дээр нэг зүйл гарч байна шүү дээ. Та бүхэн нэг зүйлийг анхаараарай. Сайд бол яам биш, сайд бол томилогдсон улс төрийн албан тушаалтан. Төрийн ажил залгамжаа хангаж байх ёстой. Тэр асуултад хариулдаг төр байх ёстой байхгүй юу, яам байх ёстой. Тэр яамыг хэн толгойлж, хэн төлөөлж, хэн ажлыг нь хариуцаж явж байгаа вэ гэдэг дээр тодорхой байх ёстой шүү.

Дараагийн удаад энэ Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулахдаа сайд солигдсон учраас, дарга солигдсон учраас гэдэг хариулт тайлбар огт байж болохгүй гэдэгт онцгой анхаар. Ажлаа мэдэж байх ёстой. Мэдэхгүй байгаа бол мэддэг хүн нь ажлаа хариуцаж хийж байх ёстой. Энэ дээр их сайн анхаарна шүү.

Би түрүүн ажлын хэсгийг танилцуулчхаад дараа нь хэлсэн. Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч гэдэг статустай төрийн албан хаагч байж болохгүй. ТАЗ энэ рүү Их Хурлын хяналтын чиг үүргийг гүйцэтгэх зорилгоор ажилдаа орно. Зүгээр, төрийн албаа хашиж байгаа албан хаагчдыг ямар нэгэн байдлаар шалтгаан тооцож, шалтаг тоочиж, ажил байдлыг нь өөрчилдөг байдлыг бас таслан цогцлоох ёстой. Энэ дээр Улсын Их Хурал, ТАЗ анхаарал тавьж ажиллана шүү гэдгийг бас энд хэлье.

Дараагийн гишүүн асуултаа асууя.  
Ганзоригийн Лувсанжамц гишүүн  
асуултаа асууя.

**Г.Лувсанжамц:** Сайн байцаана уу. Бусад гишүүдийн асууж байгаа асуулттай агуулгын хувьд ойролцоо зүйл асуух гэж байгаа юм. 2023 оны төсвийг харахаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо, хэмжээний үзүүлэлт гээд 1 дүгээр хавсралт байгаа. Энд ингээд бүх яамнуудаараа ингээд ямар зорилт тавьсан, ийшээгээ хүрнэ гээд, хувь байна уу, чанар байна уу, тоо байна уу ингээд тавьчихсан байгаа юм л даа.

Тэгээд ингээд төсвийнхөө гүйцэтгэлийг ингээд тайлан тавиад ороод ирэхээрээ зүгээр ингээд нэг хүснэгт гаргаад ирэхээр нь би ерөөсөө ойлгохгүй байна л даа. Үр дүнг чинь хэмжихийн тулд бид нар хүснэгт хараад 1 тэрбум төгрөг төсөвлөсөн юм байна. Үүнийгээ хэрэглээд дуусчихлаа. 100 хувийн хэрэгжилттэй энэ амжилт гэж байгаа юм шиг харагдаад байна л даа. Ерөөсөө ингээд байшин барих ч юм уу, эсвэл нэг үйл ажиллагаа хийгээд тууз хайчлах нь ингээд хийх ёстой ажил юм шиг харагдаад байгаа юм.

Бид нарын ингээд Алсын хараа 2050 дунд хугацааны хөгжлийн бодлого, 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үүний хэрэгжилт нь яг хэдэн хувьтай яваад байгаа гэсэн тийм тайлан, дүгнэлт ерөөсөө харагдахгүй байна. Үүнийг Үндэсний аудитын газар гаргадаг юм уу, эсвэл яамнууд нь тус тусдаа гаргаад тайлагнах ёстой байдаг юм уу. Сайн мэдэхгүй байна.

Гэхдээ ингээд юу гэх юм, ингээд нэг байшин барилаа, ок гээд. Яг ингээд боловсролын хүртээмж дээшилсэн юм уу, боловсролын чанар сайжирсан юм уу, багш нарын сургалт хийлээ, ийм юм хийлээ, сургууль, цэцэрлэг барилаа гээд уг нь ингээд сайн үр дүн гарсан зүйлүүд байгаа шүү дээ. Жишээлбэл цэцэрлэг

сугалаагүйгээр явдаг болсон, цэцэрлэгт. Нийслэлд 3 ээлжээр хичээллэдэг сургууль ЕБС байхгүй болсон гээд энэ чинь яг үр дүнгээ ингээд олон нийтэд тайлагнах бодитой харагдаж байгаа. Амьдрал сайжирч байгаа, нийгэм сайжирч байгаа үр дүн байтал байшин барьсан л гээд л ороод ирдэг.

Тэгээд ингээд Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороон дээр ХХААЯ-наас асуусан чинь нэг танин мэдэхүйн шинж чанартай хариулт хэлээд, ингээд 117 тэрбум төгрөгийн татаасыг хаана олгосон юм бэ. Ингэснээрээ орон нутагт ажлын байр нэмэгдсэн юм уу. “Эрүүл Монгол” үндэсний хөтөлбөр дээр хүнсний аюулгүй байдлыг ингээж сайжруулна гэсэн тийм зорилтууд тавьсан. Тэр нь ингээд хүрч байгаа юм уу гэсэн асуулт асуухаар ингэнд мөнгийг нь шилжүүлдэг юм. Ингээд иргэд авсан. Малчдын дансанд нь мөнгө нь орсон гээд ийм тайлан тавиад боломжгүй л гээд энэ улс хөгжихгүй л гэж би бодоод байна л даа.

Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гээд 2020 он гээд батлаад л хийгээд л явж байгаа. Тэгээд эдгээр зорилтуудтай бид нар хэр ойртсон юм бэ гэдэг зүйлүүдийг ерөөсөө ингээд ярихгүй байна. Тэгээд тавьсан мөнгө нь бага байсан ч гэх юм. Тэгээд асуудал гараад зогсчихсон гэх юм. Тэгээд эсвэл үүнийгээ бүгдийг нь хэрэгжүүлээд дуусчихсан бүгдээрээ гоё сайн ажиллалаа гэсэн нэг тийм би ерөөсөө жоохон ойлгохгүй байна. Яг мэргэжлийн хүний хувьд бол.

Төлөвлөлт, төсөвлөлт гэдэг чинь үр дүн дээр суурилсан байх ёстой шүү дээ. Хөгжлийн бодлогын бичиг баримтууд дээр байгаа зорилтууд дээрээ бид нар хэрхэн хүрч байгаа юм бэ. Нэг алхам урагшилсан юм уу, хойшилсон юм уу гэдэг зүйлүүд дээр байгаа шүү дээ.

Утааны асуудал дээр бас адилхан. Ингээд аягүй их мөнгө ингээд утаан дээр тавиад утаа бууруулахад зарцуулж байна гээд тавиад байдаг. Үр дүнгээ ерөөсөө ярьдаггүй. Тэдэн тонн сайжруулсан нүүрс

ингээд үйлдвэрлэсэн, тэдэн хүнд тараасан, тэдий хэмжээний мөнгө зарлаа гээд. Үгүй шүү дээ, утаа хэр буурч байгаа юм бэ гэдгийгээ бид нар хэмжээд, түүнийгээ бодитоор яриад үр дүнд хүрч байна, үгүй байна гэдгийгээ яриад тэгээд ирэх жилийнхээ төсөв дээрээ энэ үр дүнгээ хэрхэн сайжруулах юм бэ гэсэн зүйлээ ярилцаад явах ёстой байтал ингээд тоо л яриад л, хүснэгт яриад л ийм ерөөсөө ингээд нэг тийм ийм байдлаар ерөөсөө хяналт хийх боломжгүй гэж бодож байна л даа.

Одоо удахгүй 2025 оны төсөв орж ирнэ. Энэ дээр дунд хугацааны, урт хугацааны бодлогын бичиг баримтын зорилтууд хэрхэн биелэх юм бэ гэдэг зүйлээ энэ 1 дүгээр хавсралт дээрээ бичиж орж ирээд танилцуулаасай гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** ХХААЯ-наас хариулна, тийм ээ. Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн 1 дүгээр индрээс хариулъя.

**Т.Жамбалцэрэн:** Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нэгдсэн төсвийн нэг 2,9 хувьтай байдаг. 23 оны ...

**Д.Амарбаясгалан:** Микрофондоо ойрхон ярья. Сонсогдохгүй байна.

**Т.Жамбалцэрэн:** 23 оны төсвийн жилд нэг 490 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Үүний 50 хувь нь нь буюу татаас урамшууллын зардлууд байгаа. Татаас урамшууллуудын зардал гээд ингээд үзэхээр Засгийн газраас олгогдож байгаа хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хөнгөлөлтүүд, Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэртэй урамшууллууд тусгагддаг. Энэ дотроо хамгийн том өндөр дүнтэй байгаа нь “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ байгаа.

Өнгөрсөн жилийн дүнгээр арилжааны банкны, 23 оны дүнгээр арилжааны 10 банктэй гэрээ байгуулаад нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр олгогдсон. Энэ хүрээндээ нийтдээ 832,7 тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр гаргасан. Энэ дотроо 49 хувь нь эргэлтийн хөрөнгө, 51 хувь нь хөрөнгө оруулалтын зээлийн ийм дүнтэй байгаа.

Хүрсэн үр дүн нь гээд ингээд аваад үзэх юм бол нийтдээ нэг 12300 орчим ажлын байрыг хадгалж, 1200 гаруй шинэ ажлын байрыг бий болгосон байна. Татварын орлогыг 133,1 тэрбумаар буюу өнгөрсөн оныхоос 30,2 хувиар өссөн ийм дүнтэй.

Импортын хамаарлыг бид нар нэг 15-16 хувиар бууруулж чадсан. Жилдээ бид нар тэрбум долларын хүнсний бүтээгдэхүүнийг импортоор авдаг байсан бол өнгөрсөн 23 оны жилийн эцсийн дүнгээр бид нар нэг 820 сая долларын ийм хүнсний бүтээгдэхүүнийг импортоор авсан. Ийм үр дүнтэй байгаа.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэх зорилготой “Цагаан алт” хөтөлбөрийг Монгол Улсын Их Хурлаас баталж, хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Дээр нь шинэ малчин, “шинэ хоршоо, чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаж байгаа. Энэ хөтөлбөрүүд маань хоорондоо нарийн уялдаатай. Нэг ёсондоо анхан шатын түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооноос нь боловсруулах үйлдвэрлэлийн түвшинд нь хэрэгжүүлж ажиллаж байгаа. Энэ хүрээндээ Монгол Улсын Засгийн газраас хүүгийн хөнгөлөлтийг арилжааны банкны эх үүсвэрээр л зээлийг олгож явж байгаа ийм үзүүлэлттэй байгаа.

Дээр нь малчдыг нөгөө болзошгүй эрсдэлээс хамгаалах гэдэг юм уу, малчдын

зээлийг хойшлуулах, сүүний урамшуулал, арьс ширний урамшуулал гээд эдгээр урамшууллууд төсвийн тухайн төсвийн жилд суугдсан хэмжээндээ татварын нэгдсэн систем дээр уялдуулсан үр дүнгийн үзүүлэлтээр нь л үнэлэгдээд, энэ тухайн урамшууллууд нь олгогдоод явж байгаа.

Энэ хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дүнгүүдийг нэг бүрчлэн салбараар нь эдийн засгийн өсөлтийнх нь хувь дүнтэй бас танд албан бичгээр бас хүргүүлье. Баярлалаа

**Д.Амарбаясгалан:** Ганзоригийн Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

**Г.Лувсанжамц:** Хариулт өгсөнд баярлалаа. Үр дүнгүүдээсээ сая яг та тодорхой зүйлүүдийг дурдлаа. Баярлалаа.

Би нөгөө яг гол чухал гэж бодоод байгаа зүйл болохоор хэдүүлээгийнх нь хөгжлийн бодлого дээр тавьсан зорилтууд хэдэн хувьтай биелж байгаа юм бол оо? 2024 он хүртэлх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээр танай яам, би нөгөө танай яамыг яаж байгаа юм биш, шарж байгаа ч юм биш. Зүгээр бусад яамнууд ч гэсэн адилхан зүйл дээр ажиллаасай гэж бодож байгаа болохоор би ингээд хэлээд байгаа юм. Яг ингээд хэдэн хувийн биелэлттэй байгаа юм бэ гэдгийгээ ингээд хэдүүлээ харилцан хараад тийм ээ, тэгээд тийшээ 70 хувийн гүйцэтгэлтэй байна гэсэн зүйлээ л би хэдүүлээ хийе гэсэн тийм санаагаар хэлж байгаа юм шүү.

Тэгээд өөр бас манай Боловсролын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ тэр чинь аягүй том урсгал зардалтай 2 том яам байгаа шүү дээ, тийм ээ. Яг нийгмийн амьжиргаа сайжирч байгаа юм уу, үгүй юм уу гэдгийгээ бас энэ үр дүн дээрээ суурилсан байдлаараа төлөвлөөд, төсөвлөөд, хэдий хэмжээг нь бид нар хүрч байгаа юм бэ гэсэн зүйлээ тайлагнаасай гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулах уу. Жамбалцэрэн дарга аа, ХХААЯ энэ шинэ хоршоо хөдөлгөөнийг зөвхөн МАА-н бодлого гэж хараад байгаагаа бас залруулах шаардлагатай харагдаж байна лээ шүү. Бас энэ төсөв төлөвлөгөөтэй холбоотой асуудал дээр. Бусад салбарын сайд нар ч гэсэн зөвхөн ХАА-н салбарын асуудал юм шиг бодоод байгаа.

Гэтэл энэ шинэ хоршоо хөдөлгөөний чинь цаана хөдөөгийн хүн амын төвлөрөл, хөдөөгийн ард иргэдийн амьжиргааны түвшин дээшлэх, ядуурлын бууруулах гээд олон зүйлүүд энэ дунд байгаа гэдгийг өргөн хүрээгээр нь харж хандаж, асуудлыг авч явах ёстой шүү.

Өмнө нь ЗГХЭГ авч явж байсан гол утга учир нь салбар дундын зохицуулалт, бүх салбарын бодлого нэг дор төвлөрөх ёстой гэдэг агуулга дээр явж байгаа.

Тэгэхээр бусад салбарын сайд нар ч гэсэн зөвхөн ХАА-н сайдын асуудал гэж орхиж ерөөсөө болохгүй шүү гэдгийг бас зориуд сануулж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууна.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Өнөөдрийн энэ хуралдаан маш чухал хуралдаан. Яагаад гэвэл үсээ зулгааж байж олсон мөнгөнөөсөө татвар төлдөг. Татвар төлөгчдийн мөнгийг энэ улс төрчид маань хэрхэн зарцуулж байгаа, нэр нүүрээ бараад гаднаас зээл, тусламж авчирч ашиглахдаа мөн яаж зарцуулсан тухай хэлэлцэж байна.

Тэгээд энэ чухал ажил ямар байв, санхүүгийн сахилга бат ямар байв, цаашид яах юм болов оо гэдгийг хэлэлцэж байгаа энэ чухал хуралд яагаад дэгийн тухай хуулиараа Ерөнхий сайд маань суухгүй байгаа юм бэ? 74.3 гээд түрүүн маш тодорхой хэлсэн шүү дээ. Уянгахыг гишүүн. Суух ёстой юм байна. Болно ч биш бүр суух ёстой гээд.

Яагаад гэвэл Ерөнхий сайдын ажлын гүйцэтгэл гэсэн үг.

Тэгэхээр Ерөнхий сайдыг дуудаж ирүүлэх нь зүйтэй гэж бодож байна. Яагаад гэвэл энд маш ноцтой ноцтой зүйлүүд маш их байна. Тэгээд хурал болгон дээр асуугаад байх бас хаашаа ч юм. Яах вэ ямар ч байсан асуухыг нь асуугаад явъя.

Бараа, материал гээд энэ төрөл жишээлбэл 73,8 тэрбумын бараа, материалыг илүү авсан байна. Хэрэггүй шахам материал авсан гэсэн ийм тодорхойлолттой. Тэгээд үүнээс бараг 90-ээд хувь нь УУХҮЯ буюу 65,9 хувь. 65,9 тэрбум төгрөгийн илүүдэл, хэрэггүй, хугацаа нь дууссан бараа авсан байна.

Тэгээд энэ ямар бараанууд юм бэ. УУХҮЯ ямар бараа авсан юм бэ?

ЭМЯ-наас би өчигдөр асуусан чинь Ковидын үеэр авсан бараа, арга байхгүй юмыг яаж мэдэх вэ гээд илүү авчихсан юм гэж тайлбарласан. Тэгээд нөгөө муу л бол хойд талын бор овоохой гэдэг шиг Ковид руу чихээд өнгөрсөн.

УУЯ-нд ковид ямар хамаатай байсан юм бол оо, 1.

2-т, энэ анхан шатын баримт байхгүй, хүчин төгөлдөр бус баримтаар мөнгө төгрөг олгосон асуудал гээд 256,3 тэрбум төгрөг. Энэ асар их мөнгө шүү дээ. Тэгэхээр энэ яаж олгочихсон гэсэн үг вэ? Баримтгүй байхад л ингээд мөнгө олгоод байдаг юм уу? Яагаад байдаг юм бэ? Энэ маш ноцтой зөрчил гэж би хувьдаа харж байгаа. Ингээд баримтгүйгээр ийм олон тэрбумын төгрөг гаргаад яваад байх юм бол энэ төр засагт ер нь хяналт гэж байгаа юм уу, байхгүй юм уу? Энэ ер нь ямар ч замбараагүй явж байгаа юм биш үү гэж бодогдохуйц байна.

Дээрээс нь Монголбанкнаас асууя. 1,3 их наяд төгрөгийн Ирээдүйн өв сангийн дансанд байршуулсан байгаа юм. Тэгээд хүү тооцоогүй гэж хэлсэн байна,

бичсэн байна л даа, энд. Тэгээд хүү тооцох ёстой юм биш үү? Наад зах нь нөгөө бодлогын хүүгээр тооцоолоод 12 хувиар ингээд тооцоолоод байршуулахад л энэ чинь 156 мянган тэрбум төгрөг байх ёстой байгаад байна. Үүнийг нь дахиад 320 хүүхдийн сургуулиар бодохоор 22 сургууль гарч байна гээд. Тэгэхээр яагаад энд хүү тооцоогүй юм бол оо гээд.

Манай Монгол Улс чинь ерөөсөө бүхэлдээ төрийн өмчит ХК, төрийн өмчит үйлдвэрийн газруудын улс болчихжээ. Бид бүхэн маш сайн мэдэж байгаа. Нийт актив нь маш их өндөр байдаг. Тэгээд энэ аудитад бас ийм юм байна. 5,1 их наяд төгрөгийн урьдчилгаа эцсийн үлдэгдэл гэж байгаа юм. Тэгээд үүний 82,2 хувь нь бас л нөгөө төрийн өмчит үйлдвэрийн газруудад байршиж байна гэж байгаа юм. Энэ ямар учиртай мөнгө юм бол оо? Ийм их хэмжээний их наяд төгрөгөөрөө ингээд урьдчилгаа болгоод байршуулчихсан байгаа юм уу? Эсвэл эцсийн үлдэгдэл гээд байгаа юм уу? Энэ ямар дүрэм журмаар ийм их мөнгө ингээд байршуулчихсан, урьдчилгаа болгоод байж байдаг юм болоо гээд.

Тэгээд бас нэг юм энд хэлье л дээ. Бүлэг 3 гээд. Төсвийн нийт зардалд эзлэх урсгал зардлын хэмжээ сүүлийн 5 жилийн дунджаар 76,9 буюу бараг 77 хувьтай гэж байгаа юм. Тэгээд энэ ингэж дүгнэсэн байгаа юм. Энэ нь өөрөө төсвийн үр ашгийг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, дунд болон урт хугацааны бодлоготой уялдахгүй байна гээд. Энэ маш ноцтой дүгнэлт гэж би харж байна.

Нөгөө нэг дунд болон урт хугацаандаа ингэнэ, тэгнэ гээд ингээд баахан бодлого боловсруулаад гаргачихсан 2050, бишгүй олон баримт бичигтэй шүү дээ, бид нар. Тэр бүгдийг чинь энэ урсгал зардлын чинь дүн ерөөсөө хангахгүй, уялдахгүй, болохгүй байна гэж дүгнэсэн байна шүү дээ.

Тэгэхээр энэ ер нь олон улсын жишигт яаж явдаг юм бэ? Энэ төсвийн



нийт зардал дахь эзлэх урсгал зардлын хувь, хэмжээ ямар байх ёстой юм бэ?

**Д.Амарбаясгалан:** Өнөөдөр 2025 оны улсын төсвийг өргөн барих сүүлийн өдөр байгаа, ажлын. Тийм учраас Засгийн газар бас ээлжит бус хурлаа хийж, төсвийн төслөө хэлэлцэж байгаа юм байна.

Тэгэхээр Ерөнхий сайд, зарим асуудал хариуцаж байгаа сайд нар чуулганы хуралдаанд бас бүтэн суух боломжгүй байгаад байгаа гэдгийг бас тайлбар ирүүлж байгаа.

Гэхдээ өнөөдөр бас энэ төсвийн гүйцэтгэл орж байгаа учраас яг холбогдох хариулт өгч чадах албан тушаалтнууд энэ танхимд байгаа гэж ойлгож байгаа.

Би түрүүнд хэлсэн шүү. Сайд солигдсон учраас гэдэг тайлбар хэзээ ч байж болохгүй. Харин тэр ажлаа мэдэж байна уу, мэдэхгүй байна уу л гэдэг асуудал үүнийг дагаж гарч ирж байх ёстой.

Энэ дээр нэмж хэн хариулт өгөх вэ. Жудагийн Баярмаа гишүүний асуултад хариулах хүн, хэн байна? Хариулт өгөх хүн байхгүй юу.

Харин тийм. Аудит хариулах уу. Хариулт өгөх хүн байна уу?

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Далайн Батбаяр гишүүн хариулна.

**Д.Батбаяр:** Энэ Баярмаа гишүүн Үндэсний аудитын газрын гаргасан дүгнэлттэй холбоотой тоо, хэмжээтэй асуулт асуусан учраас манай Аудитын газрын дарга Загджав дарга хариулчихъя.

**Д.Амарбаясгалан:** 2 дугаар индрээс хариулт өгье. Наранчимэг Тэргүүлэх аудитор хариулт өгөх юм байна. 2 дугаар индэр.

Баярмаа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар гарч байгаа энэ зөрчлүүд дотоод аудит буюу дотоод хяналт хангалтгүй ажиллаж байна гэж аудитын байгууллагаас ерөнхийд нь дүгнэж байгаа.

Төрийн аудитын байгууллагаас хийж, Улсын Их Хуралд хүргүүлж байгаа Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн аудитаар дотоод аудитын эрх зүйн орчинтой буюу хуультай болохыг Улсын Их Хуралд 3 удаа толилуулсан. Дотоод хяналт сайтай байгууллагад ямар нэгэн алдаа зөрчил гарахгүй байх бүрэн боломжтой.

Тийм учраас дотоод хяналтыг сайжруулах эрх зүйн орчныг бий болгоосой гэж энэ Их Хурлаас төрийн аудитын байгууллага буюу Монгол Улсын Ерөнхий аудитор бас Улсын Их Хуралд толилуулж байгаа.

Урьдчилгаа дансанд байгаа үлдэгдэл бол яг ном журмынхаа дагуу стандартаараа санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаараа зөв бүртгэгдээд тайлагнаад явж байвал энэ санхүүгийн тайланг баталгаажуулж байхад зөрчил бол биш.

Гэхдээ урьдчилгаа дансанд байгаа үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүй. Олон жил явж байгаа энэ урьдчилгаа дансныхаа авлагыг барагдуулж ажиллахгүй ийм асуудлууд байгаад байгаа учраас аудит энэ ажлаа хийгээч гэдгийг нийт урьдчилгаа дансны үлдэгдлийн 82,2 хувийг төрийн болон орон нутгийн өмчит компаниуд эзэлж байгаа учраас энэ талаарх зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлээд ажиллаж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Туваан сайд харин нэмж хариулъя.

**Ц.Туваан:** Баярмаа гишүүний асуултад хариулъя. Энэ аудитаас гаргасан дүгнэлт дээр энэ бараа материал хэрэглээнээс илүү бэлтгэсэн гээд энэ ангилал дээр нийтдээ 73,8 тэрбум төгрөгөөс манай яам дээр 65,9 тэрбум төгрөг байна. Энэ яамны хувьд төрийн өмчит 24 компанитай холбоотой энэ аудитын асуудал манай яаман дээр гардаг.

Тэгэхээр энэ дээр бас нэг ийм гажуудал яваад байгаа юм. Юу гэхээр аудитын дүгнэлт болон бодлого нь хуучнаар Уул уурхай хүнд үйлдвэр, одоогийнхоор Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яам дээр явдаг. Бусад бүх асуудал нь нөгөө төрийн өмч гээд өмчийн компаниуд буюу ЗГХЭГ дээр яваад байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг бас энэ 24 төрийн өмчит компаниудын хувьд худалдан авсан бараа бүтээгдэхүүний дүн байна. Тэгэхээр ямар компани дээр хэд хэдэн төгрөгөөр илүү худалдан авалт хийсэн, энэ дүгнэлттэй холбоотой асуудлыг компани, компаниар нь тодруулаад ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жудагийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

**Ж.Баярмаа:** Дансанд 1,4 их наяд билүү, мөнгийг яагаад хүү тооцдоггүй юм бэ гээд. Ингээд уг нь асуултууд байна. Тэгээд хариулах хүн олдохгүй л юм шиг байна л даа. Тэгээд.

**Д.Амарбаясгалан:** 2 дугаар индэр дээрээс Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван нэмж хариулна.

**Г.Энхтайван:** Баярмаа гишүүний асуултад хариулъя. Ирээдүйн өв сантай холбоотой асуудал бол Ирээдүйн өв сангийн тухай хуулиар зохицуулагдаад явдаг. Өнгөрсөн 23 оны 12 дугаар сард Төв банк дахь Ирээдүйн өв сангийн дансанд 200 сая доллар орж ирсэн байгаад байгаа. Яг одоогийн байдлаар үлдэгдэл 550 сая долларын үлдэгдэлтэй байна. Ирээдүйн өв

сангийн дансны үлдэгдэлд хүү тооцох асуудлыг Монголбанк Засгийн газар хооронд гэрээгээр зохицуулдаг. Төв банкны зүгээс Засгийн газарт гэрээний драфтыг хүргүүлсэн байгаад байгаа. Засгийн газар энэ 9 дүгээр сард гэрээ дээр саналаа илэрхийлээд, гэрээ байгуулагдаад явахаар Ирээдүй өв сангийн дансанд, долларын дансанд нь хүү тооцогдоод явна.

**Д.Амарбаясгалан:** Дахиж тодруулах юм уу? Жудгийн Баярмаа гишүүн дахиж тодруулъя гэж байна. Хариулт хангалтгүй байна. Хариулт өгч байгаа хүмүүс тодорхой хариулъя.

Баярмаа гишүүний микрофон 1 минут.

**Ж.Баярмаа:** Яах вэ, тодруулмаар ч юм уу, яамаар ч юм, ямар ч байсан Засгийн газартай гэрээ явуулж байж хүү тооцох ёстой. Гэрээнийхээ төслийг явуулсан боловч хариу ирээгүй юм байна л даа, Засгийн газраас гэж ойлголоо.

Тэгээд яах вэ, ер нь хавар хэлэлцэх ёстой байсан тийм ээ, энэ төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланг. Тэгээд нөгөө хуваарилалт нь шог байна гэдэг шиг энэ чинь дараалал нь эсрэг болчхоод их сонин юм болоод байна л даа. Зүй нь бол энэ гүйцэтгэлийн аудитаа харж байгаад юу нь буруу, юу нь зөв, ямар үргүй зардал гарсан, яасан ийсэн, үүнийг нь маш сайн ойлгож шүүсийг нь шахаж байгаад дараа нь төсвийнхөө тодотголыг уг нь хийх байсан юм.

Тэгээд одоо эсрэг ингээд дараалал нь буруу явчихаар чинь бид нар аль хэдийн тэр тодотголоо ингээд баталчихсан шахуу явж байдаг. Гэтэл араас нь ингээд маш их маапантай зүйлүүд орж ирж байгаад харамсаж байна. Гэтэл хавар маш их хуулийг баталсан байдаг шүү дээ. Нэг өдөр бараг 200 хууль нэмэлт, өөрчлөлт оруулсан гэдэг ч билүү. Гэтэл ийм чухал татвар төлөгчдийнхөө мөнгийг хэрхэн зүй зохистой, эсвэл буруу зөрүү зарцуулж байгаагаа л бид нар маш

нухацтай хэлэлцэж баймаар байна, цаашид. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх асуудал хариуцаж байгаа сайд бас яг энэ дээр, энэ гишүүдийн хэлж байгааг их сайн анхаарах ёстой шүү. Энэ тайлагнал, үнэлгээ, мониторинг гэдэг зүйлүүдийг яг бид мэргэжлийн түвшинд хийж чадахгүй байгаагийн тод илрэл яг энэ дээр явж байгаа юм. Яаж тайлагнаад байгаа юм тийм ээ. Энэ тайлагнал нь өөрөө Улсын Их Хуралд орж ирж байгаа процесс нь ямар түвшинд явж байна, мэргэжлийн түвшинд байна уу, үгүй юү гэдэг асуудал үүнийг дагаж гарна шүү.

Тэгэхээр Засгийн газар яг энэ гүйцэтгэлтэй холбоотой асуудал дээр ирэх жилүүдэд, ирэх чуулганы хуралдааны асуудал дээр онцгой анхаарч хариуцаж ажиллах нь байна шүү. Мэргэжлийн түвшинд ажиллах нь байна шүү гэдгийг л анхаарах хэрэгтэй.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна. Тэгээд санал хураалт явагдана.

**С.Эрдэнэбат:** Түрүүн бас чухал асууя гэж байсан юм, асуучихлаа. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүдийг маш тодорхой болгомоор байгаа юм. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүдийг зөвхөн аудит болон Их Хурлын гишүүд, бүтцийн байгууллагууд дүгнэхээс гадна тэр хөрөнгө оруулалт, тэр бий болсон тухайлбал сургууль барих юм бол тэр сургуульд нь сурч байгаа сурагч, эцэг эх, багш, эмнэлэг барих юм бол тэр ажиллаж байгаа эмч нар, үйлчлүүлэгч нар нь тодорхой дүгнэлт, үнэлгээ өгдөг ийм систем рүүгээ цаашаа явах хэрэгтэй болов уу гэдгийг бас хэлмээр байна.

Дахиад бас хэлэхэд, тэр нийгэм, эдийн засгийн дан болон шууд нөлөөллүүдийг нь бид нар бас давхар үнэлдэг баймаар байгаа, хэрэгтэй байгаа юм. Түрүүн бас Их Хурлын дарга хэллээ. Хоршоолол гэдэг чинь өөрөө цаанаа маш

олон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг давхар бас цаанаа бодлогын хувьд авч явдаг гэдэгтэй ижилхэн.

Боловсролын юун дээр бас хэлмээр байна. Энэ өчигдөр юу харж байхад Боловсролын зээлийн сангаар ер нь сурсан хүмүүс аваад ирэхээр багш нар маань бараг байдаггүй юм байна лээ шүү дээ, энэ дээр. Тэгэхээр бараг үүнийг өмнө нь бас Засгийн газарт бас тодорхой санал хүргүүлж байсан. Ирэх жилүүд дээр ерөөсөө тэр боловсролын зээлийн сангийн 50 хувь нь нь зөвхөн энэ багш нартаа зориулаад, тэр гадаад дотоодод сургадаг, хөгжүүлэхгүй бол англи хэлний хөтөлбөрийг бид нар баталчихсан. Тэр хэлийг чинь заах хүн тэр орчинд нь өөрийнхөө ур чадварыг сайжруулахад маш олон энэ ялангуяа энэ хөдөө орон нутаг, зах хорооллуудад ажиллаж, амьдарч байгаа энэ багш нарыг системтэйгээр сургах юмыг бодлогоор оруулж ирээч. Ингэх боломж бий юу гэдгийг Боловсролын сайдаас асуумаар байна.

Монголбанкнаас түрүүн бас дахиж хэлмээр байна. 3 хувь нь олон улсын жишиг байдаг гэж. Харилцахын хүүнүүдэд 3 хувь нь гэдэг манай улсын өөрөө бодлогын хүү, эргээд гаргаж байгаа зээлийн хүү чинь олон улсын жишигт биш шүү дээ. Тэгэхээр түүнтэй харьцуулж яриад байна уу, эс үгүй бол бодлогын дундаж хүүтэйгээ харьцуулснаараа ер нь боломжийн хүү харилцах данснууд өгч байна уу? Би тэгээд Монголбанкнаас харилцах данснуудад байгаа дундаж хугацааны үзүүлэлтүүдийг нь авмаар байна. Үлдэгдлийнх нь дундаж хугацааны. Үүнийг бас та бүгд маань бичгээр ирүүлэхийг хүсэж байна гэж хэлмээр байна.

Тэр нийгмийн даатгал, ЭМД-тай холбоотой асуудлаар ярьж байна. Би бас үүнийг олон жил бас хөөцөлдөж байдгийн хувьд тэр банканд эрсдэх 100 хэдэн тэрбум үлдэх энэ эрсдэлийг бид нар өөрсдөө, Монголбанк, Сангийн яам,

ХЗДХЯ-ны бүрэн эрхт төлөөлөгч нар хамтдаа сууж байгаад, хадгалуулсан хүмүүсийн мөнгийг энэ төрийн мөнгө өө гэж харж байгаа байхгүй юу. Яагаад гэхээр, нийгмийн даатгал, ЭМД-ын агентлаг хадгалсан учраас, төрийн мөнгө учраас хамгийн сүүлд барагдуулах бараг дараалал руу нь оруулсан.

Тэгэхээр үүнийг манай бас хариуцлагатай албан тушаалтнууд өөрөө өөрсдөө хуулийг тайлбарлаж дүгнээд, энэ мөнгийг төлөгдөх боломжийг нь нэг жилээр хойшоо болгож байж ийм эрсдэлд оруулсан. Гэхдээ сүүлийн жилүүдэд бас талаас илүү хувийг нь барагдуулсан байна. Тэгээд энэ мөнгийг ер нь тодорхой ойрын хугацаанд барагдуулах энэ тал дээр бас эрчимтэй шүүхийн шийдвэрийнхэн ч гэсэн бас ажилламаар байна гэдгийг хэлмээр байна.

Байгаль орчны сайдаас бас асуумаар байна. Энэ сая хөдөө орон нутгаар явж байхад манай энэ ой мод маань ер нь нэлээн хүнд байдалтай болчихсон юм байна лээ. Яах вэ, чадлаараа төсөв суулгадаг, маш их хор юу цацаж байгаа. Гэхдээ үүнийг ирэх жил энэ тэр тодорхой анхаарахгүй бол нөгөө олон модны маань санаачилга маань зөрүүлээд, байгаа ой мод маань сүйдэх бас ийм аюултай байгаа учраас энэ тал дээр энэ хэдэн хувьд нь яг энэ хор цацах юмыг шийдэж байгаа юм бэ, цацсан бэ? Одоо энэ үхчихсэн байгаа моднууд чинь эргээд сэргэх үү, үгүй юү? Маш их ой энэ хойд, нийт газар нутгийн маань зургаахан хувь нь ойтой. Түүний бараг тал нь хорхойд идэгдсэн байна лээ шүү дээ, ингээд харахад. Тэгээд энэ тал дээрээ бас би тодруулж асуумаар байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Наранбаяр сайд хариулах уу. Боловсролын сайд Наранбаяр хариулъя.

**П.Наранбаяр:** Багш нарын энэ хөгжлийн асуудлыг хөндсөн танд баярлалаа. Эрдэнэбат гишүүн ээ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нэг 11 мянган багшийг гадаад, дотоодын

сургууль, магистр, ахисан түвшний болоод бусад сургалтад хамруулна гээд заачихсан байгаа. Үүнийг санхүүжүүлэх эх үүсвэр нь гаднын бас тусламжаас гадна, Боловсролын зээлийн сан дээр бас сууж өгч байгаа.

Бас танд бас нэг юу яахад, төрийн албан хаагчдыг чадавхжуулах ийм ажлын хүрээнд бас энэ 150 төрийн албан хаагчийг гадаадад хэлний бэлтгэлтэй нийлүүлээд 3 жил ингээд сургах, нийтдээ 7,8 тэрбум төгрөг энэ боловсролын зээлийн санд суучихсан байгаа.

Цаашидаа ер нь багшийг хөгжүүлэх энэ асуудлыг тасралтгүй багшийн 3 тулгуурт бодлогын хүрээнд хэрэгжүүлнэ. Тэр бас энэ цаашидаа ер нь энэ Монголын багш нарын энэ юун дээр англи хэлний багшийг олноор нь бэлтгэх ийм шаардлага байгаа. Бас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2000 англи хэлний багшийг бэлдэхээр, нэмж бэлдэхээр ингэж сургаж, боловсруулахаар ингэж туссан байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Далайн Батбаяр гишүүн нэмж хариулъя.

**Д.Батбаяр:** Энэ ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сангийн арилжааны банкнуудад байршсан байсан мөнгийг хэрхэн буцааж авч байгаа вэ гэдэг дээр бас санал хэлье гэж бодож байгаа юм. Яагаад гэвэл, энэ ингээд анх 2011 оноос хойш жил, жил дараалаад яг энэ зохистой, Монголбанкнаас чинь нэг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тавьчхаад байгаа шүү дээ. Тэгээд тэр шалгуур тэр үзүүлэлтийг үл хайхраад байнга байршуулж байсан тохиолдлууд маш их байгаад байгаа юм байна лээ. Тэд нар бүгдээрээ энэ аудитын тайлангаараа тогтоогдчихсон. Тэгээд түүн дээр харин хариуцлага нь шийдвэр гаргасан улсуудад нь хариуцлага ноогдоогүй ингээд яваад ирчихсэн байгаад байгаа юм.

Зүгээр энэ асуудалтай холбоотойгоор би сая Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөрт бас нэг санал боловсруулж оруулсан юм. Тэр нь юу вэ гэхээр, энэ нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сан дээр хуримтлагдаж байгаа мөнгийг бизнесийн байдлаар нь арвижуулдаг ийм тогтолцоог нь бий болгож өгье гэдэг ийм санал оруулсан. Харамсалтай нь дэмжээгүй. Нэг ёсондоо энэ сангийн мөнгийг зөвхөн нэг бол сая ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж 1 минут өгье, гүйцээж тайлбарлая.

**Д.Батбаяр:** Дөнгөж сая бас яригдаж байна. 3 хувийн хүүтэй харилцах дансанд хийж байна гээд байна. Эсвэл удаан хугацааны хадгаламжийн дансанд хийдэг ийм хоёрхон янзын л нөхцөл байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг эрх зүйн хувьд нь өөрчлөлт оруулаад, бизнесийн зориулалтаар нь хөрөнгө оруулалт хийдэг, эрсдэлийг нь бас даатгалаар нь хааж өгдөг ийм тогтолцоогоор оруулж өгөх юм бол даатгалын салбараа ч дэмжээд явчихна. Ахиад энэ сангийн хөрөнгө маань ч өөрөө арвижаад явчих ийм боломж гарч ирээд байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Тодруулаад нэг зүйл яачхаач, хэдэн жилийн хугацаагаар хадгалуулаад байна? Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг. Энх-Амгалан сайд тайлбар хийх юм уу. Хэдэн жилийн хугацаагаар хадгалуулж байна, ер нь арилжааны банкнуудад.

Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

**Л.Энх-Амгалан:** Их Хурлын дарга аа, одоо арилжааны банканд хадгалуулчихсан нийгмийн даатгалын мөнгө байхгүй шүү дээ. Тийм. Өмнө нь тийм практикууд байсан юм байна лээ. Тэгээд тэрнээс л үүссэн юунууд шүү дээ. Одоогийн байдлаар ямар нэгэн арилжааны банканд тодорхой хугацаагаар хүүлэх зорилгоор, өгөөж

хүртэх зорилгоор ямар нэгэн тийм мөнгө байршуулсан юу байхгүй.

**Д.Амарбаясгалан:** Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван нэмж тайлбарлая.

**Г.Энхтайван:** Эрдэнэбат гишүүний энэ харилцах дансны хүүтэй холбоотой асуудалд нэмэлтээр тодруулъя.

Ер нь дэлхийн дийлэнх оронд харилцах дансанд хүү төлдөггүй. Манай орны хувьд харилцах дансанд хүү тооцож төлдөг. Өрсөлдөөний зарчмаар арилжааны банкнууд харилцагчийг татах зорилгоор харилцах дансанд хүү төлдөггүй. Харилцах дансны хүү 3 хувь нь гэдэг маань одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд ч тэр, манай улсын эдийн засгийн нөхцөл байдлын хувьд ч гэсэн харьцангуй өндөр тоо.

Хэрвээ бид бүхэн харилцах дансны хүүг үүнээс илүү барих юм бол энэ нь эргээд зээлийн хүү болон зээлийн олдоц энд маш сөргөөр нөлөөлнө. Төв банкны зүгээс цаашидаа харилцах дансны хүүг илүү бууруулах нь зүйтэй гэсэн бодлогын байр суурьтай байгаа.

**Д.Амарбаясгалан:** Энхтайван дэд ерөнхийлөгч. Энэ нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг арилжааны банкнуудад ямар хугацаатайгаар хадгалуулж байсан. Тэр талаар нэг мэдээлэл өгөөдхөөч.

**Г.Энхтайван:** Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг одоо эрх хүлээн авагч томилогдсон байгаа. Капитал банканд анх 104,1 тэрбум төгрөгөөр байршуулсан. 2011 оны 4 дүгээр сараас эхлээд. Яг одоогийн байдлаар үлдэгдэл 67,3 тэрбум төгрөгтэй. Хугацааны хувьд тухайн үедээ 6 сарын хугацаатай байршуулж эхэлж байсан.

**Д.Амарбаясгалан:** Тэгээд яадаг юм, автоматаар сунгаад явдаг юм уу, гэрээгээ.

**Г.Энхтайван:** Тэгээд үлдэгдлээ тухайн үед нь ингээд сунгаад, сунгаад явж байсан байгаа.

Хүүгийн хувьд бол тухайн арилжааны банк болон харилцагчийн хооронд гэрээгээр зохицуулсан үүрэгтэй. Тэгэхээр гэрээнийхээ дагуу хүүгээ тухай бүрдээ шинэчлээд явж байсан.

**Д.Амарбаясгалан:** Энэ тэгээд мөнгө хүүлэлтийн л хэлбэр байгаад байгаа шүү дээ. Өнөөдөр малчны зээл жилийн 24 хүртэл хувийн хүүтэй зээл авдаг. Гэтэл яг энэ эргээд хадгалж, хадгаламж хэлбэрээр авсан, татан төвлөрүүлсэн мөнгө нь 9-өөс 11-хэн хувийн хүүтэй яваад байдаг. Тийм ээ. Тэгээд хугацааны асуудал. Тэгээд энэ арилжааны банкнууд ерөөсөө богино хугацаатай хэрэглээний зээл дээрээ төвлөрчихсөн. Урт хугацаатай, хөрөнгө оруулалтын зээл гаргадаггүй. Зах зээлээ дэмжиж байгаа бодлого энд алдагдаад байгаагийн жишээ энэ шүү.

Тэгэхээр энэ дээр Их Хурал бас анхаарч ажиллах нь зөв байх. Энэ Төсвийн зарлагын хяналтын дэд хороо бас энэ анхаарлаа тавьж ажиллах нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг байхгүй шүү дээ.

Горимын санал Эрдэнэболд гишүүн. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэболд:** Баярлалаа. Легал инфо.мн чинь яг манай албан ёсны хууль тогтоомж журам байгаа зүйл. Энэ дээр байгаа манай Их Хурлын дэг байгаа. 74 дүгээр зүйл дээр төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэх гээд. Үүний 74.3 дээр төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагч нар, Монгол улсын

ерөнхий аудитор байлцана гэсэн өгүүлбэр байгаа юм. Байлцана гэдэг бол яг нөгөө мандатури буюу байж ч болно, байхгүй ч болно гэсэн үг биш. Зайлиггүй байлцах ёстой юм байна. Тэгэхээрээ дэгийн дагуу Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг та энэ чуулганы хуралдаанд оруулах юм байна гэж харж байгаа.

Мөн 74.4.2 дээр нь 2 дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод, нам, эвслийн бүлэг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ төсвийн гүйцэтгэлийн талаар, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг сонсож, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч нараас төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлантай холбоотой асуулт асууж, үг хэлж, санал, дүгнэлт гаргах гэсэн хэсэг байгаа юм. Дэг.

**Д.Амарбаясгалан:** Горимын санал гаргах асуудал нь, горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргасан саналыг горимын санал гэж үзнэ гэж байгаа юм.

Ингээд санал хураалт.

АН-ын бүлгийн дэд дарга Тэмүүжин гишүүн үг авч байна.

**Х.Тэмүүжин:** Нөгөө будаа ч будаа ч гэхээр сахлаа буудав гэдэг шиг уг нь бид нар 2023 оны төсвийн гүйцэтгэлийг ярьж байгаа юм. Харамсалтай нь одоогоос 2 жилийн өмнө яг төсөв хэрхэн зарцуулсан бэ гэдэг яриаг ярьж байгаа энэ сэдэв дээр манай олон гишүүд нэлээн зарчмын байр суурь илэрхийлж, шүүмжлэлтэй хандаж байх шиг байна.

Тэгээд АН-ын бүлгээс юу ярьж байна вэ гэхээр, 3 зүйлийг тодотгож хэлэхийг хүсэж байгаа юм.

1 дүгээрт, энэ төсвийн гүйцэтгэл энэ хаврын чуулганаар буюу 2020 оноос 24 оны Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд яригдах ёстой сэдэв байсан. 20 оноос 24 онд ярих ёстой байсан Улсын Их Хурал нь ажлаа хийгээгүй учраас 24-28 оны Улсын Их Хурал дээр ажил болж яригдаж байгаа. 3 жилийн өмнө баталсан төсвөө 2 жилийн өмнө хэрхэн яаж зарцуулсан бэ гэдэг асуудлаар, тэр сэдвээр ярьж байгаа.

Тэгээд энэ дээр зүгээр зарчмын 3 байр суурь харагдаж байна.

1 дүгээрт, нь энэ төсвийн гүйцэтгэлийг ийм шуурхай ээлжит бус чуулганы үеэр хэлэлцэх ёстой байсан уу, үгүй юү гэдэг дээр эргэлзээ төрж байна. Эхнийх нь.

2 дахь нь, сая 2 хоног дотор төсвийн гүйцэтгэлтэй холбоотой Байнгын хороод болон бусад хуралдааны хэлбэр дотор яригдахад нэг бус гишүүдийн амнаас гарсан үг нь энэ нэг гэмт хэргийн хавтаст хэрэг шиг юм ярилаа. Дотор нь гэмт хэргийн шинжтэй зөрчлийн шинжтэй, ер нь бол энэ төсвийг яаж үрэлгэн, яаж замбараагүй, яаж хувийн ашиг сонирхолтой зардаг юм бэ гэдэг хэмжээний ярианууд яригдлаа. Дээд, доодгүй оролцсон мэт дүр зураг харагдлаа.

Тийм учраас АН-ын бүлэг энэ удаагийн энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал дээр Улсын Их Хурал ажлын хэсэг гаргах ёстой юм биш үү. Тухайн үеийн эрхэлж байсан сайдууд, зарим нь сайд үргэлжлүүлээд хийж байх шиг байна. Зарим нь Улсын Их Хурлын гишүүнээр байж байх шиг байна. Зарим хүмүүс нь энэ удаагийн Улсын Их Хурлын гадна байгаа байх. Үнэхээр хариуцлага ярих ёстой хэмжээний сэдвүүд хөндөгдөж байгаа учраас намрын чуулганаар энэ асуудлаа эцэслэвэл яасан юм бэ. Ажлын хэсэг Улсын Их Хурлаас байгуулагдаад, төсөвтэй холбоотой нарийвчилсан хяналтууд явуулаад, үнэхээр энэ гэмт хэргийн хэмжээний юм

яригдаад байгаа бол, үнэхээр ийм зөрчил нь хавтгайрсан шинжтэй байгаа бол, үнэхээр хүний байдлаар хандаад гараа угаасан шинжтэй, татвар төлөгчдийн мөнгөөр ийм үрэлгэн асуудалд хандсан байгаа бол энэ удаа Улсын Их Хурал цаашид энэ хамтарсан засгийн хэлбэрээр энэ зүйлийг өөгшүүлж, эс үгүй бол нүдээ аниад чихээ бөглөөд явж болохгүй нь ээ.

Үнэхээр хариуцлагатай асуудал ярья гэж бодож байгаа бол одоо энэ тогтоолын төслийг батлахгүйгээр, намрын чуулган руу шилжүүлээд, ажлын хэсгийнхээ дүгнэлтүүдийг гаргаж, ярьж хэлэлцээд хариуцлага тооцох бол, ажлаа сайжруулах бол, төсвийг илүү үр ашигтай үр дүнтэй байлгахад чиглэсэн арга хэмжээ авах ёстой бол энэ тодотгол, Улсын Их Хурлын тогтоол дотор чинь тэр бүхэн нь бичигдэж орох ёстой юм биш үү.

Тэгэхгүй бол энэ ёстой нэг нүглийн нүдийг гурилаар хуурна гэдэг шиг яаруу сандруу ажил хэрэгч бус зүйл болох нь ээ. Би Дамдинням гишүүн болон Ганхуяг гишүүн, Энхбаяр гишүүн гэх мэтчилэн гишүүдийн санаачилгыг дэмжиж байна. Гэхдээ хаягласан эзэн чинь буруу байна. Одоо байгуулагдсан Засгийн газрын ажил ерөөсөө биш байгаа байхгүй юу. Энэ чинь 2 жилийн өмнө хийх ажил байгаа байхгүй юу.

Үнэхээр угаартуулаад иргэдийнхээ амь насаар тоглосон тэр сайжруулсан түли гээд байгаа зүйл чинь бараг гэмт хэрэг байгаа юм биш үү. Түүн дээр гарсан төсөв мөнгө чинь гарын салаагаар урсаад, зальдуулчихсан юм биш үү. Зөвхөн нэг жишээ шүү дээ. Ийм ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** 2 асуудал байгаа.

1 дүгээрт, дэгийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр хаврын чуулганы дараагийн чуулганаар хэлэлцэж батална гээд хуулийн зохицуулалт орчихсон учраас намрын чуулган руу хойш

нь батлах асуудлыг хойш нь тавих боломжгүй.

Хэрвээ Тэмүүжин гишүүний хэлж байгаа саналаар явъя гэж үзэх юм бол ээлжит бус чуулганаа хаахгүйгээр үргэлжлүүлэх асуудал яригдана гэсэн үг. Зохицуулалт байж болно. Тэр зохицуулалт нь энэ тогтоол батлагдчихаад, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо ахиж тогтоолын төсөл оруулж ирээд, ажлын хэсэг байгуулаад, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах боломж нь нээлттэй байгаа гэсэн үг.

Тэгэхээр бид Улсын Их Хурал хуулиа хэрэгжүүлэх үүднээс тогтоолоо баталчихаад, саяын Тэмүүжин гишүүний хэлж байгаа процессыг үргэлжлүүлээд явуулах боломж нь нээлттэй гэж ингэж ойлгож болно.

Тогтоол батлагдахгүй бол ээлжит бус чуулган үргэлжилж дараагийн 7 хоногт хуралдаж, батална. Дэгийн тухай хуулийн зохицуулалт ийм байгаа юм.

Ингээд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.,

54 гишүүн дэмжиж, 49,5 хувийн саналаар санал, тогтоол батлагдсангүй.

Батсуурь гишүүн, Батсуурь сайд юу юм, горимын санал юм уу. Тодорхой хэлнэ шүү, горимын санал.

**Ж.Батсуурь:** Би сая дэмжиж дарсан боловч энэ урт улаан юм гарчхаад одоог хүртэл гараад явах юм, тийм. Хүчингүй болгож, дахиж санал хурааж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Төхөөрөмжид буруу өгөхгүй ээ. Төхөөрөмжтэй харьцахдаа гишүүд өөрсдөө хоцорч

байгаагаа микрофоноор одоо зөв хэлж байна. Тэгэхгүй бол Их Хурлын үйл ажиллагаа, Их Хурлын санал хураалтын төхөөрөмж ажиллахгүй байгаа мэтээр олон нийтэд буруу ойлголт өгч байгаа. Тэгэхээр би хоцорлоо гэдгийгээ өөрсдөө хүлээн зөвшөөрч үгээ хэлж байх нь зөв шүү.

Алтангэрэл сайд. Горимын санал.

**О.Алтангэрэл:** энэ нөгөө төхөөрөмжөөс болоод гишүүд энэ санал хураалтыг дахилаа гэж бухимдаж байгааг ойлгож байна л даа.

Тэгэхдээ сая ингээд яг санал хурааж байхад энэ чинь ажиллахгүй байна, ажиллахгүй байна гээд энд тэнд яриад байгаа байхгүй юу. Над дээр ч гэсэн тохиолдож байгаа зүйлүүд заримдаа ингээд дэмжигдчих юм бол ажиллаагүй байсан ч гомдол гаргахгүй, өнгөрөөд байгаа юм.

Тэгэхээр үнэхээр ажиллаагүй бол тэнд нэг тэмдэглүүлээд байгаа шүү дээ. Процесс. Дэмжиж өгсөн гэдгээ. Үүгээрээ шийдээд явдаг жишгээ тогтоовол яасан юм бэ. Заавал ингээд буруу өглөө гээд саналыг унагаад дахиж хураадаг биш. Дэмжиж өгсөн гээд олны дунд ил хэлээд, түүнийг маань тэмдэглэж өгөөч гээд тэр хувиараа шийддэг байж болохгүй юм уу гэсэн санал.

**Д.Амарбаясгалан:** Алтангэрэл сайд, энэ чинь өөрөө хуулиараа. Тэгээд санал хураалтынхаа журамтай холбоотой асуудлаараа энэ дэлгэцэн дээр гарсан нэрсээрээ явж байгаа юм. Санал нь, хувь нь гарчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ санал хураалтыг заавал хийх шаардлагатай, ёстой гэсэн үг.

Төхөөрөмжид бид буруу өгөөд яриад байгаа юм. Би энэтэй санал нийлэхгүй. Яагаад гэвэл санал өгөх процесс нь өөрөө яг эхэлж байхад хуруугаа уншуулах процесс нь яг түүнтэйгээ уялдаж явагдаж байна уу, хоцорч байна уу, түрүүлж хөдөлгөөн



Үйлдэл хийгээд байна уу гэдгээс л хамаараад байгаа шүү дээ.

Тэгэхээр бид төхөөрөмжид буруу өгөх биш, өөрсдийнхөө үйл ажиллагаанд дүгнэлт хийх ёстой. Үйлдэл дээрээ анхаарах ёстой гэж би хэлж байна.

Ингээд Батсуурь сайдын гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

53,2 хувийн саналаар санал хүчингүй боллоо.

Үндсэн санал хураалт руугаа орёе.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

53,2 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын төслөө уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 16 их наяд 85 тэрбум 164,1 сая төгрөгөөр баталсугай.

2. Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын хэмжээг 16 их наяд 79 тэрбум 765,5 сая төгрөгөөр баталсугай.

Ингээд тогтоолын эцсийн найруулгатай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд 13 цаг болсон тул үдийн завсарлага.

Гишүүдэд нэг зар хүргээдэхье.

Өнөөдөр Улсын Их Хурлын даргын захирамжаар 54 ажлын хэсэг байгуулагдахаар байгаа. Улсын Их Хурлын гишүүд хууль, эрх зүйн орчны шинэтгэлийг хийх, хүн төвтэй хууль, эрх зүйн орчны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулагдаж байгаа.

Тэгэхээр энэ үдийн завсарлагаар Улсын Их Хурлын гишүүд Тамгын газраас аль ажлын хэсэгт орж байгаа, аль ажлын хэсгийг ахлахаар болж байгаа талаараа мэдээллээ аваад, үдээс хойших хуралдаан дээр ажлын хэсгийг албан ёсоор албажуулна гэдгийг бас хэлье.

Баярлалаа.

## ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийг танхимдаа цуглахыг зар хүргэе. Чуулганаа эхлүүлье. Үдээс хойших хуралдаан.

Чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанаа эхлүүлье.

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Хэлэлцэх асуудлын талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**С.Эрдэнэболд:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн Наранчулууны Отгончимэг үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тухай албан бичгийг Монгол Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэгт Ерөнхий зөвлөлийн дарга гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө. 83.1.3 дахь заалтад өөрөө хүсэлт гаргасан гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлд заасан журмын дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн Наранчулууны Отгончимэгийг чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Г.Уянгахишиг, П.Сайнзориг, О.Номинчимэг, С.Эрдэнэболд, Б.Энхбаяр, Ц.Сандагдорж нар асуулт асууж хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Г.Уянгахишиг, Б.Заяабал, Д.Цогтбаатар нар үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Наранчулууны Отгончимэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Амгалангийн Насандэлгэр  
Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн.

Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн Наранчулууны Отгончимэг хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны санал, дүгнэлт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Мөнхбаатар гишүүнээр тасаллаа.  
5 гишүүн.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн бас өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх анхны кэйс гарч байгаа юм. Яах вэ, зүгээр Отгончимэг гишүүний хувьд үндсэндээ бас томилогдоод 3 жил бас ажиллаж байгаа. Бас энэ шүүхийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх, дагаж гарсан бодлогын бичиг баримтуудыг хэрэгжүүлэх энэ үйл ажиллагаанд бас идэвхтэй оролцсон гэдэг нь бас өөрийнх нь бас асуулт хариултаар гарч ирж байсан.

Тэгэхдээ энэ дээр нэг л зүйл байгаа юм. Яг дараагийн хүнийг бас сонгон шалгаруулах процесс маань үндсэндээ 3 сар дор хаяж үргэлжлэхээр байгаа. Гэтэл энэ хүрээндээ нөгөө 19 онд батлагдсан Үндсэн хуулийн өөрчлөлт, эргээд 21 онд батлагдсан Шүүхийн тухай хууль дээр шүүхийг хараат бус бие даасан, шүүгчийг шилдэг шүүгчийг, шилдэг хуульчдаас шүүгчийг шилж сонгох ажиллагаа дээр бас шүүгч болон шүүгч бус гишүүдийн балансыг 5, 5-аар бай ярих асуудал маань яригдаж байгаа.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн зарчим цааш цаашдын томилгоонууд дээр шууд алдагдах учраас энэ эрсдэлээс нь л бодож

бас зайлиггүй бас харах болчхоод байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол бас хувь хүний эрхийн асуудал байгаа боловч нөгөө талдаа бас Үндсэн хуулийн институцийн тэр үзэл санаа, зарчим алдагдах ийм нөхцөл байдал руу орох ийм эрсдэл байна гэдэг зүйлээс нь л би зүгээр хувьдаа саналаа хэлж байгаа.

Мэдээж хувь хүний цаашдын ажил, хөдөлмөр эрхлэх энэ сонголтыг нь хүндэтгэж байна. Тэгэхдээ нөгөө талдаа бас энэ цаашидаа шүүгч давамгайлсан шийдвэрүүд үндсэндээ гараад явах энэ нөхцөл байдал дээр бас жоохон эргэлзэж энэ Үндсэн хуулийн зарчим алдагдах энэ нөхцөл байдал руу орох нь.

Тэгэхээр бас төрийн өндөр албан тушаалтнууд бас яах аргагүй энэ Улсын Их Хурлаас томилогдсон энэ хугацаагаа бас бодолцож яах вэ, зүгээр зохицуулалтыг хийх зайлиггүй шаардлага хууль, эрх зүйн талаасаа ч байх юм байна.

Нөгөө талдаа ч энэ шүүхийн хууль дээр бас орон, гарсан тохиолдолд маш яаралтайгаар нөхөх гэдэг юм уу, сонгон шалгаруулалт дээр тэнцсэн хүмүүс дээр бас сан бүрдүүлээд, нөхөх тэр бололцоотой байдлаар ингээд явах тэр жишиг рүү ингээд орохгүй бол цаашидаа энэ Үндсэн хуулийн зарчим бас алдагдах ийм нөхцөл байдлын эрсдэлүүд л байгаа юм.

Тэгэхээр энэ эрсдэлийг та бас юу гэж харж байгаа вэ гэдэг зүйлийг би бас нэр дэвшигч болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаас бас асууя. Аль аль талынх нь байр сууриудыг бас гишүүд маань сонсох нь зөв байх. Би мэдээж хувь хүний асуудал байгааг хүндэтгэж байна.

2 дугаарт, яг таны энэ кэйс бас хувь хүний асуудал гэхээсээ институцийн болон Үндсэн хуулийн зарчмын асуудал болчхоод байгаа шүү гэдэг зүйл дээр бас тодруулж хэлье.

Тэгээд яг бас нэр дэвшигч болон Шүүх ерөнхий зөвлөлийн гишүүдээс бас

энэ асуудлын эерэг, сөрөг нөлөөллийг та нар юу гэж харж байгаа юм бэ гэдэг зүйлийг бас нэг протоколын хувьд бас асуулт асуучихъя гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Тийм, нэр дэвшигч биш байгаа. Чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн. Яах вэ, энэ дээр бас Сайнзориг гишүүний ярьж байгаа зарчим бас зөв байх. Нэг талдаа.

Нөгөө талдаа бас бид ингээд нөгөө хэт их байгууллага, үйл ажиллагаа процесст нь зориулсан хуулиудтай, энэ хүний энэ нөхцөл байдлыг бас зохицуулалт хийх тал дутмаг байгаагийн илэрхийлэл нь байна гэж ингэж бодож байна.

Ажлын хэсгийн I дүгээр микрофон Амгалангийн Насандэлгэр. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн хариулт өгнө.

Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Насандэлгэр оролцож байна.

Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Гишүүн маань сая өөрөө хэллээ. 2021 онд бас хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүхийн тухай хууль, үүнийг хэрэгжүүлж байгаа явцад 19 оны Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан энэ бүтэц бүрэлдэхүүнээрээ анх удаагаа ажиллаж байгаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн хувьд анх удаагаа гарч байгаа ийм кэйс байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөл яг төрийн шүүхийн захиргааны төв байгууллага болохынхоо хувьд хамтын зарчмаар шийдвэр гаргадаг хэдий ч мэдээж хувь хүний, хувь гишүүний оролцоо маш чухал байдаг. Энэ утгаараа энэ өнгөрсөн 3 жилийн хугацаанд манай Отгончимэг гишүүний өөрийнх нь оролцоо, эрх зүйн салбарын судлаач, хуульч гишүүний хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гаргаж байгаа аливаа шийдвэрт маш идэвхтэй оролцож ирсэн манай нэлээн тийм гол болох байр суурь эзэлдэг ийм гишүүн байгаа.

Сайнзориг гишүүн маань сая хэлж байна. Мэдээж хувь хүний шийдвэрт хүндэтгэлтэй хандана гэж. Шүүхийн ерөнхий зөвлөлийн хувьд ч гэсэн яг энэ байр суурьтай байгаа. Нэг талаас.

Нөгөө талаас гишүүний ярьж байгаа тэр өнцгийг би бас хуульд байгаа, мөн цаашаа яг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэж байгаа чиг үүрэгтэй холбоотойгоор зайлиггүй анхаарах ёстой зүйл мөн. Шүүхийн тухай хуульд зааснаар гишүүний бүрэн эрхийн хугацаа хугацаа дуусахаас өмнө орон гарсан тохиолдол нэг 3 сарын хугацаанд ингээд процесс үргэлжлэхээр байгаа.

Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн хувьд мэдээж хууль дээдлэх зарчим, хуулийг зөрчихгүй мөрдөж ажиллах, дээр нь энэ зарчмыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд төрийн албан тушаалтны хувьд мөрдөж ажиллах ийм үүрэгтэй.

Тийм учраас хэдийгээр ийм боломж өөрөөр хэлэх юм бол хүний нөөцийг хангах Үндсэн хуульд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн энэ үндсэн үүргийг хэрэгжүүлэх явцад сөргөөр нөлөөлж болзошгүй ийм эрсдэл байгаа хэдий ч тэнд ажиллаж байгаа гишүүдийн хувьд ялангуяа шүүгч гишүүдийн хувьд энэ дээр зарчим барьж ажиллах, цаашидаа энэ чиглэлээр ямар нэгэн сөрөг, хэн нэгний эрх ашгийг хөндсөн ялангуяа энэ хүний нөөцтэй холбоотой шүүгчээр томилогдох гэж орж ирж байгаа залуучуудтай холбоотой, сонгон шалгаруулалттай холбоотой энэ холбож тайлбарлаж байгаа энэ зүйл дээр ямар нэгэн эрсдэл гарахгүй ажиллах ийм боломжтой гэдэг ийм хариултыг өгье.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг тодруулъя, тодруулж асууя.

**П.Сайнзориг:** Ерөнхийдөө хариулт протоколд үлдэх нь зөв гээд би асуусан юм. Тэгээд ер нь зүгээр цаашидаа энэ Үндсэн хуулийн байгууллага болсон

Шүүхийн ерөнхий зөвлөл яг л 5, 5-ын харьцаатай шүүгч болон шүүгч бус гишүүдээс бүрдсэн бүрэлдэхүүнээр ажиллах ёстой.

Тэгэхээр энэ дээр бас эрсдэлүүд үүсэж байгаа гэдэг нь шулуухан хэлэхэд үнэн. Одоо ингээд сонгон шалгаруулалтаасаа эхлээд шийдвэр гаргалт дээр бүгд шүүгчид хамгаалсан шийдвэрүүд гарна. Дараагийн гишүүнийг орон, гарсан гишүүн дээр сонгон шалгаруулалт яваад дуустал Шүүхийн ерөнхий зөвлөл бас яг маш олон шийдвэрүүд гарах байх. Шүүгчдийг дээшээ дэвшүүлэх байх. Шинээр сонгон шалгаруулалт явуулж, зарим шүүгчдийг томилуулах саналаа эрх бүхий этгээдэд хүргүүлэх байх. Ийм зүйлүүд гарна.

Тэгэхээр энэ дээр ерөнхийдөө бас төрийн өндөр албан тушаалтан дээр дэвшиж байгаа, дээрээс нь дэвшээд нээлттэй сонгон шалгаруулалтаар орж томилогдсон этгээдүүд маань үнэхээр л эрүүл мэндийн шалтгаан биш бол уг нь ингэж бас дундаас нь хаяж гардаг энэ зүйл байх ёсгүй юм гэдэг зүйлийг би бас энэ зүйл дээр ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууя.

**Л.Мөнхбаатар:** Ер нь 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн хүрээнд 1993 онд Шүүхийн тухай хууль анх батлагдан гарсан. Энэ хуулиар шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллахаар ингэж тогтоосон байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөл байгуулагдсан цагаасаа эхлээд анх Хууль зүйн яамны дэргэд бас байсан. Улсын дээд шүүхийн дэргэд байсан. Ингээд олон хэлбэрээр ажиллаж ирсэн л дээ. Тодорхой албан тушаалтнууд ч гэсэн санал болгодог. Хууль зүйн байнгын хорооны дарга Хууль зүйн яамнаас тодорхой хүн санал болгодог, ажилладаг ийм олон хэлбэрүүдтэй байж байгаад одоогийн энэ хэлбэр буюу жишээ нь Үндсэн хуульд

заасан хэлбэрээр 10 гишүүнтэй. 5 нь шүүгч, гишүүн 5 нь шүүгч бус буюу нээлттэй сонгон шалгаруулалтаар нийтийн сонсголоор томилогддог болсон. Энд их зөв хэлбэр лүүгээ орсон гэж бодож байгаа юм.

Энэ сонгон шалгаруулалтын хүрээнд орж ирсэн бас гишүүн манай Отгончимэг гишүүн байгаа л даа. Монголын бас сайн хуульчдын нэг. Энд Шүүхийн ерөнхий зөвлөлийн асуудал гэж яригдсанаар бас нэг 2, 3 зүйлийг зохион байгуулалтын хувьд бас эргэж хармаар юм шиг байгаа юм. Бид бас олон хуулиудыг нь яалаа. Сая бас ярьж байна. 10 гишүүнтэй тав таваараа гэхээр санал тэнцээд бас олон бэрхиээлүүд гардаг юм байна лээ. Даргаа сонгох дээр хүртэл их олон бэрхиээлүүд энэ практик дээр гарсан. Ийм асуудал байгаа.

Түүнээс гадна Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний хугацааг 4 жил гэгчихсэн. Шүүхийн сахилгын хороо 6 жил байдаг. ҮХЦ бусад холбогдох байгууллагууд дандаа 6 жилээр. 4 жил болдог энэ өөрөө Шүүхийн ерөнхий зөвлөл бодлого үйл ажиллагаа нь тогтвортой явах энэ боломжийнх нь хувьд энэ 6 жил дээр байх нь зохимжтой юм шиг байгаа юм.

Түүнээс гадна даргыг нь нэг жилээр сонгодог ийм хууль бид нар гаргачихсан. Ерөөсөө ажилтайгаа танилцаад л тодорхой бодлого үйл ажиллагаагаа явуулж эхэлж байтал сонгууль нь болоод нэг жил болчихдог. Ингээд 4 жил, 4 даргатай байгаад байгаа юм. Ийм учраас энэ асуудлыг нь ч гэсэн эргэж авч үзэж бид бас Цэцийн адил 3, 3 жил 6 жилийн хугацаатай, 3, 3 жил ажилладаг ч юм уу ийм зохион байгуулалт руу бид бас цаашидаа орох шаардлага ингээд харагдаад байгаа юм.

Тэгээд эдгээр зүйлүүдийг бас ер нь бид бас Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлынхаа хүрээнд авч үзэх нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

Отгончимэг гишүүний хувьд сая энэ Шүүхийн тухай хууль, Шүүх эрх мэдлийг хөгжүүлэх 10 жилийн төлөвлөгөө гарсан. Эдгээрийг ахалж ажилласан. Хялбар ажиллагааны шүүх, шүүхийн ил тод байдлын тухай гээд их олон асуудлуудыг авч гарч, хамтран ажилласан ийм сайн хуульчдын нэг. Үнэхээр хүлээн зөвшөөрөгдсөн сайн судлаач, хуульч. Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлд энэ ажиллах хугацаандаа хууль дээр хүлээсэн үүргээ хамгийн сайн биелүүлсэн гишүүдийн маань нэг байгаа.

Гэхдээ мэдээж хувь хүнийхээ хувьд өргөдлөө өгч, өөр ажилд шилжэж байгаа гэж би ойлгосон. Энэ саналыг нь хүндэтгэж байна.

Тийм учраас хувь хүний хүсэлтийг нь илүү түлхүү харж бид бас шийдэх нь зөв байх гэсэн ийм бодолтой байгаагаа хэлье. Ийм зүйлүүд байна.

#### **Д.Амарбаясгалан:**

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна. Алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Чинбүрэн гишүүн асуулт асууя.

#### **Ж.Чинбүрэн:**

Баярлалаа. Яг өөдөөс нь хараад сууж байгаа даргын өөдөөс. Би энэ Байнгын хорооныхоо даргаас, энэ Хууль зүйн байнгын хорооны даргаас бас л асуумаар санагдаад байгаа юм л даа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн өөрөө цаашаа ажиллах боломжгүй гээд хэлээд байгаа. Тийм ээ. Боломжгүй гэсэн хүнийг ажиллааа гээд үүрэгдээд байгаа байхгүй юу. Та бүхний санал хураалгаад оруулж ирж байгаа зүйл бол, болно оо, энэ хүнийг буцаагаад ажиллуул гээд санал хурааж байна.

Тэгэхээр ажиллахгүй гэж байгаа, ажиллах боломжгүй цаана нь ямар нэг шалтгаан л байгаа л байх л даа, тийм ээ. Тэгэхээр би хувь хүнийг нь яаж байгаа

зүйл биш. Энэ олон гишүүд хэлж байх шиг байна. Их чухал үүрэгтэй, рольтой ажилласан. Бид ч бас өнгөрсөн парламент энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн талаар асуудлуудыг бас хууль баталж байсан.

Тэгэхээр Цогтбаатар даргаас асуумаар байгаа юм. Ажиллах боломжгүй гэж хэлж байгаа хүнийг танай Байнгын хорооны гишүүд ямар үндэслэлээр ажиллааа гээд өөрийнх нь хүсэлтийг хүлээж авахгүй гээд байгаа юм? Тэр шалтгааныг нэг тодорхой тайлбарлаж өгөөч?

Түүрүүн би бас Сайнзориг гишүүний хэлж байгааг ойлгосон. Тэгэхдээ энэ шалтгаан биш гэж надад санагдах юм. Жоохон шуурхай шийдэж болох л байлгүй дээ, энэ чинь. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар гишүүн хариулт өгнө.

**Д.Цогтбаатар:** Энэ гарах л ёстой асуулт л даа. Би яг ийм ч асуулт гарах болов уу гээд Байнгын хороон дээр санал хураахад өөрийнхөө байр суурийг хэлсэн.

Монголын төр бол хүн ингээд ажлаа өгье гээд тэгж байхад гуйгаад ажиллуулж байгаа юм шиг, энэ чинь энэ хүний тухай асуудал биш шүү. Цаашидаа ийм асуудал гарах нь байна шүү дээ. Би энэ ерөнхий хуулийн хэрэглээ, практикийн тухай ярьж байна шүү дээ. Амьдрал дээр хүн ажлаа өгье, би ингээд боллоо, өөр ажилд очно гээд явах гээд өргөдөл өгнө.

Тэгсэн Монголын төр үгүй, чамгүйгээр л бид нар дутаад байна, чи энэ дээр ажилла гээд төрийн ийм өндөр албан тушаал дээр, ийм нарийн шийдвэр гаргадаг юман дээр, хүн би эндээ ажиллахгүй гээд шийд гаргачихсан байхад бид хүчээр санал хурааж байгаад ажиллуулах гэж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ чинь өөрөө би энд үг авах юу, үг хэлэх гээд үг авчихсан байгаа. Ерөөсөө үүгээр шууд хязгаарлаад явчихъя.

1 дүгээрт, энэ хуульдаа юу, Шүүхийн тухай хуульд 83 дугаар зүйлд нь 83.1.3 дээр тодорхой заачихсан байгаа. Өөрөө хүсэлт гаргана, хууль гаргаж байгаа энэ хуулийг хийж байгаа хүмүүс ингэж хүн ажил өгч магадгүй гээд хуульчлаад заагаад өгчихсөн байна шүү дээ. Энэ хүн хуулийн хүрээнд энэ хүсэлтээ гаргаж байгаа байхгүй юу. Энэ чинь хуулийн үндэслэлтэй. Тэгэнгүүт, ингэж гаргаж болохгүй юм шиг шийдвэр бид нар гаргаад байна.

2 дугаарт, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйл дээр, манай Үндсэн хуульд энэ бүх үзэл баримтлалууд нь бүгд орчихсон байж байгаа. Түүн дээр хүн ажиллах өөрийнхөө ажлыг чөлөөтэй сонгох эрхтэй гээд заачихсан байхгүй юу. Энэ чинь хүн төрөлхтний эрх зүйн хүний эрх ярьдаг хүмүүсийн хувьд хамгийн үнэт зүйл. Тэгсэн энэ хүнд тэр эрхийг нь олгохгүй байна шүү дээ. Одоо бол чи ажилла гээд санал хураагаад ингээд явж байгаа байхгүй юу.

Тэгээд энд ярьж байгаа тайлбар нь тав, таваараа ингээд тэнцүү байх ёстой гээд хууль хэзээ ч ийм хатуу, юу болд шиг ингэж хийгддэггүй шүү дээ. Нийгмийн харилцаанд тэр 5 байхад нөгөөдөх нь 4 болох тохиолдол гарч болно. Нэг хүн өвдвөл яах юм. Тэгсэн хүчээр өвдүүлэхгүй байлгах юм уу. Тэгсэнээ 5 шүүгч шийд гаргах гээд байна. Тэр шүүгчид яасан юм гэмт хэрэгтнүүд юм уу, амьдрал дээр энэ Их Хурал дээр хэчнээн хүн түрүүний Их Хурал дээр юу, саналаа өөрийнхөө хүсэлтээр гараад өөр ажил дээр очсон кноп дараад явсан. Тэгсэн 76 л биш бол шийдвэр гаргаж болохгүй болчихоод байна гээд 76-г нь байлгах гэж байгаа юм уу. Одоо 126-г 1-ийг нь ч хөдөлгөхгүй байлгаж байж Их Хурал шийдвэр гаргах уу? Ийм шаардлага тавиад байна шүү дээ.

*Би тийм учраас энэ асуудал дээр энэ хүн явъя гэгчихсэн байхад Монголын төр хэнээс ч гуйж, өндөр албан тушаал дээрээ танигүй л энэ ажил явахгүй нь гэдэг асуудал байхгүй. Явъя гэж байгаа хүнийг нь явуулах хэрэгтэй.*

*Тэгэхээр энэ дээр энэ шийдвэрийг манайхан кноп дар ... /минут дуусав/*

**Д.Амарбаясгалан:** Цогтбаатар гишүүн хариулт өглөө.

*Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.*

**Х.Баасанжаргал:** Би бас яг Цогтбаатар гишүүний саналтай яг нэг байна. Тэгээд тэр дундаа Үндсэн хууль дээр бид нар хууль тогтоогч нарын хөндөж үл болох ёс бол энэ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх юм гээд ингээд бас ийм тайлбар ийм зүйлийг Үндсэн Хууль дээрээ тунхаглачихсан байгаа.

*Тэгэхээр бид нар хүний эрхийн асуудал дээр ямагт хүндэтгэлтэй хандах ёстой гэдгээ нэг номерт барих ёстой байх. Тэр байгууллага хямрах гээд, институц хямрах гээд байгаа гэдэг асуудал 2 дугаар, 3 дугаар эрэмбийн асуудал байх. Тэгэхээр энэ асуудлаа бас бид нар бодох ёстой байх.*

*2 дугаарт гэвэл хуульчийн ёс зүйн хувьд ёс зүйгүй гэдэг ийм мессежийг бас сүүлийн үед нэлээн өгөх шиг боллоо. Гэхдээ би хувьдаа энэ хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийг харлаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг харлаа. Энэ хуулиуд дээр энэ дүрмүүд дээр ч гэсэндээ энэ хүний ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийн асуудлыг хөндсөн ёс зүйн хувьд хязгаарласан ийм зохицуулалтууд бид нарт алга.*

*Тэгээд ямар утгаараа бид нар ийм ёс зүйгүй гэдэг ийм дүн тавих гээд байгааг би хувьдаа яг адилхан хуульч хүний хувьд ерөөсөө ойлгохгүй байна. Харин*

*эсрэгээрээ ер нь энэ нэг ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр юм биш үү гэж харах гээд байгаа юм. Яагаад бид нар ер нь энэ хуульчдыг өөр бусад ажил мэргэжлийн экспертүүдийг улс төрийн албан тушаал сонгосных нь төлөө дандаа ингэж бүүлийддэг, ялгаварлан гадуурхагддаг. Тэгээд 1 ийм цаанаасаа нэг ийм дургүйгээр хүлээж авдаг. Ийм байдлаа бид нар халахгүй бол энэ улс төрийн энэ үйл ажиллагаанд чинь маш сайн экспертүүд орж ирэхгүй. Бид нар энэ шинэчлэлийг хийж чадахгүй.*

*Тэгэхээр энэ хувь хүний шийдвэрт би маш их хүндэтгэлтэй хандаж, мэдээж энэ бас тийм амар шийдвэр биш. Хуульч хүний хувьд, өдий карьертай явж байгаа хуульч хүний хувьд тийм амар шийдвэр биш. Ийм шийдвэрийг гаргаад орж ирж байгаа энэ тохиолдолд бид нар парламент буюу хууль тогтоогчид энэ асуудал дээр хүний эрхийг гол зарчмаа болгож, шийдвэр гаргах байх гэж найдаж байна.*

*Би Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Насандэлгэр гуайгаас нэг асуулт асуугаадахъя. Энэ миний ойлгож байгаагаар энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шинээр томилогдсон гишүүдийн хугацаа дуусахаар бүгдээрээ дахиж шинээр солигдоно гэж ойлгож байгаа, яг хуулийнх нь бичвэрээр.*

*Тэгэхээр 1 ёсондоо нөгөө ротац гэдэг юм ерөөсөө байхгүй л байна л даа. Дахиад дараагийн бүрэлдэхүүн дахиад цоо шинэ ийм концепцоор явах болчихоод байна. Тэгэхээр энэ ротац дээр таны бодол ямар байдаг вэ? Ер нь цаашид энэ ер нь ийм томоохон ийм бодлогын байгууллагуудын залгамж халаа гэдгийг бид нар ер нь яаж авч явах ёстой вэ гэдэг дээр таны саналыг сонсьё.*

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

**А.Насандэлгэр:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, энэ нэмэлт, өөрчлөлтийн дагуу батлагдсан.

Шүүхийн тухай хууль бол энэ шүүхийн системийн үйл ажиллагаанд дэвшилттэй шинэлэг зохицуулалтууд их орсон. Нэлээн тийм амьдралд хэрэгжихээр тийм бодитой, ийм зохицуулалттай, ийм сайн хууль болсон гэж хуульчдын хувьд үздэг.

Яг энэ хууль хуулийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл 10 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулаад 3 жилийг үзэж байна. Тэгэхээр шинэ тутам хэрэгжсэн хууль, нэгэнт шинэ тутам хэрэгжиж байгаа учраас яг сонгогдож, томилогдож байгаа гишүүд маань нэг цаг хугацаа дор томилогдоод яг бүрэн эрхийн хугацаа нэг дуусах байгаа учраас, яг тэр төрийн албаны яг гишүүдтэй холбоотой залгамж чанарын хувьд бас анхаарах ёстой юм байсан юм биш байгаа даа гэсэн ийм бодол байгаа.

Тийм учраас энэ ротац тасрахгүй байх 1 дүгээрт.

2 дугаарт, яг энэ чанараараа энэ залгамж чанар, яг шүүхийн ерөнхий зүйлийн бүрэлдэхүүнд цаашидаа хэрэгжүүлж байгаа бодлогыг ингээд тасалдахгүйгээр авч явах энэ ач холбогдолтойгоос нь авч үзэх юм бол одоогийн гарч байгаа энэ кэйс магадгүй бас ач холбогдолтой байж болохоор. Ийм цаг хугацааны хувьд ингээд хэрэгжиж байна. Нэг жилийн өмнө нөхөгдөөд тэр нөхөн томилогдсон гишүүн маань бас нэг жилийн хугацаанд шинээр орж ирсэн гишүүдтэйгээ бас хамтраад ажиллах ийм боломж нээгдэж байгаа талаас нь бас харах ёстой ийм зохицуулалт нь илүү эерэг байж болох юм гэсэн ийм байдал анзаарагдаж байгаа.

Нөгөө талаасаа гишүүд магадгүй зүгээр яг хуулийн хэрэгжилт талаас нь авч үзэх юм бол нэгэнт л хуульд заасан хугацаагаараа томилогдоод тэр хугацаагаараа томилогдоод явна гэдэг. Энэ амьдрал дээр хэрэгжиж байгаа энэ зүйл маань нэг талаасаа зөв мэт боловч нөгөө талаасаа саяын ярьж байгаа байж болох энэ дэвшилттэй зүйлүүдийг бид нар амьдралынхаа энэ туршид практикаасаа

олж хараад засаад, залруулаад цаашаа явах ийм шаардлага байгаа байх гэж ингэж ойлгож байгаа.

Зүгээр ийм кэйс гараагүй байсан тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл яах байсан бэ гэдгийг бас бид нар бас ярьдаг. Нэг талаасаа. Нөгөө талаасаа яг Шүүхийн ерөнхий зөвлөлийн барьж байгаа бодлого бол Шүүхийн ерөнхий зөвлөлд арга зүйн туслалцаа үзүүлдэг ажлын албыг маш сайн бэхжүүлэх ёстой юм байна гэдэг дээр бид нар маш сайн анхаарч, ажлын албаа бэхжүүлэх, тэнд байгаа залуучуудаа сургах, болж өгвөл тэнд байгаа залуучуудаараа гардаж ажиллуулах энэ чиглэл дээр Шүүхийн ерөнхий зөвлөл нэлээн чиглэл болж, бодлого барьж ингэж ажиллаж байгаа. Энэ ч утгаараа өнгөрсөн хугацаанд ажлын алба маань харьцангуй бас төлөвшиж бэхжигдэж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Наранчулууны Отгончимэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөхийг дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Техникийн албаныхан бэлэн биш байсан байна, санал хураалтад.

Байнгын хорооны саналаар Наранчулууны Отгончимэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөхийг дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая.

1 хүн дэмжлээ. Санал дэмжигдсэнгүй.

Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөхийг дэмжихгүй гэсэн Хууль зүйн байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй



тул “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Наранчулууны Отгончимэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Баярлалаа. Отгончимэг гишүүнд амжилт хүсье.

14.35 цаг

Хэлэлцэх асуудал 5. Дараагийн асуудалд оръё.

**“Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Ж.Чинбүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын 24 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Байнгын хорооноос боловсруулсан Монгол Улсын Их Хурлын 24 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Тогтоолын төслийг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, итгэлцлийн зохистой дадлагыг хэрэгжүүлэх хүрээнд эмийн зохицуулалтын үнэлгээгээр ДЭМБ-аас хүлээн зөвшөөрсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, гаалийн болон татварын байгууллагатай мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлсний үндсэн дээр эм, эмнэлгийн эрсдэлийн цахим мэдээллийн санг хөтөлж, эмийн бодит үнийн мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй болгох, эмийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэхээр боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ тогтоолын төсөлд Эм, шинжилгээний лабораторийн чадамж, хүний нөөцийг бэхжүүлэх асуудал тусгагдсан эсэх, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын чиг үүргийн талаар, Түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд

хийсэн хяналт шалгалтын явцын төрийн байгууллага дахь эм, хангамжийн байгууллагын хамаарал, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд үүссэн байж болзошгүй хувийн ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг холбогдох хуулийн дагуу шалган иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх ажлын явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нар Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын 10 дугаар зүйлд заасан Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлахыг хориглох заалтын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн тогтоолын төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат хүний эмийн зөвлөл болон зарим зөвлөлийн шийдвэрийг иргэдэд ил тод, нээлттэй болгох талаар Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен сумын эмийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрыг стандартын шаардлага хангасан байртай болгох, эмийн хоруу чанарыг шалгах лабораторийн чанарт анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ тогтоолын төсөлд иргэд эмийн зохистой хэрэглээг сурталчлах, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, сургалтын тогтмол зохион байгуулалт заалт тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын үйл ажиллагааг цаашид үндэсний хэмжээнд явуулахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа ЭМД-ын сангийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай, даатгуулагчид ээлтэй, ил тод, нээлттэй удирдан зохион байгуулах талаар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын үйл ажиллагааг сайжруулах, сумдад шүдний эмчийн хүний нөөц дутагдалтай байгаа тул эмч бэлтгэх асуудлыг анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн

Баясгалан Монгол Улсад бүртгэлтэй зарим эм бусад улс оронд худалдаалагдаж байгаа эмийн үйлчлэлээс сул байдаг тул эмийн чанарт анхаарах, хүнд өвчтэй, эмийн өндөр хэрэглээтэй иргэдэд эмийн олдоц муу, эм бичүүлж авахад хүндрэл чирэгдэл ихтэй байгааг шийдвэрлэх талаар тус тус саналаа илэрхийллээ.

Байнгын хороо тогтоолын төслийг хэлэлцүүлгийн явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 73,6 хувийн саналаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

4 гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Энэ өдрийн мэнд хүргэе. Энэ эмийн асуудал бас л, арай л дэндүү байгаа. Түрүүний Бейсен гишүүний хөндсөн аптектай холбоотой, эмийн сантай холбоотой асуудал ч гэсэн бас маш хүнд байна. Сумдуудад. Булган аймгийн Дашинчилэн сумд явж байгаад ганцхан эмийн сантай. Эмийн сан нь түлхүүрээ олоогүй тохиолдол хүртэл байдаг. Бид нар энэ эмийн чанар дээр их

сайн анхаарахгүй бол үнэхээр гамшигийн түвшинд оччихсон юм шиг байгаа.

Монголд байгаа эм уугаад хэдэн удаа уугаад эдгээж байна, гадаадад очоод хэдэн удаа эм уугаад эдгээж байна гэдэг бас их өөр болчихсон юм байна лээ. Энэ эмийн лавлагаа лабораторитой холбоотой асуудлуудыг би хөндөөд байгаа юм. Бид нар өнөөдөр ямар эм ууж байна. Тэр эм маань чанартай юу, чанаргүй юу. Ялангуяа өнөөдөр бараг хүнснээсээ их эм авч уудаг болчихсон ийм цаг хугацаа туулж байна шүү дээ.

Энэ лабораторийн асуудал дээр хүний нөөцийн асуудал дээр их сайн анхаарахгүй манай ЭМЯ-ныхан байна уу, үгүй юу. Энэ ядаж 2025 ондоо багтаад энэ эмийн лавлагаа, лаборатори, тэр хүнсний лавлагаа лабораторийг болохгүй бол нэгтгэдэг юм уу, яах ёстой юм. Нэг тодорхой, дорвитой шийдвэртэй арга хэмжээнүүдийг авч өгөхгүй бол энэ эмийн чанартай холбоотой асуудал маш хүндээр тусаж байна. Эмээ уугаад бараг тэрнээсээ хордоод, дараагийн түвшний дараагийн эмээ уудаг энэ хэлбэр лүү хүртэл орж байгаа тохиолдлууд байна.

Тэгээд энэ эмийн лавлагаа лабораторитой холбоотой асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна. Болдог бол тэр хүнсний лавлагаа лабораторитой нийлүүлдэг юм уу, урвалжийг тодорхой зохистой арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Нөгөөдөх нь эмийн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын зохицуулалтын газар гэж нэг учир нь ойлгогдохгүй. Дарга, цэрэг байнга сольж байдаг. Байнгын түрээсийн байрандаа ажиллаж байдаг нэг ийм газартай болсон. Олон жил энэ газрын дарга нартай холбоотой, удирдлагуудтай холбоотой асуудлууд хөндөгддөг. Үеийн үед тэр асуудлууд тэгээд л дарагдаад өнгөрдөг. Ийм хэлбэр дээр л байгаа.

Тэгэхээр энэ эмнэлэгт Эм, эмнэлгийн хяналт зохицуулалтын газрыг бас ер нь нэг тийш нь шийдвэрлэх дээр манай ЭМЯ ямар бодлого, ямар шийдвэртэй явж байгаа юм бол гэдэг ийм асуулт асуух гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн хариулна.

**Ж.Чинбүрэн:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. ЭМЯ нь эмийн агентлагтай холбоотой асуудал хариулах байх. Яг одоо жишээлбэл сумын эмнэлгийг дурдаж байгаад эмийн чанарын тухай ярилаа.

Тэгэхээр өнөөдөр бид Монгол Улсад 1 чанартай эмийг эх орондоо өвдсөн зовсон хүн болгон хэрэглэдэг байх ёстой. Тэгэхэд зарим газар нь дэндүү хямд үнэтэй эм борлуулах зарах, эс үгүй бол алслагдсан гэдгээр нь үнийг нь нэмээд, хүртээмжийг нь өвдөнд өвдсөн хүнд эм нь очихгүй, худалдаж авах боломжгүй байх ийм нөхцөлийг бүрдүүлж байгаа энэ тогтолцоог бид эвдэж өгөхгүй бол болохгүй.

Та зөв юм хөндлөө. Яагаад сумдаа хамгийн сайн эмийг авч болох вэ гэж, яагаад тэр сумаас эмээ авах гэж заавал тэр эмийн аптека нь, одоо тэр эмийн сумын эмийн аптекийн эзэмшил нь маш олон янз. Нэг нь сумын засаг даргын мэдлийн, нэг бол бүр аймгийн, эсвэл хувь хүний, эс үгүй бол сумын ЭМТ-ийн харьяа ч гэдэг юм уу. Ерөөсөө үйл ажиллагаа нь ойлгомжгүй, дур дураараа.

Тийм учраас энэ нь тогтолцоо өөрөө их маш их эвдрэлтэй байгаа учраас үүнийг бид янзлах ёстой. Тэр ч утгаараа бид энэ Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулаад, өнөөдөр 10 сарын ,1-нд энэ хууль хэрэгжиж эхлэх гэж байна. Одоо хэрэгжиж эхлэхдээ бид маш олон зүйлүүдийг энэ тогтолцоонуудыг янзалж өгсөн. Жишээлэх юм бол та ярьж байна.

Эмийн чанарыг шалгаж байгаа Үндэсний лавлагаа лабораторийн асуудал яригдаж байна. Тийм ээ. Тэгтэл бид тэр эмийн сонсгол дээр нэлээн тодорхой ярьж өгсөн шүү дээ. 3 чухал аппаратынх нь 2 нь эвдэрхий музей шиг байж байна гээд.

Тэгвэл өнөөдөр бид Засгийн газар энэ эмийн лавлагаа лабораторийг ямар удирдлагын түвшинд, ямар шатанд авч явах юм бэ? Тоног төхөөрөмжүүд нь яаж байх ёстой юм. Жишээлэх юм бол ГЕГ боомт болгон дээр ямар гоё барилга барьчихсан лабораториудтай байж байна. Тэр лаборатори болгон үнэтэй үнэтэй тоног төхөөрөмжтэй. Харамсалтай нь ажиллах боловсон хүчин байхгүй.

Тэгээд хүнсээ ч шалгана, эмээ ч шалгах ёстой. Тэгвэл энэ нэг дээвэр доор таны хэлж байгаа саналаар би бол бүр зориуд эмийн лаборатори хүнсний чанарыг шалгадаг лаборатори хоёр 1 удирдлагатай, нэг дээвэр доор, эмийн агентлаг доороо, тэгээд ингээд үйл ажиллагаагаа шалгаад, чанарыг нь үзээд, хянаад, нэг удирдлага доор байвал 1-т, боловсон хүчин хүрэлцээтэй. Олон үнэтэй тоног төхөөрөмжүүдээ аваад байхгүй. Хоорондоо хувааж хэрэглэх боломжтой. 3-д, урвалж бодисоо авах гээд бүх лаборатори тус тусдаа тендер зарлаад, баахан үнэтэй юм авдаг биш, улсын хэмжээнд нэгдсэн тендер зарлаад, урвалжаа аваад ингээд явбал энэ нь илүү ухаалаг, эдийн засгийн хувьд хэмнэлттэй, мэдээллээ хуваалцах ийм боломжтой ийм тогтолцоо болох юм гэж харж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Энэ Чинбүрэн гишүүний санаачлаад, бас энэ Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлээд орж ирж байгаа энэ тогтоолыг хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг өнөөдөр ингээд Засгийн газар луу өгөхөөр болж байгаа юм. Үүнийг бас олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр өгөхөд чанартай эмийг Монгол Улсад нэвтрүүлж, хэрэглэдэг болох тэр боломжийг ард иргэддээ нээж өгөх юм л гэж ойлгох хэрэгтэй байгаа юм.

Хуучин чинь 90-ээд онд бол гадагшаа явж байгаа хүнд бохь захидаг байсан бол одоо гадагшаа явж байгаа хүнд чанартай эм захидаг болчихсон. Тэр чанартай эмийг Монголын зах зээл дээр худалдан борлуулах эрхийг нь олгоё гэхээр тэр эмийн лобби хэсэг чинь үндсэндээ орж ирэх нөхцөлийг нь үндсэндээ хязгаарлачихдаг. Монгол Улсын стандарт гэж зүйл гаргаж ирчхээд, тэрийгээ өмнөө бариад явж байдаг.

Тэгвэл энэ өндөр хөгжилтэй улс орон буюу Япон, Солонгос, Сингапур зэрэг улсын эрүүл мэндийн баталгаажуулалтын байгууллагаас албан ёсны гэрчилгээ авсан эмийг Монголын зах зээл дээр худалдаалах, борлуулах тэр боломж нөхцөлийг нээж өгөх гэж байгаа л ийм л зорилготой тогтоол явж байгаа.

Тэгэхээр үүнийг Засгийн газарт үүрэг, чиглэлийг өгөөд явах юм байна гэж ойлгож байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан асуултаа асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Чанаргүй эм орж ирээд, борлуулдгийг бараг бүгдээрээ мэднэ дээ. Бие дээрээ туриччихсан хүмүүс зөндөө байгаа. Энэ танхимд сууж байгаа хүмүүс ч байгаа.

Тэгээд энэ тухай ярьдаггүй. Яагаад ярьдаггүй вэ. Яагаад энд шийдэл хийдэггүй вэ гэхээр энэ ерөөсөө эмийн мафи л Монголд үүсчихсэн юм байна лээ л дээ.

Би өмнө нь энэ талаар сэтгүүлч байхдаа удаа дараа цуврал нэвтрүүлэг хөндөж байсан боловч, цагаан халаад өмссөн эмч хүн өөрийг чинь эмнэлэгт ирж өвдөхгүй байхыг харна гэж заналхийлж байсан тохиолдол бий. Энэ бол чанарын шаардлага хангаагүй эм.

Нөгөө дээрээс нь Чинбүрэн гишүүн ээ, үнэхээр зайлишгүй хэрэгтэй, хүнд өвчний дараа уудаг эмийг оруулж ирэх зөвшөөрөл байдаггүй юм байна лээ шүү

дээ. Тэгээд манай эмч нар тэрийг бичдэг. Тэгэнгүүт тэр нь ингээд нууцаар ороод ирээд гараас гар дамжаад, тэрнээс утасдаад, тэдэн номер луу яриад авчхаарай гэдэг тохиолдол зөндөө байгаа. Энэ эм үнэхээр шаардлагатай, манай эмч нар уу гэж байгаа бол улсад наашаа оруулж ирэх эмийн жагсаалтад оруулж яагаад болдоггүй юм. Энэ дээр яг тэр гол мафи чинь ажиллаад байгаа юм биш үү? Хуурамч эм бол бүр утгаа алдчихсан.

Тэгэхээр энэ шаардлагатай иргэдэд хэрэгтэй байгаа эмийг яагаад оруулж ирэх эмийн жагсаалтад оруулдаггүй юм. Энэ тал дээр хариулт өгч, энэ тал дээр бас сайн ажиллах хэрэгтэй байна.

Дээрээс нь эмнэлгийн хэрэгслүүд, тоног төхөөрөмж энэ бас мафижчихсан. Ерөөсөө энэ хэдэн том эмнэлэгт ажиллаж байгаа эмч нар, эндээс тэтгэвэр авсан эмч нарын компаниуд л оруулж ирдэг. Тэрийг бас л бүгдээрээ мэддэг. Тэгэхдээ дуугардаггүй. Монгол хүн нэг эмч, лам 2-ын өмнөөс дуугардаггүй нэг тийм юутай юм шиг байгаа юм.

Тэгээд эмч юу гэж хэлнэ вэ, яг түүгээр нь байж байдаг. Үүнийг би өөрөө биеэр туулсан хүний хувьд мэдэж байна. Тэгээд энэ тал дээр яг ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Хуурамч эмийг цэгцэлж болно. Гол нь Монголд оруулж ирэх эмийн тоог нэмж, яг тэр шаардлагатай эмийг оруулж ирмээр байна.

Хүнд хагалгааны дараа эмээ авч чаддаггүй. Тэр нь үнэтэй. Монголд оруулж ирэхэд нь зөвшөөрөгдөөгүй учраас иргэд гадагшаа явах дээрээ хүртэл түлж байгаа. Байгаа байшин, байраа ломбардад тавиад л явж байгаа энэ цуваа тасрахгүй байгаа. Энэ тал дээр бас ямар арга хэмжээ авах вэ? Ингээд 3 асуулт байлаа. Хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн хариулт өгье.

**Ж.Чинбүрэн:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Нөгөө шаардлагатай өвчин намдаагч гэдэг юм уу, эс үгүй бол шинэ технологид нэвтэрсэн шинэ эмүүд ч гэдэг юм уу, бүртгэл байхгүй. Тэрийг бүртгүүлэх гэж 6-12 сар хүлээдэг. Бүртгүүлчхээд чанарыг нь шалгуулна гээд лабораторид шинжлүүлдэг. Лавлагаа лабораторид. Энэ бүх процесс өөрөө эмийн сонсгол хийж байхад энэ ерөөсөө л брьюкорад систем буюу зориудаар тэр эмийн зах зээлдээ бусдыг оруулахгүй байх энэ хориг тавьдаг ийм том технологи. Бүр ингээд нутагшигчсан.

Тэгэхээр бид нарын энэ тогтоол, одоо та бүгдийн батлах гэж байгаа энэ тогтоол дээр бид юуг оруулж байна вэ гэхээр ДЭМБ-ын зөвшөөрөгдсөн өндөр хөгжилтэй оронд хэрэглэхийг зөвшөөрсөн эмийг бид хялбаршуулсан аргаар Монгол Улсад шууд оруулах боломжийг нь бүрдүүлэх гэж байгаа. Нэг ёсондоо дахиж бүртгүүлэхгүй, дахиж лабораторид очоод энэ тоёота машин чанар нь хэр байна вэ шалгаадах гэдгээ болих гэж байгаа юм.

Тэгэхдээ яах вэ, бид бас нэг зарим муу тохиолдол мэднэ шүү дээ. Ногоон автобус мэтийн хулгай энэ тэр бол мэднэ. Гэхдээ энэ яах ёстой вэ гэхээр энэ процесс яаж хийгдэх вэ гэхээр ЭМЯ Засгийн газрыг төлөөлөөд тухайн улс орны ЭМЯ-тай нь, эмийн агентлагтай нь хамт ажиллах гэрээгээ байгуулаад, тэр гэрээний дагуу ГЕГ дээр тухайн орны хэрэглэдэг эмүүдийн жагсаалтыг рийл тайм буюу иууд онлайнар харж байна. Тусгай зөвшөөрөлтэй эмийн компани тэр эмийг оруулж ирэхэд одоо таны дурдаад байгаа Монголд бүртгэлгүй эмийг жишиээлбэл би ойрхноор нь Солонгос гээд ярьчихъя л даа. Энэ чинь ганцхан Солонгос гэж байгаа зүйл биш шүү. БНСУ-д хэрэглэдэг тэр эмийг Монголд бүртгэлгүй байлаа ч гэсэн бүртгэлтэйгээр, хэрвээ Засгийн газар гэрээ хийгээд, эмийн агентлагууд нь мэдээллээ солилчихсон

бол гаалиар нэвтрүүлнэ. Нэг ёсондоо сайн эмийг бид хэрэглэдэг болно гэсэн үг.

Дээрээс нь тэр эмийг Монголд бүртгэх гэж янз бүрийн авлига, хээл хахууль өгөх шаардлагагүй. Эсвэл цаг алдахгүй. Дээрээс нь лабораторид шинжлүүлэх гээд хамаг их мөнгөө үрээд, дээрээс нь өртөг нь нэмэгдээд, Монгол иргэдийн гар дээр үнэтэй биш болгож оруулах хамгийн шулуухан арга энэ юм байна гэдгийг бас ДЭМБ зөвлөөд байгаа учраас бид энэ хуульдаа оруулсан. Одоо үүнийг хурдан хийгээрэй гэж тогтоолдоо оруулж өгч байгаа юм.

Дараагийн асуудал бол гар дамжсан худалдаа нээрээ ноцтой асуудал шүү. Одоо энэ 10 сарын 01-нд хэрэгжих энэ хуулиараа бид бас нэлээн хатуу зохицуулалтууд хийж оруулж өгсөн. Жишээлбэл, эм болон эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг социал сүлжээгээр сурталчлах боломжгүй болж байгаа шүү дээ. Хэрвээ сурталчилсан байх юм бол та торгууль ноогдуулна, хариуцлага тооцно.

Харин жороор олгодоггүй эмүүдийг жишээлбэл, эрүүл мэндийн нэмэгдэл бүтээгдэхүүнийг юугаар сурталчилж болно. Телевиз, радио, дээрээс нь энэ хэвлэл мэдээлэл, веб сайтаар явуулах нь боломжтой. Харин нэг чухал зүйл заалт оруулсан бид идэвхжүүлэлтийг хориглосон. 1 ёсондоо эмч нар эм ... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя.

**М.Нарантуяа-Нара:** Эмийн чанар, үнийн асуудал яригдаж байна. Угаасаа яригдах ёстой. Одоо манай Монгол Улсад, ялангуяа Улаанбаатар, нийслэл Улаанбаатар хотод байр болгоны буланд аптек байгаа. Тэгээд байр болгоны буланд аптек байна. Си Ю байна. Энэ 2 л хамгийн их ийм байна шүү дээ. Ерөөсөө эмийн сүлжээ бол бүр тэр чигтээ бизнес болсон.

Дээрээс нь эм ханган нийлүүлэх байгууллагууд яг үнэндээ ард иргэд ч гэсэн ярьдаг шүү дээ, дандаа ярьдаг. Юу гэж ярьдаг гэхээр зэрэг эм ханган нийлүүлэхийн энэ тусгай зөвшөөрөл хэнд гардаг юм, зүгээр нэг жирийн иргэн хүн гүйж очоод энэ зөвшөөрлийг авъя гээд авчихдаггүй юм байна лээ. Маш олон шалгууртай, маш олон хүнд сурталтай, маш олон ийм шатлалтай.

Тэгэхээр энэ ихэвчлэн би одоогийн төр засгийн тухайд яриагүй. Өмнөх, өмнөх, өмнөх, сүүлийн 30 жилийн хугацаанд энэ төр засаг, парламент юу байдаг юм энэ төрийн холбоо хамаарлаар тийм ээ, энэ эрүүл мэндийн юугаар ингээд сүлжээгээр ингээд ихэвчлэн энэ төр засгийн холбоо хамааралтай хүмүүс авдаг гэсэн ийм шум иргэдийн дунд байдаг. Би ч гэсэн үүнийг бас хардаж боддог.

Тэгэхээр энэ тусгай зөвшөөрөл олгоод байна. Тусгай зөвшөөрлийг жишээлбэл энгийн иргэн хүн зүгээр нэг яг ингээд үнэхээр нэг бизнес эрхэлчихье тийм ээ, эмийн бизнес эрхэлчихье гэсэн сайн эм оруулья гэсэн тийм хүнд үнэхээр олгогдож чадахгүй байгаа. Одоо энэ нэг асуудал яригдаж байна.

Сошиалаар энэ хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон эмийн бүтээгдэхүүнийг сурталчлахыг хориглоод, телевизээр. Тэгвэл телевизээр гарч байгаа киноны дундуур гарч байгаа 10 реклам зар сурталчилгааны 7, 8 нь эм, эмийн бүтээгдэхүүний зар сурталчилгаа байгаа.

Тэгээд энэ нөгөө чөлөөт өрсөлдөөнийг бас энд хязгаарлаж байгаа үзэгдэл мөн шүү дээ. Иргэд өнөөдөр телевиз үздэг хэдэн иргэд байна. Сошиалаас шууд мэдээллээ авдаг хэдэн иргэд байна. Тэгэхээр энэ нөгөө өөрөөр хэлбэл мэдээллээр хангагдах, мэдээлэл авах энэ эх үүсвэрийг бас боомилж байгаа асуудал гэж би хувьдаа харж байна.

Дээрээс нь эмийн чанарт одоо ялангуяа энэ үр хөндөлтийн эмийг ямар

чанарын эмийг хаанаас тийм ээ. Одоо манай Монголд дандаа хамгийн хямдхан, үйлчилгээ муутай ийм эм орж ирдэг нь үнэн. Өнөөдөр энэ эмийн ялангуяа үр хөндөлтийн эмийн асуудлаас болоод өнөөдөр маш олон үргүйдлийн тухай асуудлууд ч гэсэн хөвөрч байдаг байж магадгүй гэж би хувьдаа бодоод д байгаа юм.

Тэгэхээр энэ жишээлбэл ингээд л нэг юмыг ингээд хорьчихож бас болно л доо. Тэгэхдээ тэнд үүсэх үр дагавар нь ямар байх вэ гэдгээ судалгаагаар бас судалж байж, үүнийгээ гаргаж байх ёстой юм шиг би хувьдаа бодоод л байна. Тийм. Одоо тэгээд ямар ч л байсан сошиалаар энэ хүнсний нэмэлт бүтээгдэхүүн. Тэгэхээр яах вэ, иргэд өөрсдөө судалж байгаад аягүй сайн хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, эм, эмийн бүтээгдэхүүн өөрсдийнхөө туулсан, үзсэн, зовсон энэ юун дээрээ туршилага дээрээсээ үндэслээд дэлхийн улс орнуудаас хамгийн сайн бүтээгдэхүүнүүдийг нь оруулаад ирдэг. Нэвтрүүлэг хийдэг. Тэгээд л тусгай зөвшөөрөл дээрээ очоод л бүх юм унадаг шүү дээ.

Тэгэхээр энэ тусгай зөвшөөрлийг олгож байгаа эрх бүхий байгууллага өөрөө үнэхээр авлига, хээл хахуулийн шинж чанаргүй ажиллаж чадаж байгаа юу гэдэг дээр бас хариулт өгөөрэй гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн хариулъя.

**Ж.Чинбүрэн:** Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Ер нь жижиглэнгийн худалдаа, аптекууд булан бүрд бий болсон үнэн. Энэ бол бид том зохицуулалт байсан хуулийн зохицуулалтыг байхгүй болгосонтой холбоотой.

Дээрээс нь эмийн борлуулалт нь өөрөө ашигтай байгаа. Зах зээлийнхээ

жамаараа ашигтай байгаа учраас л энэ олон эмийн сангууд ажиллаад байгаа юм.

Шинэ хууль дээр эдгээр зохицуулалтууд орж байгаа.

Үнийн хувьд ярих юм бол өнөөдөр энэ тогтоолд орж байгаа та бидний батлах гэж байгаа зүйл дотор нэг чухал зүйл орж байгаа. Энэ бол эмийн зохицуулалтыг, эмийн хяналтыг ард түмэнд өөрт нь олгож байгаа юм. Нэг ёсондоо гааль дээр бөөний үнээр авчирсан эмээ хайрцаг, ширхэг, ампулынх нь үнээр мэдүүлнэ. Тэр мэдүүлсэн үнээрээ иргэн аптека дээр очиж худалдаж авахдаа QR кодыг нь уншуулаад гар утсан дээрээ 2 товч дараад л ямар үнэтэй эмийг би ямар үнээр жижиглэнгээр авч байгаа гэдгээ харах боломжийг оруулж өгч байгаа нь энэ ард иргэдийн хяналтад үнийн өсөлтийг шууд оруулж байгаа хамгийн шилдэг арга гэж харж байгаа учраас үүнийг яаралтай хийгээрэй гэдэг ийм үүрэгжүүлж байгаа юм.

Дараагийн асуудлаа энэ хуульд юугаар, сүлжээгээр олон нийтийн сүлжээгээр дамжуулах нь буруу юу, зөв үү гэдэг асуудал ярьж байх шиг байна. Фэйсбүүк, твиттер ч байна уу, олон нийтийн энэ сүлжээг дамжуулаад иргэн хүн өөрөө хуулийн хариуцлага хүлээх тэр эрх зүйн акт нь ойлгомжгүй. Та худлаа яриад, худлаа сурталчлаад эм өгчихсөн байдаг. Нийлмэл бүтээгдэхүүн бүр ялангуяа энэ витамин, энэ эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг чинь бараг л хорт хавдрыг устгачихдаг гэж яриад л бие биедээ өгөөд байгаа шүү дээ. Ямар ч нотолгоо байхгүй, ямар ч хариуцлага байхгүй.

Тэгээд олон нийтийн сүлжээний нэг сул тал нь шэйрлээд олон нийтэд хэн нь юу тараагаад байгаа нь мэдэгдэхгүйгээр түгээчихдэг учраас бид хуулийн ажлын хэсэг дээр энэ үнэхээр болохгүй байна гэдгийг яасан юм шүү. Тухайлах юм бол зарим өвчтэй улсуудын групп байна. Би энэ эмийг уугаад зүгээр болчихсон юм, одоо та энийг уугаарай

гээд л. Хавдар чинь дотроо олон янз. Нэг төрлийн хавдар хүртэл эмчилгээ нь өөр өөр байхгүй юу. Тэгтэл манайхан ийм сайн санааны төөрөгдлөөр хүмүүст туслах гэж байгаа нэрийдлээр хүнд хор болдог юм шүү.

Тийм учраас эрүүл мэндийн энэ бизнес ашиг олдог бизнес биш. Энэ тусгай бүтээгдэхүүн. Тийм учраас иргэд минь тун анхааралтай үүнийг хэрэглэнэ шүү. Та бүгдийн анхаарал сэрэмж маш чухал.

Тэгээд л хэлсэнд нь итгээд л, тэгээд л юу ч хамаагүй идэж болно. Хорт хавдар эдгээд гээд л элээний элэг идчих гээд л баахан элээ буудаад элэг авчраад л өгөөд л. Тэгээд үндсэн эмчилгээнээс нь төөрүүлж, холдуулаад л. Энэ болохгүй. Энэ ноцтой асуудал.

Тийм учраас ийм бизнесийг Монгол Улс зөвшөөрч болохгүй. Зохицуулалттай байх ёстой. Хяналттай байх ёстой.

**Д.Амарбаясгалан:** Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуултаа асууя.

**Н.Батсүмбэрэл:** Энэ өмнө нь эмийн сонсгол хийгээд байсан санагдаад байгаа. Чинбүрэн гишүүн байсан байх. Тэгэхээр тэр эмийн сонсгол хэр үр дүнтэй болсон юм. Тэр эмийн сонсголоор ямар зөрчил илэрсэн юм, тэрийгээ яаж шийдсэн юм, ямар бодитой үр дүн гарсан юм гэдгийг нэг ...

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооноос оруулж ирсэн санал, дүгнэлттэй холбоотойгоор асуулт асууж, хариулт өгөх дэгтэй.

Бейсен гишүүн асуулт асуух хүсэлт тавьсан байгаа. Түрүүн кнопоо дарж амжаагүй гээд.

Тэгэхээр Бейсен гишүүн асуултаа асууя.

**Б.Бейсен:** Энэ түрүүн бас гишүүд ярьж байна. Энэ эмийн үнийн асуудал үнэхээр өндөр байна. Сум, багийн

түвшинд бүр өндөр үнэтэй. Тэгээд эмийн чанаргүй эм сум, багт л очдог.

Тэгэхээр энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн газар, ЭМЯ энэ дээр анхаараад нэг бодлого боловсруулахгүй бол үнэхээр сум, багийн түвшиний юуг анхаараад л ямар төлөвлөгөө гаргадаг юм, тэр талаар ер нь баримталж байгаа бодлого бий юу? Ер нь ядахдаа явуулын, одоо сум бүгд юу нь өндөр хүчдэлтэй холбогдсон шүү дээ. Хөргөгчид хадгалах эмүүд байж байна, зарим нь.

Тэгэхээр энэ дээр ямар бодлого баримталж байна? Энэ талаар.

Дараагийн асуудал энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой эмийн үйлдвэрийн асуудал байж байна. Манайх эмийнхээ 70 хувийг импортоор авч байна. Дөнгөж 30 орчим хувийг дотооддоо үйлдвэрлэж байна. Витамин ганц 2 шингэн гэх мэтийн. Тэгэхээр энэ ядахдаа эмийнхээ 50 хувийг дотооддоо хангачихмаар эмийн үйлдвэр баримтлах талаар ЭМЯ Эм, эмнэлгийн эрсдэлийн газар энэ Засгийн газарт асуудал тавьж байгаа юу? Цаашидаа ямар төлөвлөгөөтэй байна?

Оношилгооны тоног төхөөрөмжийн хувьд энэ аймаг болгон дээр нь имра аппарат, сум болгонд рентген аппаратаар хангахгүй бол ангиографийн аппарат ч юм уу, энэ хот руу ирэх ачаалал ер нь багасахгүй юм шиг байна. Энэ талаараа Засгийн газар бас сая гишүүд маань бас анхаараад бүгдээрээ хөдөө аймгуудаас сонгогдсон. Жишээлбэл хугаралтай улсууд байж байна, хатгаа байж байна. Манайх чинь эрс тэс хүйтэн уур амьсгалд орон. Энэ дээр ямар бодлого байна.

Ер нь тоног төхөөрөмжийн хангалтын асуудал дээр Засгийн газар анхаарч байна уу. Эрүүл мэндийн сайд аа. Ер нь хамтарч ажиллая энэ талаар гэдгээ хэлье. Ер нь баримталж байгаа бодлого бий юу.



Нөгөө талаар хамгийн гол асуудал эмийн чанар, хоруу чанарыг шалгах баталгаат лаборатори маань бас тоног төхөөрөмжийн дутагдалтай. Эмч мэргэжилтнүүд чинь зарим нь мэдлэг мэргэжил нь хүрэхгүй байх шиг байгаа. Тэгэхдээ мэргэжлүүд байна л даа. Энэ талаар тоног төхөөрөмжөөр хангах, чадварлаг боловсон хүчнээр хангах тал дээр ямар бодлого баримталж байна. Энэ талаар асууя.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт өгөх үүрэгтэй.

Тийм учраас яах вэ, Бейсен гишүүний хөндөж байгаа сэдэв чухал. Энэ холбогдолтой асуудлыг дараа нь улсын төсөв хэлэлцэх үед Засгийн газар бодлогын түвшинд хариултаа өгөх нь зөв байх гэж бодож байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

66 гишүүн буюу 60 хувиар дэмжиж, тогтоол ...

Гантөмөр дарга төхөөрөмж яасан байна, саналаа өгч чадаагүй байна. Дэмжсэнээр протоколд. Батжаргал гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлж байна.

Тогтоолын төсөл батлагдсан. Би уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, итгэлцлийн зохистой дадлын хэрэгжүүлэх хүрээнд эмийн зохицуулалтын үнэлгээгээр ДЭМБ-аас хүлээн зөвшөөрсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах,

2. Гаалийн болон татварын байгууллагатай мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлсний үндсэн дээр эм, эмнэлгийн хэрэгслийн цахим мэдээллийн санг хөтөлж, эмийн бодит үнийн мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй болгох, чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслээр иргэдийг хангах хүртээмжийг нэмэгдүүлэх,

3. Эмийн аюулгүй байдал, хяналт, зохицуулалтын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар судлан санал танилцуулах.

Хоёр. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийн хамт 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын

Нийгмийн бодлогын байнгын хороонд даалгасугай.

Гурав. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

15.06 цаг

Дараагийн асуудалд оръё.

**“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа танилцуулна. Индэрт урьж байна.

**Ж.Баярмаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5, 45 дугаар зүйлд заасны дагуу “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж, 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцлээ.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль,

Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна гэж заасны дагуу хэлэлцэх асуудлын жагсаалтад 7 хууль, тогтоолын төслийг тусгасан болно.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байхаар зохицуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Засгийн газар, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад тус тус үүрэг болгосон болно.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Бат-Эрдэнэ.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. байнгын хорооны санал, дүгнэлттэй

холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байгаа.

Гэхдээ энэ нөгөө хэлэлцэх асуудал үндсэндээ өргөн баригдсан хуулиар хэлэлцэх ёстой асуудлууд нь өнөөдөр орж байгаа. Шинэ Улсын Их Хурал бүрдсэнтэй холбогдуулаад урьд нь өргөн баригдсан байсан хуулийн төслүүд, төсөл санаачлагчид бүгдээрээ буцсан байгаа.

Тэгэхээр тэдгээр асуудлуудыг нэмж шинээр өргөн бариад, өргөн барьсан цаг хугацаа болгонд нь дэгийн тухай хуулийн 5.7 дахь заалтын дагуу тухай бүрд нь Төрийн байгуулалтын байнгын хороо авч хэлэлцээд, хэлэлцэх жагсаалтад нэмээд яваад байх юм. Тэгэхээр гишүүд нөгөө асуулт асуухдаа, үг хэлэхдээ тэр хууль алга байна, энэ хууль яачхав гэдэг асуулт явах шаардлагагүй гэсэн үг.

Тэдгээр хуулийн төслүүдийг ахиж өргөн мэдүүлээд тухай бүрд нь Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэх асуудалд нь нэмж оруулаад явах юм гэдгийг бас урьдчилаад тайлбар хэлчихье.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгөхийг хүсье. Алга байна.

Тийм учраас асуулт дууслаа.

Ингээд “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

61 гишүүн буюу 55,5 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй.

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төсөл,

3. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

4. Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

5. “Монгол Улсын Их Хурлын 2024-өөс 28 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

6. “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах, нарийвчилсан журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

7. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд

өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байхаар тогтоосугай.

Гурав. Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад тус тус үүрэг болгосугай.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

15.13 цаг

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан **хууль, тогтоолын эцсийн найруулгуудтай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу Байнгын хороод хууль, тогтоолын төслийн эцсийн найруулгыг бэлтгэж танилцуулахад бэлэн болсон байна.**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

### **Хамт өргөн мэдүүлсэн:**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3. Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцно.

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

### **Дагалдан гарсан:**

Төр. хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох

тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

8. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

9. Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11. “Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Энэ дээр Алтангэрэл сайдаас тодруулах нэг зүйл байна. Уянгахишиг гишүүн асуудал хөндсөн “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн 27 хувийг иргэн, аж ахуйн нэгж эзэмшиж байгаа. Тэгтэл “Эрдэнэс тавантолгой”-н охин компани болох Таван толгой түлшийг улсын өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн саналыг авахгүйгээр Улсын Их Хурал шийдвэрлэж байгаа байдал нь Компанийн тухай хуулийг зөрчих нөхцөл бүрдээж байна уу, бүрдэхгүй байна уу?

Хэрвээ бүрдээж байна гэж үзэх юм бол өнөөдөр эцсийн найруулгыг сонссонд тооцохгүйгээр намрын чуулган хүртэл хойшлуулаад, намрын чуулганаас өмнө

“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийж, зөвшөөрлийг авсны үндсэн дээр энэ эцсийн найруулгыг сонссонд тооцох ёстой.

Тэгэхээр энэ дээр ямар асуудал байна? Тийм.

Энэ дээр Алтангэрэл сайд Хууль зүйн сайд нэг тайлбар өгөөч.

**О.Алтангэрэл:** Компанийн тухай хуульд зааснаар төр өөрийнхөө өмчлөлийн хувьцааны хувь заяаг шийдэж байгаа дкл өөрийнхөө өмчлөл тодорхой. Одоо энэ чинь Эрдэнэс тавантолгой дээр төрийн өмчийн хувьцаа гэж ярьж байгаа.

Дахиад тэр Таван толгой түлшнийхээ өөрийнх нь асуудлыг шийдээгүй хувьцааныхаа асуудлыг шийдэж байгаа бол би хойшлуулж байгаад, хурлыг нь хуралдуулах л зөв болов уу л гэсэн саналтай байна.

**Д.Амарбаясгалан:** Тэгвэл тогтоол батлагдсан. Тогтоол батлагдсантай холбогдоод Учрал сайд Засгийн газар I дүгээрт, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж, санал авах процессыг хийх ёстой. Үүнийгээ хийсний үндсэн дээр төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх процессыг эхлүүл.

Энэ дээр ямар нэгэн байдлаар шалтаг тоочоод Улсын Их Хурал ёсчлоогүй учраас агаарын бохирдол нэмэгдсэн мэтээр асуудал ярихыг Улсын Их Хуралд хүлээн зөвшөөрөхгүй. Улсын Их Хурал хуульд нийцүүлсэн үйл ажиллагаа явуулах гэж байгаа гэдгийг ойлгож, Засгийн газар алдаатай процесс явуулахгүй байхыг хүсье.

Тэгэхээр эцсийн найруулгыг намрын чуулган хүртэл хойшлууллаа.

Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Үгүй ээ, энэ заяагдмал баялгийнхаа тодорхой хэсгийг иргэддээ, бид хувьцаа хэлбэр олгосон.

Түүнтэй энэ асуудал зөрчигдөхгүй шүү дээ. Ер нь яг үндсэндээ Тавантолгой түлшний хөрөнгө өөрөө энэ иргэдийн хувьцаанд үнэлэгдэж нөлөө үзүүлэх юм байхгүй шүү дээ.

Тийм учраас бид иргэддээ 1072 хувьцаа л эзэмшүүлсэн. Түүнд нь бид халдаагүй байна. Тийм учраас энд ямарваа нэгэн тийм зөрчил гарах үндэслэл байхгүй шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Алтангэрэл сайд хариулъя.

**О.Алтангэрэл:** Тэр иргэдийн эзэмшиж байгаа 1072 хувьцаанд хохирол учрах эсэхийг бид нар энд шууд хэлж, шийдэж болохгүй л дээ. Тэр өөрсдөд нь хохирол учрах эсэх дээр эрх зүйн хамгаалалт авах, үзэл бодлоо илэрхийлэх тэр боломжийг нь олгох гэж л хуулийн зохих зохицуулалт байдаг учраас энэ боломжийг олгох нь зүйтэй л гэж.

Хохирол учрахгүй байж бас бодитоор магадгүй. Тэгэхдээ бид энд субъективээр үнэлж болохгүй л гэж.

**Д.Амарбаясгалан:** Тийм. Тэгэхээр яах вэ, бид зүгээр Улсын Их Хурал тогтоолоо баталчихсан шүү дээ. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлж өгөх нь зөв гээд шийдчихсэн.

Эцсийн найруулгыг сонсохоос өмнө Компанийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг хэрэгжүүлэх үүднээс энэ процессыг зайлигүй явуулах ёстой. Их Хурал хуулийн зөрчилтэй эцсийн шийдвэрийг гаргах нь зохимжгүй юм л гэдэг ийм байр суурийг гишүүд хэлээд байгаа юм.

Тийм учраас би бас Хууль зүйн сайдаас тодруулж асуулаа. Намрын чуулганаар ...

Цогтбаатар дарга. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

**Д.Цогтбаатар:** Энэ юуг, энэ чинь компанийн засаглалын тухай асуудал ярьж байгаа болохоос биш зөвхөн төрийн өмчийн тухай яригдаагүй л дээ.

Тэгэхээр энэ өмчлөл нөгөө тийшээ шилжихэд хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ер нь яаж нөлөөлж болзошгүй вэ гэдгийг бид нар тооцож мэдэхгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нарын бодлоор төр төрдөө шилжүүлээд байгаа юм шиг боловч үүнээс засаглалд ямар өөрчлөлт орох вэ. Энэ тооцоонууд хэн ч хийж чадахгүй байгаа учраас хувьцаа эзэмшигчдэд нь тэр шийдвэрээ гаргах боломжийг нь олгоод, бид нар энд эрх зүйн тодорхойгүй байдал үүсчихсэн байгаа бол энд бид нар өнөөдөр хариултыг нь хайгаад ч шаардлагагүй. Оруулж ирж байгаа байгууллага нь өөрөө энэдээ бүх хариултаа бэлдээд оруулж ирэх ёстой байхгүй юу.

Тэгэхгүй бид нар тодорхойгүй юмандаа тодорхой л байж таараа гэж шийдвэр ёстой гаргаж болохгүй. Түүний оронд хүлээж байгаад л өдий болтол хүлээж болсон юм чинь хүлээж байгаад л шийдвэрээ гарга.

**Д.Амарбаясгалан:** Тэгье. Санал нэг байна. Энэ бас компанийн хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал явж байгаа. Яг Цогтбаатар гишүүнтэй санал 100 хувь нэг байна.

Тэгэхээр эцсийн найруулгыг намрын чуулганаар сонсоно. Тэр хүртэл Засгийн газар бэлтгэлээ ханга, процессоо явуул л гэсэн үг. Тийм ээ.

12. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

13. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна

уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

1. Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

#### **Холбогдуулан боловсруулсан:**

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

15.23 цаг

Дараагийн асуудалд оръё.

#### **Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулган. Хаалт.**

Монгол Улсын Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, нийт ард иргэд ээ, Монгол Улс Үндсэн хуульт ардчилсан парламентын засаглалд шилжсэн цагаас хойш Улсын Их Хурлын 33 дахь удаагийн ээлжит бус чуулганыг хуралдуулж байна.

Энэ удаагийн Их Хурлын ээлжит бус чуулган 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ажлын 12 өдөр чуулан хаалтаа хийж байна.

Чуулганы өдрүүдэд нэгдсэн хуралдаан нийт 7 удаа, хийгдэх хугацаандаа 39 асуудлыг хэлэлцэж, зохих шийдвэрүүдийг гаргалаа.

Мөн энэ хугацаанд Байнгын хороод 35 удаа, дэд хороо 3 удаа хуралдсан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхээ эдэллээ.

Хамтарсан Засгийн газар 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн МАН, АН, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг Улсын Их хурал нэн яаралтай хэлэлцэн баталлаа.

Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн үндсэн 4 бодлогын хүрээнд, 16 чиглэлийн 619 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсан байлаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт сүүлийн 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын реформыг цаг алдалгүй эхлүүлж, эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аж үйлдвэржилт, бүсчилсэн хөгжил, шинэ хотын бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийг тэлэх 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасан нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн амьдралд дэвшилтэт өөрчлөлтийг авчрах учиртай.

Хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зөвхөн 4 жилээр зогсохгүй, ирэх 10-20 жилийн хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын үндсэн чиглэл байх ёстой гэдгийг энэ удаагийн парламентын гишүүд чухалчлан үзэж шийдвэрээ гаргалаа.

Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй хамт төсвийн тодотгол өргөн баригдсан нь хууль тогтоох байгууллагын хяналтын чиг үүргийг тодотгосон үр дүнтэй хэлэлцүүлгийг өрнүүлж, парламентын гишүүн иргэдийнхээ жинхэнэ төлөөлөл байж, улс орныхоо хөгжлийг хурдасгах,

үндсэн зорилгынхоо төлөө өндөр ёс, зүйтэй, нээлттэй, мэргэжлийн байж хурдтай ажиллах ёстойг илэрхийллээ.

Шинээр байгуулагдсан парламентын анхны ээлжит бус чуулганаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүх Байнгын хороод Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж баталлаа.

2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785,9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний ашигтай гарсан боловч Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хангуулах, төсвийн тогтвортой байдал, хариуцлага, сахилга батыг сайжруулах нэн шаардлагатай байна.

Цаашид Засгийн газар Улсын Их Хурлаас баталсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, төрөөс хувийн хэвшилд олгож байгаа татаас урамшуулал, томоохон төслүүдийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, санхүүжих дүнгийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн алдагдал, засаглал, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр, авлагын асуудлыг цэгцлэх, ноогдох ашгаа төсөвт төвлөрүүлдэг байх, тусгай сангуудын үйл ажиллагааг сайжруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкнуудад байринуулан, алдсан асуудлыг судалж, хариуцлага тооцох, хохирлыг барагдуулах тал дээр үр дүнтэй ажиллах ёстой.

Мөн төрийн аудитын байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах, аудитын зөвлөмжийг

биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангаруулах нь чухал байна.

Нийгмийн болон нийгмийн олон бүлгийн төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй шинээр байгуулагдсан парламент анхны ээлжит бус чуулганаар төсвийн гүйцэтгэлийг хэлэлцсэн нь Улсын Их Хурлын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ажиллах чухал механизм болохыг илтгэлээ.

Улсын Их Хурал, Засгийн газар болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандахын сацуу үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг олон нийтийн хяналтад оруулах, төрийн бүтээмж, хариуцлагын тогтолцоог сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг анхаарч ажиллах шаардлагатай байна.

Чуулганаар эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш, шударга хүртээх, хуваарилах зорилгоор Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан төрөлжсөн сангууд болох Хуримтлалын, Ирээдүй өв сангийн, Хөгжлийн санд 2024 онд төвлөрүүлэн хуримтлуулах Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийг анх удаа баталлаа.

Улсын Их Хурал бол иргэдийн хүсэл зоригийг илэрхийлэгч байгууллага болохын хувьд парламентын үйл ажиллагаагаа бүхэлдээ төр улсын хөгжил, нийт олны амьдралын сайн сайхны төлөө чиглэсэн байх учиртай.

Тиймээс энэ удаагийн хуралдаанаар хэлэлцэгдэж, батлагдсан хөтөлбөр, хууль тогтоомжууд хүндээ хөгжлийн үр шимийг бодитой хүргэх, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг эрчимжүүлсэн.

Итгэл хүлээлгэсэн шинэ парламентын анхны ээлжит бус чуулган боллоо.



Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, манай парламентын өмнө Монгол Улсынхаа хууль, эрх зүйн орчныг 3 төгөлдөржилтийг бодит болгох өргөн цар хүрээтэй үйл хэрэг биднийг хүлээж байгааг ээлжит бус чуулганы нээлтийн өдөр илтгэсэн байгаа.

Тиймээс Улсын Их Хурлын гишүүд та бүхнээс санал аван дараах үндсэн 3 чиглэлд ажлын хэсгүүдийг байгуулж байна. Үүнд:

Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлж ажиллах чиглэлийн хүрээнд 22 ажлын хэсэг,

Хууль тогтоомжийг тодорхой, ойлгомжтой болгож, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгох чиглэлийн хүрээнд 6 ажлын хэсэг,

Нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргадаг болох чиглэлийн хүрээнд 24 ажлын хэсгийг тус тус байгуулж, Улсын Их Хурлын даргын захирамж гарч байна.

Та бүхэндээ ажлын амжилт хүсье.

Ээлжит бус чуулганы үйл ажиллагаа хаагдсаныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ